



АМРИТА НЭЭЛАКАНТАН

ХАВСРАЛТ 3: АЗИД ЗЭРЛЭГ АН АМЬТАНД ЭЭЛТЭЙ ШУГАМАН ДЭД БҮТЦИЙГ БАЙГУУЛАХАД ОДООГИЙН ЧАДАВХ БОЛОН СААД БЭРХШЭЭЛҮҮД

МЭДЭГДЭЛ: Энэхүү нийтлэлд илэрхийлсэн зохиогчийн үзэл бодол нь оролцогч талуудын өгсөн бэлэн мэдээлэлд тулгуурласан бөгөөд АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг эсвэл Америкийн Нэгдсэн Улсын засгийн газрын үзэл бодлыг тусгасан байх шаардлагагүй юм. Уг тайлан(гууд)-ын англи хувилбар нь албан ёсны хувилбар болно. Уг тайлангийн орчуулгын хувилбарыг хүсэлтийн дагуу өгнө.

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГС	I
УДИРТГАЛ	3
ХАМ СЭДВИЙН ТОВЧ УТГА: АЗИД ӨМНӨХ ЧАДАВХЫГ БИЙ БОЛГОХ	5
АРГА БАРИЛУУД	10
АЗИЙН ТҮВШНИЙ ЧАДАВХЫН ҮНЭЛГЭЭ	10
ҮНДЭСНИЙ ТҮВШНИЙ ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭНҮҮД	13
АЗИЙН ТҮВШНИЙ ҮР ДҮН БА ХЭЛЭЛЦҮҮЛЭГ	18
ЗАСГИЙН ГАЗАР БА АГЕНТЛАГ	18
ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУД (ОУСБ), ШУГАМАН ДЭД БҮТЦИЙН БУСАД	
САНХҮҮЖҮҮЛЭГЧИД	22
АЖ ҮЙЛДВЭРИЙН ХОЛБОО	27
ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУД	30
ҮНДЭСНИЙ ТӨВШНИЙ ҮР ДҮН, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ	36
LISA СУДАЛГААНЫ ХАРИУЛТУУДЫГ НЭГТГЭН ДҮГНЭХ НЬ	36
ШУГАМАН ДЭД БҮТЦИЙН НӨЛӨӨЛЛӨӨС ЗЭРЛЭГ АН АМЬТНЫГ ХАМГААЛАХ ХЭРЭГЦЭЭ	
ШААРДЛАГАД АНХААРАХ ҮНДСЭН АСУУДЛУУД, ОЙЛГОЛТУУД	36
ОДООГИЙН ЧАДАВХ БОЛОН ТҮҮНИЙ ТУХАЙ ОЙЛГОЛТ	37
ЧАДАВХ БОЛОН ТӨСЛИЙН ХӨГЖЛИЙН ПРОЦЕССЫН ЯВЦ ДАХЬ УДИРДЛАГА ЗОХИОН	
БАЙГУУЛАЛТ	40
WFLI-Д ТУЛГАРЧ БАЙГАА СААД БЭРХШЭЭЛҮҮД	44
ЧАДВАР, ЧАДАВХЫН ХЭРЭГСЭЛ	45
СУРГАЛТЫН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА БА ТОДОРХОЙЛСОН СЭДВҮҮД	47
ӨВӨРМӨЦ БҮРДҮҮЛЭГЧ БҮЛГҮҮДЭД ЗОРИУЛСАН ЧАДАВХЫН ДҮГНЭЛТ	49
УЛСЫН, ҮНДЭСНИЙ ТӨВШНИЙ ХЯНАЛТ	62
ЗЭРЛЭГ АН АМЬТНЫГ ХАМГААЛАХ ЦААШДЫН АРГА ХЭМЖЭЭНД ЧУХАЛ	
ҮҮРЭГТЭЙ ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, ХУУЛИУДЫН ТАЛААРХ ДҮГНЭЛТ	66
БАНГЛАДЕШ	66
ЭНЭТХЭГ	67
МОНГОЛ	69
НЕПАЛ	71
ТАЙЛАНД	72
ҮНДСЭН ОЛОЛТУУД	77
1. БҮРДҮҮЛЭГЧ ДӨРВӨН БҮЛГИЙН ОДООГИЙН ЧАДАВХ БОЛОН ИРЭЭДҮЙН ХЭРЭГЦЭЭ	
ШААРДЛАГЫН ТАЛААРХ ҮНДСЭН ДҮГНЭЛТҮҮД	77
2. БҮРДҮҮЛЭГЧ БҮЛГҮҮДИЙН ӨРГӨН ХҮРЭЭНИЙ ОРОЛЦООГ ШААРДСАН ӨРГӨН ХҮРЭЭТЭЙ	
ДҮГНЭЛТ	78
3. ШУГАМАН ДЭД БҮТЦИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨСЛҮҮДЭД ЗЭРЛЭГ АН АМЬТНЫ	
ХАМГААЛАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАРЧ БАЙГАА СААД БЭРХШЭЭЛИЙГ ҮНЭЛЭХ	
ДҮГНЭХ	78
4. ЦААШИД ЗЭРЛЭГ АН АМЬТНЫ ХАМГААЛЛЫН АРГА ХЭМЖЭЭНД ЧУХАЛ НӨЛӨӨТЭЙ ОЛОН	
УЛСЫН ХУУЛЬ, ҮНДЭСНИЙ ХУУЛИУДЫН ТАЛААРХ ДҮГНЭЛТИЙГ ТАНИЛЦУУЛАВ	79
5. ЭНЭТХЭГ, НЕПАЛЫН ТЭРАЙ БАЙГАЛИЙН НУМАН ТӨРХ БОЛ ХИЛ ДАМНАСАН ШУГАМАН	
ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН ГОЛ ЖИШЭЭ ЮМ.	79

ЗӨВЛӨМЖҮҮД	80
ТАЛАРХАЛ	82
ИШЛЭЛ МАТЕРИАЛУУД	83
ХАВСРАЛТУУД	86
ХАВСРАЛТ А: ТӨРӨЛ ЗҮЙЛ, ЭКОСИСТЕМ, БИОЛОГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛ, WFLI-ИЙН ХАМГААЛЛЫН ҮНДЭСНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖУУДЫГ ХАЙХ, ТОДОРХОЙЛОХ ECOLEX МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ТАНИЛЦУУЛГА	86
ХАВСРАЛТ В: БАЙГАЛЬ ХАМГААЛЛЫН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН АСУУМЖ БА ТЭМДЭГЛЭЛ	87
ХАВСРАЛТ С: АЗИД ДЭД БҮТЦИЙН ЗҮГЭЭС БИОЛОГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛД ЧИГЛЭСЭН НӨЛӨӨЛЛИЙГ ШИЙДВЭРЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АЖИЛЛАДАГ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН ТАЛААРХ ЦАХИМ СУДАЛГАА	90
ХАВСРАЛТ D: АЗИЙН (LISA) ШУГАМАН ДЭД БҮТЦИЙН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЧАДАВХЫН СУДАЛГААТАЙЛАН	93
ХАВСРАЛТ E: СУДАЛГААНЫ ХҮРЭЭНД ХОЛБОГДОХ	111
ХАВСРАЛТ F: БАНГЛАДЕШИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ХУУЛЬ	114
ХАВСРАЛТ G: ЭНЭТХЭГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТУХАЙ ХУУЛЬ	117
ХАВСРАЛТ H: МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ХУУЛЬ	119
ХАВСРАЛТ I: НЕПАЛЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ХУУЛЬ	123
ХАВСРАЛТ Ж: ТАЙЛАНДЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ХУУЛЬ	125

ЗУРГУУД

Зураг1: Аж Үйлдвэрийн Холбоодын Газар Зүйн Байрлал	29
Зураг2: Бага хурлуудын зохион байгуулагдаж байгаа байдал, шугаман дэд бүтцийн салбар бүрээр авч үзвэл	30
Зураг3: Төрийн бус байгууллагын судалгаанд хамрагдсан оролцогчдын байгаль хамгаалал, шугаман дэд бүтцийн үйл ажиллагааны хэрэгжилт, газар нутгийн байдлаар	31
Зураг4: Төрийн бус байгууллагуудаас авч хэрэгжүүлдэг шугаман дэд бүтцийн асуудлаар чадавхыг бий болгох арга хэмжээнүүд. а) Дотоод чадавхыг бий болгох б) Гадаад чадавхыг бий болгох. (Хөх өнгөтэй хэсгүүд нь 'тийм' гэсэн хариултыг илэрхийлнэ). Саарал тэмдэг нь 'үгүй' гэсэн хариултыг илэрхийлнэ.)	32
Зураг5: Төрийн бус байгууллагуудын судалгаанд оролцогчдын газар зайн тархалт	34
Зураг6: Шугаман дэд бүтцийн гол асуудлууд, улс орноор авч үзвэл	35
7Зураг: Дөрвөн бүрэлдэхүүн хэсгээс судалгаанд хамрагдагсдын өгсөн шалтгаан нь шугаман дэд бүтцийн зүгээс зэрлэг ан амьтдад үзүүлэх нөлөөллийг шийдвэрлэх шалтгаанууд юм.....	37
8Зураг: Түншлэгчдийн (баруун) төрлүүд тус бүртэй хамтран ажилладаг гэж мэдээлсэн бүрэлдэхүүн хэсэг бүрийн (зүүн) тус бүрээс асуумжид оролцогчид	39

9Зураг: бүрдүүлэгч дөрвөн бүлгийн үнэлгээгээр зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх түншүүдийн дундаж чадавх. Төр засгийн газар = улаан, ОУСБ= шар, аж үйлдвэр = хөх, төрийн бус байгууллага = ногоон өнгөөр тэмдэглэсэн. Чадавхыг 0-ээс (чадваргүй) 5 хүртэл (өндөр чадвартай) хүртэлх оноогоор дүгнэсэн. Цэг тэмдэгтүүд нь дундаж чадавхыг илэрхийлдэг, харин зурааснууд нь стандарт хэлбийлтийг илэрхийлдэг..... 40

Зураг10: Шугаман дэд бүтцийн төслийн хөгжлийн долоон үе шат тус бүрд судалгаанд оролцогчдын оролцоог бүрдүүлэгч бүлэг тус бүрээр авч үзэв 42

11Зураг: Зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээг шугаман дэд бүтцийн төслийн долоон үе шат тус бүрд хэрэгжүүлдэг, энэ нь төслийн бүх үе шатанд хариуцлагатай байдлаас шалтгаалдаг гэж үзэж байгаа оролцогчдын хувийг бүрдүүлэгч бүлэг тус бүрээр харуулав. "Авч үздэггүй" гэсэн хариулт нь судалгааны оролцогчид өөрийн бүх үйл ажиллагаандаа зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээг авч үздэггүй болохыг харуулна. Харин "Оролцдоггүй" гэсэн хариулт нь төслийн хөгжлийн явцад судалгааны оролцогчид оролцдоггүй болохыг илтгэнэ.. 43

Зураг12: Шугаман дэд бүтцийн төслийн үе шатанд зэрлэг ан амьтныг хамгаалахад саад бэрхшээл тулгардаг гэж үздэг оролцогчдын тоог бүрдүүлэгч бүлэг тус бүрээр авч үзэв..... 44

Зураг13: Энэхүү цацраг хэлбэрийн графикт саад бэрхшээлийн төрлүүд нь шугаман дэд бүтцийн төслүүдэд зэрлэг ан амьтныг хамгаалах үйл ажиллагаанд саад болдог гэдэгтэй санал нийлж байгаа оролцогчдын тоо, эзлэх хувийн дөрвөн бүрдүүлэгч бүлгээр нь харуулав. Олон нийтийн дэмжлэг түслалцаа дутмаг, санхүүжилт дутмаг, улс төрийн эрмэлзэл дутмаг зэрэг хариултуудын хувьд төрийн албан хаагчдын хариултын хувь хэмжээ нь төрийн бус ажилчдын хувь хэмжээтэй бараг ойролцоо байна. Иймээс графикийн зарим хэсэгт улбар шар зураас харагдахгүй байна..... 45

Зураг14: Төслийн хөгжлийн явцад зэрлэг ан амьтныг хамгаалах зорилгоор ашиг-алдагдлын дүн шинжилгээг авч хэрэгжүүлэх эсэх талаар бүрдүүлэгч дөрвөн бүлгийн хариултын хувь давтамж. 46

Зураг15: Зэрлэг ан амьтныг хамгаалах мэдээллийн эх үүсвэр, олон төрлийн мэдээллүүдийг ашиглахтай холбоотой бүрдүүлэгч дөрвөн бүлгийн хариултыг хувиар харуулсан байдал..... 47

Зураг16: (а) зэрлэг ан амьтны талаарх сургалтад баримтлах нэн тэргүүний механизм (b) зааварчилгаа, заавар өгөхөд чухал сэдвүүдийн талаар бүрдүүлэгч дөрвөн бүлгийн өгсөн хариултыг хувиар илэрхийлсэн цацраг хэлбэрийн график. 49

Зураг17: MEA-д хамаарах төр, засгийн газрын зорилго зорилтын талаар сүрч мэдэхийн тулд албан хаагчдын авах боломжтой чадавхыг бий болгох арга хэмжээний олон төрлүүдийг тодорхойлсон төр засгийн бүрдүүлэгч бүлгийн хариулагчдын тоо..... 50

Зураг18: (а) өөрийн байгууллага нь шугаман дэд бүтцийн зүгээс зэрлэг ан амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг хариуцдаг ажилтны чадавхын талаар (b) шугаман дэд бүтцийн зүгээс зэрлэг ан амьтанд үзүүлэх нөлөөллийг хариуцсан ажилтанд шаардлагатай чадварын талаар тодорхойлсон төр засгийн байгууллагаас оролцсон оролцогчдын тоо..... 51

19Зураг: Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хөгжилд янз бүрийн бүрдүүлэгч бүлгийн гүйцэтгэх үүргийг тодорхойлсон төр засгийн оролцогчдын хувь..... 53

20Зураг: Азийн шугаман дэд бүтцийн төсөлд хөнгөвчлөх шаталсан арга хэмжээнд хамгийн их ашигласан сонголт, аргыг тодорхойлсон ОУСБ бүрдүүлэгч бүлгийн оролцогчдын тоо..... 54

21Зураг: (a) дотооддоо чадавхыг бий болгох зорилгоор ОУСБ-ууд-ээс баталсан янз бүрийн арга хэмжээнүүд (P= биечлэн мөн PR= танхимын ба давтан), (b) гадаад түншүүдэд чадавхыг бий болгох зорилгоор ОУСБ-ууд-ээс баталсан арга хэмжээнүүд. 55

22Зураг: (a) Азийн шугаман дэд бүтцийн төслүүдийн сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор сүүлийн таван жилд авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд (b) Азийн шугаман дэд бүтцийн төслүүдийн нөлөөллөөс зэрлэг ан амьтныг хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд..... 57

23Зураг: Шугаман дэд бүтцийн зүгээс зэрлэг ан амьтныг хамгаалах тухай сургалтын үйл ажиллагаанд багтаах үндсэн асуудлуудын талаар төслийн төлөөллийн таван улс тус бүрд аж үйлдвэрийн салбарын бүрдүүлэгч бүлгийн гишүүдийн хариултын хувь хэмжээ (n=45)..... 58

Зураг24: Шугаман дэд бүтцийн төлөвлөгөө, төслийг шийдвэрлэх, зэрлэг ан амьтныг хамгаалах дадлага туршлагыг хөгжүүлэх зорилгоор сүүлийн үед ашигласан үр чадварыг бий болгох арга технологийн тодорхой хэлбэрүүдийг тодорхойлсон төрийн бус байгууллагуудын зөвлөх бүлгийн оролцогчдын тоо (n=105). Бий болгоогүй=судалгаанд оролцогчийн төрийн бус байгууллагад чадавхыг бий болгох арга, техникийг ашиглаагүй..... 60

25Зураг: (a) шугаман дэд бүтцийн төсөлд тэдний байгууллагын гүйцэтгэх үүрэг мөн (b) шугаман дэд бүтцийн төслийн явцад зэрлэг ан амьтныг хамгаалах үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд төрийн бус байгууллагуудын үр дүнтэй үйл ажиллагааг хязгаарлаж байгаа хүндрэл бэрхшээлүүдийн төрлийг тодорхойлсон төрийн бус байгууллагуудын бүрдүүлэгч бүлгийн оролцогчдын тоо..... 61

26Зураг: (a) Төслийн явцад зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд ямар бүлэг хангалттай чадвартай байгаа (b) зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд тулгарч байгаа одоогийн саад бэрхшээлд илүү өртөмхий төслийн үе шатыг нэрлэхтэй холбоотой Бангладеш, Энэтхэг, Монгол, Непал, Тайланд зэрэг улс тус бүрд судалгааны үх бүлгийн оролцогчдын гишүүдийн хариулт..... 63

27Зураг: (a) зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд тулгарч байгаа хамгийн их саад бэрхшээлийг тодорхойлох (b) мэдээллийн хангалтгүй байдлыг тодорхойлох тухай бүх бүрдүүлэгч бүлгийн хариултыг цацраг хэлбэрийн графикт улс орон бүрээр ялган харуулсан.. 64

28Зураг: Шугаман дэд бүтцийн төслийн явцад зэрлэг ан амьтны хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хамгийн чухал хүчин зүйлийг тодорхойлохын тулд бүх бүрдүүлэгч дөрвөн бүлгээс өгсөн хариултыг улс орон бүрээр цацраг хэлбэрийн графикт харуулав. 65

ХҮСНЭГТҮҮД

Хүснэгт1: Чадавхыг бий болгох тухай хянан шалгасан баримт бичгийн дүгнэлт..... 9

Хүснэгт2: ОУСБ-ууд болон шугаман дэд бүтцийн бусад санхүүжүүлэгчид 11

Хүснэгт3: Байгаль хамгааллын чиглэлээр ажилладаг, ярилцлагад хамрагдсан байгаль орчны чиглэлийн II төрийн бус байгууллагууд нь Ази даяар олон салбаруудтай	12
Хүснэгт4: Цахим судалгааны төлөвлөгөөт оролцогчдын нийт тоог бүрдүүлэгч бүлэг ба улсаар нь тодорхойлсон байдал	16
Хүснэгт5: Долоон үндсэн MEA-д элсэн орсон орнууд	18
Хүснэгт6: Шугаман дэд бүтцийн төрөл, БОНБУ-тэй холбоотой үндэсний хууль тогтоомж болон удирдамжийн зонхилох хувьд суурилсан улс орны түвшний үнэлгээ.....	21
Хүснэгт7: Зэрлэг ан амьтныг хамгаалах чиглэлээр Азийн түвшний ОУСБайгууллагуудын заалтууд	23
Хүснэгт8: Салбар салбараар нь аж үйлдвэрийн холбоодыг авч үзсэн байдал.....	28
Хүснэгт9: Олон улсын MEAs-д Бангладешийн оролцоо, мөн MEA тус бүрийн тухай ойлголтын байдал.....	66
Хүснэгт10: Олон улсын MEAs-д Бангладешийн оролцоо, мөн MEA тус бүрийн тухай ойлголтын байдал.....	66
Хүснэгт11: Бангладешийн хууль тогтоомж, бодлого зохицуулалтын тоог хайлтын ангилал тус бүрээр харуулав.....	67
Хүснэгт12: MEAs-д Энэтхэгийн оролцоо болон MEAs тус бүрийн тухай ойлголтын талаарх төр, засгийн бүрдүүлэгч бүлгийн хариултын тоо	68
Хүснэгт13: Хайлтын ангилал тус бүрд тодорхойлсон, хянан шалгасан үндэсний хууль, бодлого, зохицуулалтын нийт тоо.....	68
Хүснэгт14: Монгол улсын MEAs дахь оролцоо, MEA тус бүрийн талаарх засгийн газрын бүрдүүлэгч бүлгээс өгсөн хариултын тоо	69
Хүснэгт15: Ангилал тус бүрт тодорхойлогдсон, Монгол улсын үндэсний хууль, бодлого, зохицуулалтын тоо.....	70
Хүснэгт16: Непал улс олон улсын MEAs дахь оролцоо болон MEA тус бүрийн тухай ойлголтын талаарх төр, засгийн газрын бүрдүүлэгч бүлгийн хариултын тоо.	71
Хүснэгт17: Непалын үндэсний хууль, бодлого, зохицуулалтын нийт тоог хайлтын ангилал тус бүрээр харуулав.....	72
Хүснэгт18: Тайланд улс олон улсын MEAs дахь оролцоо болон MEA тус бүрийн ойлголтын талаарх төр, засгийн бүрдүүлэгч бүлгийн хариултын тоо.....	73
Хүснэгт19: Тодорхойлогдсон тайландын үндэсний хууль, бодлого, зохицуулалтын нийт тоо, хайлтын ангилал тус бүрээр	73

ТОВЧИЛСОН ҮГС

АХБ	Азийн Хөгжлийн Банк
AIIB	Азийн Дэд Бүтцийн Хөрөнгө Оруулалтын Банк
ASEAN	Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны нийгэмлэг
BRI	БҮС БА ЗАМ САНААЧИЛГА
BRIGC	BRI-ийн Ногоон Хөгжлийн Эвсэл
CBA	Өртөг Зардал ба Ашгийн Шинжилгээ
CBD	Биологийн Төрөл Зүйлийн Конвенц
CIDCA	Хятадын Олон Улсын Хөгжлийн Хамтын Ажиллагааны Агентлаг
CITES	Ховордсон Төрөл Зүйлийн Худалдааны Конвенц
CMS	Нүүдлийн Төрөл Зүйлийн Конвенц
EBRD	Европийн Сэргээн Босголт, Хөгжлийн Банк
EHS	Орчны Аюулгүй Байдал, Эрүүл Мэнд
БОНБУ	Байгаль Орчны Нөлөөллийн Үнэлгээ
EIB	Европын Хөрөнгө Оруулалтын Банк
ESF	Байгаль Орчны ба Нийгмийн Тогтолцоо
ESIA	Орчны ба Нийгмийн Нөлөөллийн Үнэлгээ
IFC	Олон улсын санхүүгийн корпораци
IFI	Олон Улсын Санхүүгийн Хүрээлэн
IPPC	Олон Улсын Ургамал Хамгааллын Конвенц
ITPGRFA	Хүнс, Хөдөө Аж Ахуйн Ургамлын Генетикийн Нөөцийн Олон Улсын Гэрээ
IUCN	Байгаль хамгаалах олон улсын холбоо
JICA	Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Агентлаг
KBA	Биологийн төрөл зүйлийн чухал бүс нутаг
LI	Шугаман дэд бүтэц
LISA	Азийн Шугаман Дэд Бүтцийн Хамгаалалт
MDB	Олон Улсын Хөгжлийн Банк

MEA	Олон Талт Байгаль Орчны Гэрээ
MEE	Экологи, Байгаль Орчны Яам
NDB	Шинэ Хөгжлийн Банк
ТББ	Төрийн бүс байгууллага
OECD	Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллага (OECD)
PS	Үйл Ажиллагааны Стандарт
Рамсар	Олон Улсын Ач Холбогдолтой Чийглэг Газруудын Рамсарын Конвенц
SDG	Тогтвортой Хөгжлийн Зорилт
SEA	Стратегийн Орчны Үнэлгээ
TAL	Терай Нумын Ландшафт
UIC	Олон Улсын Төмөр Замын Эвлэл
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
UNDP	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр
UNEP	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Байгаль Орчны Хөтөлбөр
UNESCAP	Нэгдсэн Үндэстний Ази, Номхон Далайн Байгууллагын Эдийн Засаг, Нийгмийн Комисс
USAID	АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг
WARPA	Зэрлэг Ан Амьтныг Хамгаалах Хууль
WB	Дэлхийн Банк
WFLI	Зэрлэг Амьтанд Ээлтэй Шугаман Дэд Бүтэц
WHC	Дэлхийн Өвийн Конвенц

УДИРТГАЛ

21-р зууны эхний 25 жилд Ази нь эдийн засаг, нийгмийн хөгжлийг эрчимжүүлэх, олон улсын дэд бүтцийн санаачилга, үндэсний хөтөлбөрөөр хот, улс үндэстэн, бүс нутгийг холбох үндсэн зорилтыг хэрэгжүүлж эхэлсэн. 2030 он гэхэд дэлхийн эдийн засгийн өсөлтийн 60 орчим хувь нь Азиас эхлэлтэй буюу 2.4 тэр бум шинэ "дунд анги"-ийн гишүүд, дэлхийн нийтийн хэмжээгээр 90 хувь нь дэлхийн эдийн засагт оролцох төлөвтэй (Yendamuri & Ingilizian, 2019). Ази нь өнгөрсөн хэдэн арван жилийн хугацаанд тодорхой хэмжээний ахиц дэвшил гаргасан хэдий ч хөгжлийн зорилтуудтай нүүр тулгарсаар байна. Хэдийгээр Азийн дотоодын нийт бүтээгдэхүүн (GDP) дэлхийн бусад тивүүдээс давж гарсан боловч бараг хагас тэр бум хүн хэт ядуу нөхцөлд амьдарч, орлогын тэгш бүс байдал нэмэгдсээр байна (Yendamuri & Ingilizian, 2019).

Азийн Хөгжлийн Банк (АХБ)-ны тайланд дурдсанаар тус тивд дэд бүтцийг хөгжүүлэхэд жил бүр 880 тэр бум тэр ам долларыг төсөвлөдөг (Asian Development Bank, 2017). Азийн Хөгжлийн Банкны тооцоогоор тус бүс нутагт эдийн засгийн одоогийн өсөлтийг хангахад 2016-2030 оны хооронд дэд бүтцийн салбарт 22.6 триллион ам долларын хөрөнгө оруулалт шаардлагатай байна. Цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох, хөнгөвчлөх арга хэмжээнд жилд 4 триллион ам.доллар нэмэлтээр шаардлагатай. Энэхүү нийт дүнгээс Ази даяар авто зам, төмөр зам, цахилгаан дамжуулах шугамыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд цахилгаан эрчим хүчний (52 хувь) тээврийн (32 хувь) салбаруудад дэд бүтцийн хөрөнгө оруулалтын ихэнх хэсэг чиглэгдэнэ.

Сайжруулсан болон шинэ дэд бүтцийн системүүд нь нийгмийн хөгжлийг дэмжиж, худалдааг хөгжүүлэх, ядуурлыг бууруулах, хүн амын амьжиргааг сайжруулахад тусламж дэмжлэг болно. Гэхдээ зохих ёсоор шийдвэрлэхгүй бол дэд бүтцийн өргөжилт нь Азийн зэрлэг ан амьтан, тэдгээрийн оршин амьдрах нутаг дэвсгэр, экосистем, бусад байгалийн нөөцүүдэд үр дагаврын нөлөө үзүүлж болзошгүй. Эрчимтэй хөгжлийн явцад зэрлэг ан амьтныг хамгаалахын тулд Азийн орнууд авто зам, төмөр зам, цахилгаан дамжуулах шугам гэх мэт шугаман дэд бүтцийн нөлөөллөөс зэрлэг ан амьтныг хамгаалах чадавхтай байх ёстой.

Биологийн олон төрөл зүйлээс бүрдсэн, уян хатан эко системийг хамгаалах, хангах нь халдварт зоонозийн өвчний дэгдэлтийг (Cunningham et al., 2017) сааруулах, амьдралын чанарыг (Srinivasu, 2013) сайжруулах замаар хүн ардын аж амьдралд ашиг тустай гэдэг нь улам бүр тодорхой болсон. Эко системийн үйл ажиллагаа, зэрлэг ан амьтанд шугаман дэд бүтцийг үзүүлэх нөлөөллийг хөнгөвчлөхөд шугаман дэд бүтцийн хөгжил, засгийн газруудыг санхүүжүүлдэг олон улсын санхүүгийн байгууллагууд (ОУСБ-ууд) зэрлэг ан амьтныг хамгаалахад анхаарлаа хандуулж байгаа бөгөөд экологийн, нийгмийн эмзэг улс орнуудын хөгжилд хөрөнгө оруулалт хийсээр байна. Гэхдээ Азийн олон орнууд хөгжлийн хөрөнгө оруулалтын тэгш, үр дүнтэй хуваарилалтад сөргөөр нөлөөлдөг хээл хахуультай нүүр тулж, энэ нь эргээд зэрлэг ан амьтныг хамгаалах үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг (Coca, 2020). Энэ утгаараа зэрлэг ан амьтныг хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт, төлөвлөлт, хэрэгжилтэд тулгарч байгаа хүндрэлтэй асуудал, амжилтыг тодорхойлох нь Азид байгаль орчинд ээлтэй шугаман дэд бүтцийг (WFLI) хэрэгжүүлэх чадавхыг хөгжүүлэх хамгийн чухал эхний алхам юм.

Энэхүү Хавсралтад шугаман дэд бүтэцтэй холбоотой дөрвөн үндсэн бүрдүүлэгч бүлгийг чадавхад үнэлэлт дүгнэлт өгсөн. эдгээр нь ОУСБ-ууд, төр засгийн байгууллагууд, аж үйлдвэр (төлөвлөгөө гаргагчид, инженер, холбогдох зөвлөхүүд), байгаль орчны чиглэлээрх төрийн бүс байгууллагууд (ТББ) болно. Энэ нь шугаман дэд бүтцийн гурван үндсэн төрөлд чиглэдэг, үүнд: авто зам, төмөр зам, цахилгаан дамжуулах шугам зэрэг болно. Энэхүү үнэлгээнд Ази бол том, биологийн олон төрөл зүйлтэй тив гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Олон улсын үйл ажиллагаа,

дэлхийн байгаль хамгааллын үйл ажиллагаа нь тус тивийн хэмжээнд идэвхтэй явагддаг, мөн шугаман дэд бүтцийг байгуулахад зэрлэг ан амьтны асуудлыг ойлгох ойлголтыг төвшинг илэрхийлж байгаа боловч зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээ нь бүс нутаг, тивийн төвшинд биш зөвхөн шугаман дэд бүтцийг төлөвлөн хэрэгжүүлж байгаа улс орны төвшинд явагдаж байна. Азийн өргөн уудам газар нутаг, биологийн олон төрөл зүйлийн хувьд чадавхыг хоёр байдлаар үнэлдэг: үүнд Азийн хэмжээний 28 улс орны төвшинд ерөнхий тойм байдлаар, мөн Бангладеш, Энэтхэг, Монгол, Непал, Тайланд гэсэн таван төлөөлөгч улс орнуудын үндэсний түвшний үнэлгээ гэсэн хоёр төвшинд үнэлдэг.

Энэхүү хавсралтын 1-р хэсэгт Азийг хөгжүүлэхэд өмнө нь бий болсон үйл ажиллагааны хувьд WFLI-д зориулж одоогийн чадавхыг хөгжүүлэх сонгомол жишээнүүдийг хянан үзсэн.

2-р хэсэгт төлөөлөгч улс орнуудыг хэрхэн сонгосон тухай тайлбарлаж, Ази даяар болон үндэсний төвшинд чадавхыг үнэлэх аргуудыг тодорхойлсон.

3-р хэсэгт Азийн түвшний үнэлгээний үр дүнг танилцуулж, WFLI-ийн хөгжлийг дэмждэг болон саад болдог байгаль орчны бодлого, шийдвэрүүдийг танилцуулсан. Мөн зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой мэдлэг, сонирхол, тэргүүн туршлагын өргөн цар хүрээний талаар, мөн тэдгээр нь дөрвөн үндсэн бүлэг болон ази тивийн газар нутагт харилцан адилгүй байгаа тухай хэлэлцсэн. Зэрлэг ан амьтанд зориулсан үр дүнтэй хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд тулд нэн тэргүүнд тулгарч байгаа саад бэрхшээл, тулгамдсан асуудлуудыг тодорхойлдог.

Энэхүү хавсралтын 4-р хэсэгт Бангладеш, Непал, Тайланд, Монгол зэрэг улс орнуудад бүрдүүлэгч дөрвөн бүлгийг хамруулан үндэсний түвшний чадавхын үнэлгээний үр дүнг танилцуулсан. Эдгээр улс орнууд нь Азийн харилцан адилгүй нийгэм-экологийн орчинг илэрхийлдэг бөгөөд WFLI-ийн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд тулгарч байгаа саад бэрхшээлийг тодорхойлох, үнэлэн дүгнэх, тухайн таван улс орнуудад эдгээр бүрдүүлэгч бүлгийн цаашдын эрэлт, хэрэгцээг тодорхойлох судалгаа хийсэн.

5-р хэсэгт шугаман дэд бүтцэд зориулж зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд тулгарч байгаа тулгамдсан асуудлууд, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлуудад үнэлэлт дүгнэлт өгөх, улс орны төвшинд үнэлгээ хийх замаар таван улс орон тус бүрт тусгайлан судалгаа хийсэн. Энэ нь хамгааллын арга хэмжээний шаардлагууд, чиг хандлагыг бий болгох зорилгоор улс орон бүрийн хууль тогтоомж, шаардлагууд, хууль эрх зүйн чадавхыг үнэлсэн.

Эцэст нь 6 ба 7-р хэсэгт Азийн чадавхын үнэлгээнээс гарсан үндсэн дүгнэлтийг танилцуулж, цаашид, ирээдүйд чадавхыг бий болгох зөвлөмжүүдийг танилцуулсан.

Азийн шугаман дэд бүтэцтэй холбоотой хамгаалалтад чадавхын үнэлгээний гол зорилтууд бол:

1. Шугаман дэд бүтцийг (авто зам, төмөр зам, цахилгаан дамжуулах шугам) хөгжүүлэхэд зэрлэг ан амьтныг хамгаалахтай холбоотой ази тивийн орнуудын одоогийн чадавхыг үнэлэх.
2. Шугаман дэд бүтцийг хөгжүүлэхэд зэрлэг ан амьтныг хамгаалах үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэхэд тулгарч буй хүндрэлтэй асуудлуудыг тодорхойлох.

ХАМ СЭДВИЙН ТОВЧ УТГА: АЗИД ӨМНӨХ ЧАДАВХЫГ БИЙ БОЛГОХ

Бий болгосон, хөгжүүлсэн орчин нь байгаль хамгааллын үйл ажиллагаатай(Group of Seven, 2021; United Nations General Assembly, 2021) уялдаа холбоотой байх ёстой гэсэн одоогийн дэлхий нийтийн чиг хандлагыг харгалзан үзээд, Азид WFLI-ийн чадавхыг хөгжүүлэх хичээл чармайлт тодорхой ахиц дэвшилд хүрсэн. Төр, засгийн газар, санхүүжүүлэгч, аж үйлдвэр, төрийн бус байгууллагууд гэх мэт олон бүрдүүлэгч бүлгүүд нь WFLI-ийн хамгааллыг хэрэгжүүлэх, Азийн одоогийн чадавхыг сайжруулах зорилгоор удирдамж баримт бичиг, бага хурал, танилцуулгуудыг гаргаад эхэлсэн.

Одоогийн байдлаар Ази ба Хойд Америкийн эсвэл Европын орнуудын хоорондох бизнес уулзалт, WFLI -ийн аялал, хүний нөөцийн сургалт, техник дамжуулах вебинар зэрэгт тохиолдож байгаа чадавхыг бий болгох ихэнх үйл ажиллагаануудад тодорхой баримт бичиг байхгүй хэвээр байна. Пэрэзийн багийн гишүүд Хятад, Энэтхэг, Япон, Малайз, Монгол, Мянмар, Непал, Өмнөд Солонгос, Тайланд, Туркменистан болон бусад зарим улс орнуудын шугаман дэд бүтцийн мэргэжилтнүүдтэй хамтран эдгээр олон үйл ажиллагаанд оролцсон. Азийн Хөгжлийн Банк, Хятадын Тээврийн Ухааны Академи, Дэлхийн Бар Хамгаалах Форум, Энэтхэгийн Зэрлэг Ан Амьтны Институт, АНУ-ын Загас, Зэрлэг Ан Амьтны Газар болон бусад олон байгууллага, агентлагууд чадавхыг бий болгох хичээл чармайлтад оролцож, дангаараа болон хамтран санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. Эдгээр үр дүнтэй эхлэлийг хэрэгжүүлэхдээ тивийн хэмжээнд шугаман дэд бүтцийн хөгжлийг эрчимжүүлэх, хөгжүүлэх зорилтын хүрээнд хэрэгжүүлэх нь зүйтэй.

Одоогийн чадавхыг сайтар ойлгохын тулд төлөвлөлт, бүтээн байгуулалтын шатанд WFLI-ийн хамгааллын арга хэмжээг багтаан оруулахад дэмжлэг түслалцаа үзүүлэх, чадавхыг бий болгох одоогийн баримтжуулсан хичээл чармайлтын доорх таван жишээнд анхаарлаа хандуулсан:

1. Энэтхэгийн Засгийн Газар (2016 оны хоёрдугаар сар, 23-25). *Ногоон Зам: Байгалийн Нутаг Дэвсгэр Дахь Дэд Бүтэц. Чадавхыг Бий Болгох Тусгай Үйл Ажиллагааны Бүлэг.*
2. Дэлхийн Банк, хамтран. (2010). *Барын Тархац Бүхий Орнуудад Ухаалаг Ногоон Дэд Бүтэц: Олон Түвшний Чиг Хандлага.*
3. К.Олсон, К. (2013). *Бөхөнгийн Гарцын Сонголтууд: Казахстанд Бөхөн Зээрт Хилийн Хашаа Болон Төмөр Замын Шугамын Нөлөөллийг Хөнгөвчлөх, Бууруулах Тухай Зөвлөмжүүд.*
4. UNEP/CMS. (2015). *Төв Азид Хөхтөн Амьтанд Үзүүлэх Сөрөг Нөлөөлөл, Шугаман Дэд Бүтцийн Нөлөөллийг Хөнгөвчлөх Зөвлөмжүүд.*
5. Энэтхэгийн зэрлэг ан амьтныг хамгаалах институт. (2016). *Зэрлэг Ан Амьтанд Шугаман Дэд Бүтцийн Нөлөөллийг Хөнгөвчлөх, Бууруулах Экологид Ээлтэй Арга Хэмжээнүүд.*

Зөвлөмж, удирдамжийг товч байдлаар сонгосноор бүс нутагт хамгаалах араг хэмжээний чадавхыг бий болгох үйл ажиллагаанд тусгах жишээ загваруудыг бүрдүүлэх ач холбогдолтой. Чадавхыг бий болгох олон хичээл чармайлтуудад албан ёсны мэдээлэл, тусгай тайлан хомстолтой, үүний улмаас өмнөх чадавхыг бий болгох үйл ажиллагааны талаарх системтэй хяналт шалгалтад зохих мэдлэг, мэдээлэл хомстолтой байна. Бид байгаль хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулж чадавхыг бий болгох үйл ажиллагаа, хичээл чармайлтын жишээ болгож таван баримт бичгийг санал болгосон бөгөөд эдгээр нь Азийн WFLI чадавхын бий болгох үйл ажиллагаа, хичээл чармайлтын эцсийн нэгдсэн дүгнэлт биш гэдгийг ойлгож байна.

ЧАДАВХЫГ БИЙ БОЛГОХ НИЙТЛЭГ БАЙДЛУУД

Эдгээр баримт бичгүүдэд Азид WFLI-ийн чадавхын талаар танилцуулсан, төрөл зүйл, цар хүрээнээс үл хамаараад хэд хэдэн нийтлэг зүйл ажиглагдсан. Бүгдэд илэрхий байх нь хөнгөвчлөх шаталсан арга хэмжээг хэрэгжүүлэхийн чухал ач холбогдол юм. Хөнгөвчлөх, бууруулах арга хэмжээг эрт үед ашиглах нь ландшафтын хөгжлийн төлөвлөлтийн үе шатанд мөн төслийн төлөвлөлт, зураг төслийн хэрэгжүүлэлт, үйл ажиллагааны бүх шатанд түүнийг хэрэгжүүлснээр нөлөөллийг бууруулах чухал хүчин зүйл болон гарч ирдэг. Тэргүүн туршлагын хүрээнд төслийн төлөвлөлтийн өмнөх үед биологийн төрөл зүйлийн үнэлгээ хийх шаардлагатай. Гэхдээ нарийн түвшний биологийн төрөл зүйлийн үнэлгээ хийх боломжгүй боловч төслийг хэрэгжүүлэх газар нутагт экологийн үйлдвэр холбооны судалгааг анхны чухал үе шат гэж санал болгодог. Бий болгосон орчин нөхцөлд экологийн үйлдвэр холбоог хангах аргууд нь ихэвчлэн өндөр зардалтай байдаг учраас хөнгөвчлөх, бууруулах шаталсан арга хэмжээний нэгдүгээр алхам болох зайлсхийх үйл ажиллагаа бол зэрлэг ан амьтны маршрутыг хамгаалах хамгийн үр дүнтэй арга юм. Жишээ нь хулан (*Equus hemionus khor*) гэх мэт гол төрөл зүйлд зориулан зэрлэг ан амьтны маршрутын асуудлыг судлах, зэрлэг ан амьтны хөдөлгөөний маршрутын мэдээллийг хөгжүүлэх зардал Гужарат Мужийн Төв Замын үйл ажиллагааны нийт зардалд 1-2 хувийн нэмэлт зардлыг бий болгодог ба энэ нь хожим нэмэх үйл ажиллагааны зардалтай харьцуулахад маш бага зардал юм (Government of India, 2016). Өөрөөр хэлбэл бүтээн байгуулалтын нийт зардлын 2 хувьд Казахстанд төмөр замын өргөтгөлийн явцад нэн ховордсон Бөхөнгийн (*Saiga tatarica*) хөдөлгөөний маршрутаас зайлсхийх судалгаа, төлөвлөлт нь өөр бусад сэргээгдэх нөөцөд бага хэмжээний нөлөөлөл үзүүлэх хэмжээний зардал юм (Marsh, n.d.).

Өөр нэг ерөнхий түгээмэл зүйл бол хамрагдах бүрдүүлэгч бүлэг тус бүрээр, шугаман дэд бүтцийн төслийн төлөвлөлтийн бүх үе шатанд зэрлэг ан амьтны асуудлыг багтаан оруулах хэрэгцээ шаардлага юм. Тайлан мэдээнээс харахад төр засгийн бодлого шийдвэр, газар эзэмших төлөвлөгөө нь WFLI-ийн хөгжлийн үе шатыг тодорхойлдог. Нутаг дэвсгэрийн хөндөгдөөгүй байдлыг хангах албан ёсны зорилт, бүс нутгийн газар ашиглах төлөвлөгөөний бүрэлдэхүүн байдлаар үндсэн маршрутыг тодорхойлох нь дэмжин туслах орчин нөхцөлийг бүрдүүлдэг. Тохиромжтой нөхцөлд "хохиролгүй байх" төлөвлөгөө, мөн "байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа"-ны зорилт нь томоохон нөлөөллүүдийг бууруулах, арилгах араг замуудыг судлах, байгууллага хоорондын хамтын ажиллагаатай үйлдвэртэй байдаг. Энэхүү үйл ажиллагааны хүрээнд төслийн төлөвлөлт, санхүүжилт, зураг төсөл, бүтээн байгуулалт, үйл ажиллагааг хариуцсан улсын ба хувийн байгууллагууд нь төслийг хэрэгжүүлэх өсөн нэмэгдэж байгаа төвшинд зэрлэг ан амьтныг хамгаалахад чухал үүрэгтэй. Үүнээс гадна үр дүнг сайжруулахад улсын зөвлөх байгууллага, оролцогчид, олон нийтийн түвшний үйл ажиллагаа чухал үүрэгтэй.

Эцэст нь хэлэхэд баримт бичгүүдэд гуравт нь шугаман дэд бүтцийн төлөвлөлт, хөгжлийн үйл ажиллагаа нь ихэнх тохиолдолд зэрлэг ан амьтан, биологийн төрөл зүйлстэй холбоотой асуудлыг хангалттай бүрэн тусгадаггүй ерөнхий шалтгааныг тодорхойлсон. Эдгээр нь хөнгөвчлөх, бууруулах арга хэмжээний талаарх ойлголт дутмаг, биологийн төрөл зүйлийн талаарх ойлголт зэргээс шалтгаалдаг. Сүүлчийн асуудал нь хөнгөвчлөх арга хэмжээнд тодорхой хэмжээгээр эерэгээр нөлөөлдөг боловч Азийн хүн амын нягтшил ихтэй газарт зэрлэг ан амьтны сүүлчийн орогнох газрыг хамгаалахад чухал ач холбогдолтой тэдгээр эх үүсвэрт асуудлыг бүрэн шийдвэрлэдэггүй. Хэдийгээр ногоон дэд бүтцийн талаарх олон нийтийн зорилт анхдагч асуудал болох экологийн үйлдвэр холбоогоор дутмаг байдаг. Цөөн улс орон, бүсүүдэд зэрлэг ан амьтны хөдөлгөөний маршрут, тэдгээрийг тодорхойлох хэрэгцээ шаардлагыг багтаасан биологийн төрөл зүйлийн төлөвлөлт, байгаль орчны үнэлгээтэй боловч хөнгөвчлөх арга хэмжээнүүдийг зөвхөн төслийн төвшинд л багтаадаг. Тухайн тохиолдолд

маршрутыг тодорхойлж, бүтээн байгуулалтын төлөвлөгөөг баталсны дараа арга хэмжээнүүдийг нэмэх боломжтой. Үүний улмаас тухайн арга хэмжээнүүд нь хор хохиролгүй байх, байгаль орчинд ээлтэй байх зорилгодоо хүрээнд учир дутагдалтай болдог.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨВШИН, ХИЛ ДАМНАСАН ЧИГ ХАНДЛАГАД АНХААРЛАА ХАНДУУЛАХ

Чадавхыг бий болгох баримт бичгүүдийн гурав нь бүс нутагтаа тодорхой харагдах төрөл зүйл, асуудал хандуулах шаардлагатай төрөл зүйлсийн нэгдэлд (жишээ нь бар (*Panthera tigris*) болон Төв Азийн хөхтнүүд) зориулагдсан, ховордсон төрөл зүйлсийг хамгаалан авч үлдэхийн төлөө байгаль орчны түвшний зорилтыг хөгжүүлэх хэрэгцээ шаардлагаас үүдэлтэй(Olson, 2013; Quintero et al., 2010; UNEP/CMS, 2015). Эдгээр баримт бичгүүдийн байгаль орчны хандлага нь хөгжлийн шаардлагуудад байгаль хамгааллын асуудлыг тусгахаас илүүтэй бүс нутгийн хөгжлийн төлөвлөгөөний явцад төрөл зүйлийн хэрэгцээ шаардлагын төлөв байдлаас дэд бүтцийн асуудлыг авч үзэх боломжийг олгодог. Энэхүү зорилтод чиглэснээр үнэлгээний хоёр нь *Төв Азийн Хөхтнүүдийн Нүүдэл, Шугаман Дэд Бүтцийн Атласыг* хэвлэн гаргахад хүргэсэн, энэ нь шийдвэр гаргагчид, хөгжлийн банк, бусад оролцогчдод мэдээллээр хангах үүрэгтэй, "Төв Азийн хөхтнүүд болон шугаман дэд бүтцийн хоорондох одоогийн болон цаашдын зөрчлийг зургаар дүрслэн илэрхийлсэн баримт бичиг юм"(UNEP/CMS, 2019). Заримдаа Төв Азийн хөхтнүүд хил дамнан нүүдэллэх, өргөн уудам нутаг дэвсгэрт тархан нүүдэллэх хэрэгцээ шаардлага тулгардаг боловч энэхүү атлас нь газар нутгийн түвшний төлөв байдлаас доогуур төвшинд бүрэн хангалттай мэдээлэл өгч чадахгүй. Барын жишээн дээр хэлэхэд тусгай хамгаалалттай газар нутаг нь хүний ноёрхол, давамгайлал бүхий газар нутагт оршдог, ойн тархац хэмжээ хумигдаж, шугаман дэд бүтцийн хөгжил хурдассан, шугаман дэд бүтэц болон байгаль хамгаалах эн тэнцүү хяналт шалгалтын ач холбогдлыг илэрхийлдэг.

Чадавхыг бүрдүүлэх таван баримт бичгээс гурав нь Энэтхэгт анхаарлаа хандуулсан, харин нэг баримт бичиг нь барын тархац бүхий бусад улс орнуудыг багтаасан. Бенгалийн бар, Азийн зааны (*Elephas maximus*) хамгийн том үлдэгдэл популяцын төрөлх нутаг болохын хувьд Энэтхэг нь дэлхийд авто замын хоёрдахь том, төмөр замын гуравдахь том сүлжээг дэмждэг. WFLI-ийг хөгжүүлэх бодлого, үйл ажиллагааны одоогийн төлөв байдлын талаарх гүнзгий түвшний дүн шинжилгээ мөн хөхтөн, шувуу, хоёр нутагтан, мөлхөгчид, нугалмайтан зэрэг төрлүүдэд зориулсан бүлэгчилсэн зөвлөмжийн тусламжтайгаар Зэрлэг Ан Амьтанд *Шугаман Дэд Бүтцийн Нөлөөллийг Хөнгөвчлөх Экологид Ээлтэй* Арга Хэмжээ нь гурвалсан (байгаль орчны, нийгмийн, санхүүгийн) доод түвшний үйл ажиллагааг хэрэгжүүлэх чадвартай үр дүнтэй аргаар нийгмийн, байгаль орчны зорилтуудыг хангахад шугаман дэд бүтцийн хөгжүүлэхэд биологийн төрөл зүйлийн асуудлуудыг тусгах нь зүйтэй гэдгийг онцлон харуулдаг(Wildlife Institute of India, 2016). Олон тохиолдолд зэрлэг ан амьтанд зориулсан хамгаалах араг хэмжээнүүд нь зэрлэг ан амьтан- тээврийн хэрэгслийн мөргөлдөөнийг бууруулах замаар хүний аюулгүй байдлыг сайжруулдаг. Тэдгээр нь цаг уурын онцгой нөхцөл байдлын давтамж эрчимжиж байгаа энэ үед дэд бүтцийн уян хатан байдлыг сайжруулах боломжтой. Цаашлаад экологийн үялдаа холбоог хангаснаар WFLI нь эко системийн үйл ажиллагааг хангахад тусална.

Том, дунд, жижиг хөхтнүүдэд авто замын нөлөөллийг дэлгэрэнгүй танилцуулах, мөн тусгай хамгаалах араг хэмжээнүүдийг авч үзэх тогтолцоог бий болгохоос гадна *Зэрлэг Ан Амьтанд Шугаман Дэд Бүтцийн Нөлөөллийг Бууруулах Экологид Ээлтэй Арга Хэмжээ* (2016) нь хоёр нутагтан, хэвлийгээр явагчийн дамжин өнгөрөх хөдөлгөөнийг дэмжих замыг тодорхойлдог. Томоохон төрөл зүйлүүдэд зориулсан хөнгөвчлөх арга хэмжээгээр дамжуулан шугам хоолой, бусад байгууламжид төрөл зүйлээс хамааралтай тохируулах арга хэмжээ шаардлагатай. Энэхүү баримт бичиг нь цахилгаан дамжуулах шугамд онцгой анхаарал хандуулсан, Азид зориулсан зөвлөмж баримт бичиг юм. Авто зам, төмөр замын шугамд Шувууны Чухал Нутаг Дэвсгэр, шувууны нисэж өнгөрөх замаас зайлсхийх нэн тэргүүний стратеги арга зам учраас

цахилгаан дамжуулах шугамыг газар доогуур явуулснаар зайлсхийх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагагүй болно. Урьдчилан сэргийлэх, хөнгөвчлөх арга хэмжээнүүд нь цахилгааны тасалдал, шувууны төрөл зүйлс цахилгаан дамжуулах шугамын нөлөөгөөр хорогдох эрсдэлийг бууруулдаг учраас тухайн арга хэмжээнүүд нь зайлсхийх арга хэмжээтэй харьцуулахад үр дүн багатай, хэрэгжүүлэхэд нэлээд хүндрэлтэй юм.

Барын Тархац Бүхий Орнуудад Ухаалаг Ногоон Дэд Бүтцийг Хөгжүүлэх гэх мэт одоогийн хөгжлийн чиг хандлагын хүрээнд ховордсон төрөл зүйлийн авран хамгаалах эгзэгтэй, хүнд хэцүү үйл ажиллагааны хариуд: салбар хоорондын чиг хандлага нь усан цахилгаан станцын далан, уурхай(The World Bank et al., 2010) төдийгүй тээврийн дэд бүтцийн (үндсэндээ авто замын) бодлогын сонголтууд, төслийн түвшний зөвлөмжийн хяналт шалгалтыг оруулсан. Энэхүү баримт бичиг нь бүсийн төвшинд нутаг дэвсгэрийг хуваахаас зайлсхийх сонголтуудыг шалган тодорхойлох, зэрлэг ан амьтдад гүүрэн гарцтай зам болон бусад байгууламжийн ерөнхий нөлөөллийг тодорхойлох боломжтой SEAs-ийн хэрэгцээ шаардлагыг онцолдог. SEAs нь бодлого зохицуулалтыг дамжин, төслийн түвшний шийдвэр гаргахын өмнө хамтдаа хэрэгжих бөгөөд "байгаль орчинд ээлтэй" мөн "хор хохиролгүй" шийдвэр гаргах бэлтгэл болдог. Үүний ижлээр 2016 оны Ногоон Зам, чадавхыг Болгох Судалгааны Тайлан: Энэтхэг, Непал, Бангладешийн албаны хүмүүсийн оролцсон, Энэтхэгийн Ассам Дахь Байгалийн Цогцолборт Газрын Дэд Бүтэц нь нөлөөллийг шийдвэрлэх төслийн одоогийн чиг хандлага амжилтгүй болсон, үндэсний, салбарын, төслийн төвшинд Хөнгөвчлөх Шаталсан Арга Хэмжээний зарчимд суурилсан нөлөөллийг авч үздэг гэдгийг батлан харуулдаг(Government of India, 2016).

Хянан шалгасан удирдамжийн бусад хэсэг нь Төв Азид анхаарлаа хандуулсан, Нүүдлийн Төрөл Зүйлийн Конвенцын (CMS) үр дүнгүүд юм. Хамрах хүрээгээрээ бараг нэвтэрхий толь бичиг гэж хэлж болох Төв Азийн Хөхтнүүдэд Шугаман Дэд Бүтцийн Нөлөөлөл, Холбогдох Сөрөг Нөлөөллийг Бууруулах Зөвлөмж нэртэй баримт бичиг нь авто зам, төмөр зам, нефть, байгалийн хийн хоолойн нөлөөллийг бууруулах, хөнгөвчлөх үнэлгээ, хяналт, төлөвлөлт, зураг төсөл, үнэлгээ, бүтээн байгуулалтын зарчим, удирдамжийг санал болгож, төрөл зүйлийн хэрэгцээ шаардлага, хууль эрх зүйн тогтолцоог тодорхойлдог(UNEP/CMS, 2015). Тус баримт бичиг нь Бөхөнгийн Гарц, Зөрлөгийн Шийдлүүдэд заагдсан өмнөх ажил болон Казахстанд Бөхөнгийн Сүрэгт Хилийн Хашаа, Төмөр Замын Коридорын Нөлөөг Хөнгөвчлөх Зөвлөмж, Удирдамжид суурилсан(Olson, 2013). Хяналт шалгалтын үндсэн дээр төрөл зүйл, нутаг дэвсгэрийн зохистой цар хүрээг мөрдөхийн ач холбогдлыг онцлон тэмдэглэхээс гадна Төв Азийн удирдамж нь хил дамнасан нөхцөл байдлын хэрэгцээ шаардлагыг онцлон тэмдэглэдэг. Хянан үзсэн улс орнуудаас Казахстан дангаараа шугаман дэд бүтцийн зураг төсөл, бүтээн байгуулалттай холбоотой нүүдлийн төрөл зүйлд үзүүлэх нөлөөллийг үнэлэхийг шаардсан хууль эрх зүйн тогтолцоотой орон юм. Цаашлаад хэдийгээр амьтны хөдөлгөөнд үзүүлэх илэрхий нөлөөллүүд байгаа боловч хашаа татах арга хэмжээ нь бүс нутгийн ямар ч улс оронд ямар нэгэн үнэлгээ шаарддаггүй.

ХУРААНГУЙ

Нэгтгэн хэлбэл өмнөх чадварыг бий болгох таван баримт бичигт заасан бодлого шийдвэр, төслүүд нь WFLI-ийн хөгжлийг дэмжих үндсэн замуудыг тодорхойлдог. Эдгээр таван баримт бичгүүдийн дөрөв нь авто замын илүүтэй онцолсон, төмөр замыг хоёрдугаарт тавьсан (Хүснэгт1). Зөвхөн нэг баримт бичигт энэхүү төслийн үндсэн асуудал болох цахилгаан дамжуулах шугамыг хамруулсан. Дэд бүтцийн бусад төрлүүд болох нефть, байгалийн хийн хоолой, уурхайнуудыг нэг баримт бичигт авч үзсэн, усан цахилгаан станц, хашаатай холбоотой зарим мэдээллийг хоёр тайланд заасан.

ХҮСНЭГТ I: ЧАДАВХЫГ БИЙ БОЛГОХ ТУХАЙ ХЯНАН ШАЛГАСАН БАРИМТ БИЧГИЙН ХУРААНГУЙ								
БАРИМТ БИЧГИЙН НЭР	ЖИЛ	ТӨРӨЛ ЗҮЙ/БҮЛЭГ	ДЭД БҮТЦИЙН ХЭЛБЭР					
			АВТО ЗАМ	ТӨМӨ Р ЗАМ	ХАШАА	УСАН ЦАХИЛГААН СТАНЦ/ЦАХИЛГА АН ДАМЖУУЛАХ ШУГАМ	НЕФТЬ БА БАЙГА ЛИЙН ХИЙ	УУЛ УУРХА Й
Энэтхэг болон Барын Тархац Бүхий Орнууд								
Зэрлэг Ан Амьтанд Шугаман Дэд Бүтцийн Үзүүлэх Нөлөөллийг Бууруулах, Хөнгөвчлөх Экологид Ээлтэй Арга Хэмжээнүүд	2016	Хөхтөн, Шувуу, Хэвлийгээр Явагч, Хоёр Нутагтан, Нугалмайтан	Х	Х		Х		
Ногоон зам: Өлгий Нутаг Дахь Дэд Бүтцүүд	2016	Олон төрөл зүйлүүд	Х					
Барын Тархац Бүхий Орнуудад Ухаалаг Ногоон Дэд Бүтэц: Салбар Хоорондын Чиг Хандлага	2010	Бар ба Бусад Том Хөхтөнүүд	Х	Х		Х		Х
Төв Ази								
Төв Азийн Хөхтнүүдэд Шугаман Дэд Бүтцийн Нөлөөлөл Болон Бусад Сөрөг Нөлөөллийг Бууруулах Арга Хэмжээний Удирдамж	2014	Төв Азийн Хөхтнүүд	Х	Х	Х	Х	Х	
Бөхөнгийн Гарц, Зөрлөгийн Шийдлүүд: Казахстанд Бөхөнгийн Сүрэгт Хилийн Тор Болон Төмөр Замын Шугамын Нөлөөг Бууруулах, Хөнгөвчлөх Зөвлөмж	2013	Бөхөн		Х	Х			

Нутаг орныг ажигласнаар цөөхөн үлдсэн барын унаган нутагт "нэвтрэх боломжгүй нутаг орон" гэх мэт төрөл зүйлс хамааралтай хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, гиббон сармагчин (*Hoolock spp.*) гэх мэт модон дээр амьдардаг төрөл зүйлд зориулсан хөнгөвчлөх арга хэмжээнүүдийг тодорхойлох, цаашлаад төлөвлөлтийн өмнөх шатнаас бүтээн байгуулалтын дараах хяналт шалгалт хүртэлх төслийн хөгжлийн бүх үе шатанд нөлөөлөх бодлого зөвлөмж хүртэлх стратеги арга хэмжээнүүдийг тодорхойлдог. SEAs болон байгаль орчинд ээлтэй санаачилгууд нь төслийн түвшний амжилтуудад суурь нөхцөл болдог. Бүх таван баримт бичигт дэлхий дахин дахь WFLI хөгжлийн жишээнүүдийг танилцуулж, Непал, Индонез, Малайз, Вьетнам, Энэтхэг, Төв Азийн бүс нутагт зэрлэг ан амьтанд илүү ээлтэй дэд бүтцийг байгуулахыг эрмэлзэж байгаа төслүүдийг танилцуулсан.

АРГА БАРИЛУУД

Авто зам, төмөр зам, цахилгаан дамжуулах шугамд зориулан зэрлэг ан амьтны хамгааллыг хэрэгжүүлэхэд одоогийн хүчин чадавхыг үнэлэхийн тулд бид хоёр нутаг дэвсгэрийн төвшинд чадавхыг хянан шалгасан: 1) бүх 28 оронд Азийн төвшинд 2) таван оронд орон нутгийн буюу төслийн төвшинд. Энэхүү хоёр давхар чиг хандлага нь энэхүү үнэлгээнд зэрлэг ан амьтныг хамгаалах амлалт өгсөн олон улсын гэрээнээс чадавхын янз бүрийн нөхцөл байдал, талуудыг ойлгох боломжийг олгож, харин тээвэр, эрчим хүч, байгаль хамгааллын байгууллагуудыг дэмждэг үндэсний бодлого шийдвэрт зэрлэг ан амьтныг хамгаалах боломж олгож, улмаар шугаман дэд бүтцийг төлөвлөгөө батлах, төслийн түвшний хэрэгжүүлэлт хийх боломжийг олгодог. Янз бүрийн оролцогчид төсөл боловсруулахаас эхлээд сонголт, санхүүжилт, төлөвлөлт, зураг төсөл, хэрэгжүүлэлт хүртэл шугаман дэд бүтцийн олон талуудыг хариуцдаг учраас бид ОУСБ, засгийн газрын байгууллагууд, аж үйлдвэр, төрийн бус байгууллагууд зэрэг дөрвөн бүрдүүлэгч бүлэгт зориулсан мэдээллийг цуглуулсан.

Азийн түвшний үнэлгээний хувьд бид одоогийн хууль тогтоомж, зохицуулалт, удирдамж, аж үйлдвэрийн стандартуудын талаар мэдээлэл цуглуулахад вебд суурилсан хайлтуудыг ашигласан. Азийн төвшинд бид байгаль хамгааллын чиглэлийн олон улсын төрийн бус байгууллагуудын Азийн хөтөлбөрийн удирдагчидтай ярилцлага хийж, үндэсний түвшний байгаль хамгаалах багуудад судалгааны цахим баримт бичгийг явуулсан. Тивийн төвшинд ОУСБ-ийн хамрах байдлыг үнэлэн дүгнэхийн тулд бид веб сайтуудыг хянан шалгаж, цахим судалгаа хийсэн.

Үндэсний төвшинд бид төлөөлөгч таван оронд (Бангладеш, Энэтхэг, Монгол, Непал, Тайланд) улс орнуудын төрийн байгууллагын ажилтнууд, ОУСБ-ийн гишүүд, шугаман дэд бүтцийн салбарын төлөөлөгчид, төрийн бус байгууллагын ажилтнуудад цахим судалгааг явуулахаар төлөвлөсөн. Мөн бид төв оффис болон бүсийн оффиссууд дахь ОУСБ-ын удирдагч нартай ярилцлага хийсэн. Үндэсний хууль тогтоомж, зохицуулалтыг үнэлэн дүгнэхийн тулд бид хууль ёсны интернетийн мэдээллийг хянан шалгаж, мэдээллийг хянан шалгахыг төлөөлөгч таван улсын хууль эрх зүйн болон бусад мэргэжилтнүүдээс хүссэн.

Энэхүү үнэлгээний зорилгоор бид энэхүү төслийн цар хүрээ, харьцангуй богино хугацаатай (13 сар) хамгийн сайн тохирох аргуудыг сонгосон нь КОВИД-19 цар тахлын үед дүн шинжилгээний мэдээллийг цуглуулах боломжтой. КОВИД-19-ийн улмаас аялах, оролцогчидтой ярилцах, удирдагчид болон шийдвэр гаргагчидтай уулзах боломжгүй болсон. Иймээс суурь мэдээллийг цуглуулахын тулд интернет хайлтад найдаж, бүсийн түвшний бодлого болон чадавхыг яаралтай үнэлэх зорилгоор мэргэжилтнүүдтэй хамтран мэдээллүүдийг хянан шалгасан. Төлөвлөсөн хүмүүст хүрэх, мөн дөрвөн өөр бүрдүүлэгч бүлгийн гишүүдээс зохих ёсны хариулт авахын тулд таван төлөөлөгч улсад мэдээлэл цуглуулах анхдагч арга болгон цахим судалгааг сонгон авсан. Судалгаанаас харьцуулалтыг хөнгөвчлөхийн тулд олон сонголтот эсвэл тийм-үгүй хариулттай асуултуудыг сонгон авсан.

АЗИЙН ТҮВШНИЙ ЧАДАВХЫН ҮНЭЛГЭЭ

Азийн төвшинд бид WFLI-ийг хөгжүүлэх зорилгоор 28 улсын чадавхыг үнэлэх хяналтыг хийсэн. Бид одоогийн хууль тогтоомж, удирдамжийн талаар интернетээс олох боломжтой мэдээллүүдийг ашигласан. Бид бүрдүүлэгч бүлэг тус бүрт норм, хэв хэмжээг судлах экспертийн дүгнэлтийг хүссэн. Интернетээр олох боломжтой мэдээлэлд суурилсан бүрдүүлэгч бүлгээс шалтгаалж нэмэлт аргууд харилцан адилгүй байсан; эдгээрийг доор танилцуулав.

ЗАСГИЙН ГАЗАР БА АГЕНТЛАГУУД

Олон Улсын Гэрээнүүд: Бид цэнгэг үс болон газар орныг хамгаалахыг эрмэлзсэн протокол, дүрэм, гэрээ зэрэг олон улсын байгаль орчны олон талт долоон гэрээг тодорхойлсон. Бид Азийн 28 улсын талаар MEA бүрийн веб сайтуудыг хянан шалгасан.

Үндэсний агентлагууд: Бид 28 улс орон тус бүрд хууль тогтоомждоо биологийн төрөл зүйлийн заалтыг дэмжих үүрэгтэй, шугаман дэд бүтцийн хөгжлийн явцад зэрлэг ан амьтныг хамгаалах үүрэгтэй эрчим хүч, тээвэр, байгаль хамгааллын яам, агентлагуудын тодорхойлох зорилгоор интернетээр хайлт хийсэн. Улмаар бид Азийн улс орнууд тус бүрд шугаман дэд бүтцийн хөгжлийг зохицуулдаг хууль тогтоомжийн зорилгоор олж тодорхойлсон яам, агентлагуудын веб сайтуудыг хайсан. Бид үндэсний яам, агентлагийн веб сайтаас олох боломжгүй мэдээлэл гэх мэт мэдээллийн дутагдалтай байдлыг шийдвэрлэхийн тулд байгаль орчны мэдээллийн сан болох ECOLEX-ийг ашигласан (ХАВСРАЛТ А: ТӨРӨЛ ЗҮЙЛ, ЭКОСИСТЕМ, БИОЛОГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛ, WFLI-ийн ХАМГААЛЛЫН ҮНДЭСНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖУУДЫГ ХАЙХ, ТОДОРХОЙЛОХ ECOLEX МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ТАНИЛЦУУЛГА). Эдгээр мэдээллийн төр засгийн байгууллагын веб сайтаас цуглуулсан, шугаман дэд бүтэцтэй холбоотой хамгаалалтыг хариуцсан агентлагуудад зориулсан хууль, удирдамжид мэдээллийн гол эх үүсвэр болдог учраас энэхүү хууль ёсны мэдээлэлд баталгаажуулах бие даасан үйл ажиллагаа шаардлагагүй.

ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН ХҮРЭЭЛЭНГҮҮД (ОУСБ-УУД)

Бид Азид шугаман дэд бүтцийн төслүүдэд идэвхтэй хөрөнгө оруулалт хийдэг 10 том ОУСБ-ыг олж тодорхойлж, биологийн төрөл зүйлтэй холбоотой тэдгээрийн хамгаалах арга хэмжээнүүдийг судалсан (Хүснэгт2). Ази дахь дэд бүтцийн хөрөнгө оруулагч бүрийг сонгохын оронд эдгээр тусгай ОУСБ-ууд нь ерөнхий болон Азийн түвшний шалгалт хийх боломжийг олгосон.

Хүснэгт2: ОУСБ-ууд болон шугаман дэд бүтцийн бусад санхүүжүүлэгчид

ХҮСНЭГТ 2: ОУСБ БОЛОН ШУГАМАН ДЭД БҮТЦИЙН БУСАД САНХҮҮЖҮҮЛЭГЧИД

Азийн Хөгжлийн Банк (АБХ)

Азийн Дэд Бүтцийн Хөрөнгө Оруулалтын Банк (AIIB)

Зүүн Өмнөд Азийн Орнуудын Холбоо (ASEAN)

Хятадын Олон Улсын Хөгжлийн Хамтын Ажиллагааны Агентлаг (CIDCA)

Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (EBRD)

Европын Хөрөнгө Оруулалтын Банк (EIB)

Олон Улсын Санхүүгийн Корпораци (IFC)

Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Агентлаг (JICA)

Шинэ Хөгжлийн Банк (NDB)

Дэлхийн Банк (WB)

Бид үндсэндээ ОУСБ-ын веб сайт, интернет дээрх бусад баримт бичгүүдээс байгаль хамгааллын мэдээллийг түүвэрлэн ашигласан. Үүнээс гадна ОУСБ-ын бодлого шийдвэр, үйл

ажиллагааг хянан шалгадаг экспертүүдийн гаргасан тайлан, холбогдох баримт бичгүүдэд интернетийн хайлт хийж, мэдээлэл цуглуулсан. ОУСБ-ын байгаль хамгаалах бодлого шийдвэрийг тодруулах, баталгаажуулахын тулд бид эдгээр 10 ОУС байгууллагын экспертүүд, ажилтнуудтай холбогдож, ярилцсан.

АЖ ҮЙЛДВЭРИЙН ХОЛБОО

Тээвэр, эрчим хүчний салбарын експерт, тэдгээрийн мэргэжлийн сүлжээний тусламжтайгаар бид Ази дахь зам, төмөр зам, эрчим хүч дамжуулах сүлжээ, барилгын инженертэй холбоотой 30 гаруй мэргэжлийн холбоог тодорхойлсон. Бид Азийн шугаман дэд бүтцийн төслийн гурван хэлбэрт Азийн төвшинд бүсийн түншлэл, олон талт эдийн засгийн хөгжлийн хоршоо, бусад санаачилгуудыг хэрэгжүүлсэн.

Эдгээр холбоодын веб сайтад хэвлэгдсэн мэдээллийн үндсэн дээр бид зэрлэг ан амьтныг хамгаалах мөн түүнчлэн байгаль хамгааллын чиглэлээр хувийн секторт сургалт зохион байгуулах, мэдээлэл өгөх зорилгоор холбоонуудын хүчин чадавхыг үнэлсэн. Тус үнэлгээнд хамгаалах арга хэмжээний чадавхыг бий болгох дөрвөн нийлүүлэлтийн механизмыг хамруулсан, үүнд ажиллах хүчний сургалт (виртуал болон биечлэн), вебинар, хэвлэлийн материал гаргах, бусад техникийн нөөц зэрэг болно.

ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУД (ТББ)

Олон улсын төрийн бус байгууллагууд: Бид Ази даяар олон улс орнуудад зэрлэг ан амьтныг хамгаалахад идэвхтэй ажилладаг байгаль орчны 13 төрийн бус байгууллагуудыг тодорхойлсон (Хүснэгт3). Бид шугаман дэд бүтцийн хөгжлийн явцад зэрлэг ан амьтныг хамгаалах одоогийн болон ирээдүйн төлөвлөсөн чадавхыг тодорхойлох зорилгоор Азийн хөтөлбөрийн тэргүүн, мөн төрийн бус байгууллагуудын тэргүүлэгч нартай холбоо барьж, 30 минутын ярилцлага хийсэн. Бид долоон асуудалд төвлөрч 11 ярилцлага хийсэн, эдгээрээс зургаа нь туслах нэмэлт тайлбартай, олон сонголттой, эцсийн асуулт нь сонгох хариулттай (ХАВСРАЛТ В: БАЙГАЛЬ ХАМГААЛЛЫН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН АСУУМЖ БА ТЭМДЭГЛЭЛ).

Хүснэгт3: Байгаль хамгааллын чиглэлээр ажилладаг, ярилцлагад хамрагдсан байгаль орчны чиглэлийн 11 төрийн бус байгууллагууд нь Ази даяар олон салбаруудтай

ХҮСНЭГТ3: БАЙГАЛЬ ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР АЖИЛЛАДАГ, ЯРИЛЦЛАГАД ХАМРАГДСАН 11 ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУД НЬ АЗИ ДАЯАР ОЛОН САЛБАРУУДАД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДГИЙГ ДООР ТАНИЛЦУУЛАВ

Олон Улсын Шувуу Судлалын Байгууллага

Олон Улсын Ургамал, Амьтны Байгууллага

Франкфуртийн Амьтан Судлалын Нийгэмлэг

Дэлхийн Зэрлэг Ан Амьтныг Хамгаалах Байгууллага

Олон Улсын Тогорууны Сан

Олон Улсын Амьтан Хамгааллын Сан

Шар ирвэс

Байгаль Хамгаалал

Лондонгийн Амьтан Судлалын Нийгэмлэг

Үндэсний төрийн бус байгууллагууд: Бид Ази даяар байгаль хамгааллын чиглэлээр ажиллаж байгаа төрийн бус байгууллагуудыг тодорхойлох зорилгоор Байгалийн Хамгаалах Олон Улсын Холбооны гишүүнчлэлийн жагсаалтыг ашигласан. Бид төслийн голлох 28 улсуудаас 24 улсад ажилладаг 239 төрийн бус байгууллагуудыг олж тодорхойлсон. Улмаар бид IUCN-ийн холбооны портал хаягаас тус байгууллагуудын үндсэн холбоо барих хаяг болох и-мэйл хаягуудыг түүвэрлэж, төрийн бус байгууллагуудын веб сайт руу зочилсон. Бид тэдгээр төрийн бус байгууллагуудын харилцах хаяг руу цахим шуудан бичиж, 16 асуулттай цахим судалгаанд хамрагдах хүсэлт гаргасан (ХАВСРАЛТ С: АЗИД ДЭД БҮТЦИЙН ЗҮГЭЭС БИОЛОГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛД ЧИГЛЭСЭН НӨЛӨӨЛЛИЙГ ШИЙДВЭРЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АЖИЛЛАДАГ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН ТАЛААРХ ЦАХИМ СУДАЛГАА). Бид цахимаар явуулсан судалгаанд оролцох хүсэлт гаргаж, тэдний хамт олны зөвлөмжийн дагуу 14 нэмэлт төрийн бус байгууллагуудтай (IUCN -ийн гишүүд биш) холбоотой. Бид цахим судалгааны хариултад дүн шинжилгээ хийх зорилгоор статистикийн үнэгүй програм болох R програмыг ашигласан. Нийтдээ 54 төрийн бус байгууллагад судалгаанд хамрагдсан.

ҮНДЭСНИЙ ТҮВШНИЙ ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭНҮҮД

ТӨЛӨӨЛӨГЧ УЛСУУДЫГ СОНГОХ

Ази даяар чадварын үнэлгээг хийсний дараа бид таван төлөөлөгч улсад байгаль хамгааллын чадавхыг үнэлэх нарийн түвшний үнэлгээг хийсэн. Эдгээр орнуудыг сонгохын тулд бид USAID-ээс хөрөнгө оруулалтын нөөцийн үйл ажиллагаа явуулж байгаа Азийн 19 орнуудын жагсаалтыг гаргасан. Бид доор заасны дагуу биологийн төрөл зүйл, шугаман дэд бүтцийн хөгжил, хөрөнгө оруулалтын олон талт байдлуудыг илэрхийлсэн 15 бүлэг асуумжаар эдгээр улс орнуудыг жагсаасан:

1. Биологийн төрөл зүйлийн үнэ цэн. Ерөнхийдөө биологийн төрөл зүйлийн категорийн үнэлгээ хийж, тус улсын ерөнхий дүгнэлтийг гаргасан:
 - a. Төрөл зүйлийн баялаг байдал,
 - b. Төрөл зүйлийн унаган нутгийн хамрах хүрээ,
 - c. Тухайн унаган нутаг дахь улсын пропорц,
 - d. Биологийн төрөл зүйлийн хөндөгдөөгүй байдал,
 - e. Тусгай хамгаалалттай статуст улсын эзлэх хувь,
 - f. Тус улсад ойт газрын эзлэх хувь.
2. Шугаман дэд бүтцийн хөгжлийн арга хэмжээ:
 - a. Бүтээн байгуулалт хийх төлөвлөсөн бүс болон замын санаачилгад (BRI) багтсан төмөр замын урт,
 - b. BRI-ийн нэмэлтээс төмөр замын нягт,
 - c. Бүтээн байгуулалт хийх BRI авто замын урт,
 - d. BRI нэмэлтээс төлөвлөсөн замын нягт,
 - e. Цахилгаан эрчим хүчинд холбогдсон хүн амын эзлэх хувь (ирээдүйн цахилгаан дамжуулах шугамаас их эсвэл бага)
 - f. Модон бүрхэвчийн алдагдал.
3. Азийн түвшний гурван хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалтын төвшин:
 - a. AIB,
 - b. АБХ, болон

с. USAID, нийт үүрэг хариуцлага.

19 улсуудыг харьцангуй үнэлгээ, жагсаалтаар тодорхойлсны дараа бүх гурван ангилалд үнэлгээний эхний байранд ямар нэгэн улс, бүлэг улс бичигдээгүй. Үүнээс эсрэгээрээ үнэлгээний олон ангилалд олон улсууд бичигдсэн. Ерөнхийдөө биологийн төрөл зүйл нь Азид экваторын бүсэд хамгийн их бөгөөд туйл руу ойртох тутам буурч байна. Иймээс хэрвээ биологийн төрөл зүйл нь төлөөлөгч улсын сонголтод хамаарах үнэ цэнэ, ач холбогдолтой бол зөвхөн тропикийн бүсийн орнуудыг сонгосон. Үүний эсрэгээр бид Азийн гурван бүсэд үнэлгээний шалгуурт суурилсан орнуудыг сонгосон, үүнд: Өмнөд Ази, Зүүн Өмнөд Ази, Төв ба Зүүн Ази зэрэг болно. Энэхүү үнэлгээний үр дүнд чадавхын нарийн түвшний үнэлгээг хийхээр Бангладеш, Энэтхэг, Монгол, Непал, Тайланд зэрэг таван орныг сонгон авсан.

СУДАЛГААНЫ ХӨГЖИЛ

Бид чадавхын үнэлгээ хийх зорилгоор SurveyMonkey™-ээр илгээсэн цахим судалгааг ашигласан. Бид чадавхын үнэлгээний зорилгоор стандарт практикийг ойлгох зорилгоор асуумжийг хөгжүүлэхэд эхлэл цэг болгон чадавхын үнэлгээнд НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн (UNDP) суурь системийг ашигласан (UNDP, 2008). Таван үндсэн салбарт мэдээлэл цуглуулахын тулд асуумжийг хөгжүүлсэн:

1. Одоогийн WFLI ба түүний ач холбогдлын хувь хэмжээ;
2. WFLI-ийн хамгаалалтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн одоогийн чадавх;
3. WFLI хамгаалалтыг хэрэгжүүлэхэд тулгарч байгаа саад бэрхшээлүүд;
4. Шугаман дэд бүтцийн хөгжлийн үйл ажиллагааны янз бүрийн үе шатанд бүрдүүлэгч бүлгийн оролцоо, хамрагдалт,
5. Ирээдүйн WFLI чадавхыг бий болгох хэрэгцээ шаардлага, хүсэл, сонголт.

Ирээдүйн чадавхыг бий болгохтой холбоотой мэдээлэл нь шаардлагатай чадавхын төрөл мөн нийлүүлэх арга зам талаасаа, бүрдүүлэгч бүлэг, улс орнуудад энэ нь хэрхэн өөрчлөгдөж байгаа бэ гэдэг нь USAID-д тусгай сонирхол юм.

Асуумжид оролцогчид эдгээр бүлэг асуумжид хариулах эцсийн шатны судалгаа нь 88 асуулттай (ХАВСРАЛТ D: АЗИЙН (LISA) ШУГАМАН ДЭД БҮТЦИЙН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЧАДАВХЫН СУДАЛГААТАЙЛАН. Судалгааны эхний хэсэг нь бүх бүрдүүлэгч дөрвөн бүлгийн оролцогчдод чиглэсэн 25 асуултаас бүрдэнэ. Зарим асуултууд нь өмнөх асуултын хариулттай холбоотой. иймээс асуумжид оролцогч зарим оролцогчид цөөвтөр асуултад хариулсан. Судалгааны хоёрдахь хэсэг нь бүрдүүлэгч бүлэг нь асуумжид өөрөө тодорхойлсон эсэхээс шалтгаалж харилцан адилгүй байсан. Төр засгийн байгууллагуудын бүрдүүлэгч бүлэг 10 нэмэлт асуултад хариулах ёстой: жишээ нь ОУСБ нь 16 асуултад, төрийн бүс байгууллагууд нь долоон асуултад хариулах ёстой.

СУДАЛГААНЫ ОРОЛЦОГЧДЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Азийн түвшний үнэлгээгээр тус судалгаа нь дөрвөн бүрдүүлэгч бүлгийн аль нэгийг илэрхийлсэн байгууллага руу чиглэсэн. эдгээр дөрөв нь ОУСБ, аж үйлдвэр, төр засгийн байгууллага, төрийн бүс байгууллага зэрэг болно. Тус судалгаанд төлөвлөсөн оролцогчдыг хамруулахын тулд төлөөлөгч улс орон бүрд шугаман дэд бүтцийн хөгжлийн үйл ажиллагаанд хамрагдсан үндсэн оролцогчдыг тодорхойлох зорилгоор суурь нөхцлийг бүрдүүлсэн (

ХАВСРАЛТ Е: СУДАЛГААНЫ ХҮРЭЭНД ХОЛБОГДОХ). Бид үнэлгээнд тусламж дэмжлэг үзүүлэхийн тулд таван төлөөлөгч улс тус бүрд экспертүүдийг (манай үндэсний хамтын ажиллагаа) авч ажиллуулсан. Үндэсний хамтын ажиллагаа болон тухайн улсын USAID-ийн зорилтын үндсэн дээр бид бүрдүүлэгч бүлэг тус бүрд доорх төрлийн оролцогчдод зориулж харилцах мэдээллийг түүвэрлэсэн:

1. ОУСБ-ууд: шугаман дэд бүтцийн төслийн хяналт, үнэлгээний тайлан, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (ESIAs) хариуцсан ажилтнууд. Эдгээр ажилтнуудыг олон талт хөгжлийн банкны Азийн Оффис, төлөөлөгч улсын аль нэгэнд нь байрлуулсан.
2. Төр засгийн газар: байгаль орчин, дэд бүтэц, эрчим хүчний агентлаг, яамны ажилтан, мөн байгаль орчны зөвшөөрлийн чиглэлээр ажилладаг мэргэжилтнүүд. Бусад ажилтнуудын хувьд үндэсний хөгжлийн зорилтын хүрээнд зэрлэг ан амьтныг хамгаалах заалтуудыг багтаасан дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын гэрээнүүдийг засгийн газрын төвшинд дагаж мөрдөх үүрэг хариуцлагыг хэрэгжүүлдэг.
3. Аж үйлдвэр: дэд бүтцийн төлөвлөгөө гаргагчид, инженер, барилгын компанийн төлөөлөл, мөн түүнчлэн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний зөвлөхүүд.
4. Төрийн бус байгууллагууд: төлөвлөсөн үйл ажиллагаа нь шугаман бүтцээс зэрлэг ан амьтанд үзүүлэх нөлөөлөл, эсвэл үндэсний байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний гуравдагч талын хяналтад анхаарлаа хандуулдаг байгууллагууд. Эдгээр үйл ажиллагаанд байгаль хамгааллын ажилтнуудыг хамруулах зорилготой. Энэ ангилалд төрийн бус судалгааны төв, их сургуулиудын судалгаануудыг багтаасан. эдгээр нь орон нутгийн хүн ам, зэрлэг ан амьтан, шугаман дэд бүтэц, нийгэмтэй зохицон үйл ажиллагаа явуулдаг.

Бүх таван орнуудын хэмжээнд 840 төлөвлөгөөт оролцогчдыг тодорхойлсон (Хүснэгт4). Мөн бид таван төлөөлөгч улсаас гадна бүсийн оффис, удирдлага дахь ОУСБ-ын харилцах нэмэлт хаягуудыг олж тодорхойлсон. Байгаль хамгааллын чиглэлээр ажилладаг бусад холбогдох хүмүүст, эсвэл мэргэжлийн экспертүүдэд үндэсний судалгааг танилцуулах, хуваалцахыг бүх оролцогчдоос хүссэн учраас тус судалгаанд хамрагдсан хүмүүсийн бодит тоог гаргахад хэцүү юм.

Хүснэгт4: Цахим судалгааны төлөвлөгөөт оролцогчдын нийт тоог бүрдүүлэгч бүлэг ба улсаар нь тодорхойлсон байдал

ХҮСНЭГТ 4: ЦАХИМ СУДАЛГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨТ ОРОЛЦОГЧДЫН НИЙТ ТООГ БҮРДҮҮЛЭГЧ БҮЛЭГ БА УЛСААР НЬ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ						
Төлөөлөгч улс орнууд Бүрдүүлэгч бүлгүүд	Энэтхэг	Непал	Бангладеш	Тайланд	Монгол	Нийт
ОУСБ ба дотоодын санхүүжүүлэгчид	27	18	_*	_*	6	51
Аж үйлдвэрийн холбоо	40	59	21	32	30	182
Засгийн газар ба агентлагууд	71	173	58	91	59	452
Төрийн бус байгууллагууд	15	59	21	41	19	155
Нийт	153	309	100	164	114	840

*Бангладеш болон Тайландад холбогдох ОУСБ-ын төлөөлөл тодорхойлогдоогүй

СУДАЛГААГ ОЛОН НИЙТЭД ТАРААХ

Хариултын төвшин, судалгааны оролцоог нэмэгдүүлэхийн тулд бид доор заасан үнэлгээний системийн дагуу бүх тодорхойлсон харилцах хаягууд руу судалгааг тараахаар төлөвлөсөн:

1. Улс орнуудын USAID-ийн зорилт, бүсийн үйл ажиллагааны баг, төслийн ажилтнуудын хаяг руу судалгаанд оролцох албан ёсны хүсэлтийг цахимаар явуулсан.
2. USAID-ийн зорилт, үндэсний баг, төслийн ажилтнуудтай холбогдох хаягууд руу албан ёсны и-мэйл илгээгдэж, судалгааг хүлээн авч, үндэсний ажлын хэсгээс утсаар дуудлага хийсэн.
3. Төр засгийн байгууллага, аж үйлдвэрийн байгууллагын удирдлагын харилцах хаягуудад судалгаанд оролцохыг хүссэн цахим хүсэлтийг илгээгдэж, судалгаанд оролцох утасны ярилцлагыг санал болгож, үндэсний ажлын хэсгээс утасны дуудлага хийгдэнэ.
4. Тухайн улс оронд USAID-ийн зорилтоор дамжуулан харилцах шаардлагатай удирдах албан тушаалтнуудын хаягуудаар USAID-ийн албан ёсны танилцуулгаар дамжуулан судалгаанд оролцох хүсэлт илгээгдэж, түүний дараа үндэсний ажлын хэсгээс шаардлагатай бол дагалдах и-мэйл, утасны ярилцлага хийгдэнэ.

Судалгааг тараах төлөвлөгөөт өдөр Азийн олон оронд, тухайлбал төлөөлөгч таван улсад КОВИД-19-ийн хоёрдахь давалгаа тохиолдсон. Иймээс тухайн улс орон дахь үндэсний ажлын хэсэг, USAID-ийн зорилттой нягт хамтран ажиллаж судалгааны мэдээллийг дахин тараах талаар төлөвлөлт хийгдсэн. Иймээс бид КОВИД-19-ийн улмаас үүссэн нөхцөл байдалд тохируулан, орон нутгийн нөхцөл байдал, судалгааны оролцогчдын оролцох боломж зэргийг харгалзан үзэж судалгааг тараах ажлыг зохион байгуулсан. Таван улс тус бүрийн нөхцөл байдал, өдөр тутмын мэдээллээс гадна үндэсний ажлын хэсэг улс орон бүрд судалгааны 30 харилцах хаягийг тодорхойлж, жагсаалт гаргасан, цар тахалд нэрвэгдсэн улс орнууд, үндэсний хэмжээний хорио цээр бүхий орнуудад боломж, чадавх буурч байгааг харгалзан үзэж

цаашдын нэмэлт арга хэмжээ авах шаардлагатай эсэхийг тодорхойлох зорилгоор энэхүү жагсаалтыг ашигласан.

Доорх мэдээлэл бол төлөөлөгч таван улсад энэхүү чадавхыг үнэлэх судалгааг эцсийн байдлаар тараасан тухай мэдээлэл юм:

1. Энэтхэг: Судалгааг тараах ажил олон удаа хойшилсон, цар тахлын улмаас засгийн газартай холбогдохыг эрмэлзсэн, засгийн газрын зүгээс хариу мэдэгдэх нь бага байсан. Бусад улс орнуудтай харьцуулахад бүрдүүлэгч бүлэг тус бүрд хариултын төвшин бага байсан.
2. Бангладеш: судалгааг тараах ажил төлөвлөгөөний дагуу хийгдсэн боловч хариултыг хялбархан цуглуулахын тулд утсаар өргөн хэмжээний ярилцлага хийх шаардлага тулгарсан. Аж үйлдвэрээс хариулт онцгойлон бага байлаа.
3. Монгол: Хөл хорио, карантины улмаас судалгааг тараах ажил хойшлогдсон боловч төлөвлөгөөний дагуу хийгдсэн. Судалгааны асуултуудыг Монгол хэл рүү орчуулж, мэдээлэл цуглуулах зорилгоор цахим судалгаа хийгдсэн.
4. Непал: Непалд цар тахлын давалгаа эхлэхээс өмнө төлөвлөсөн ихэнх оролцогчид рүү судалгааг тараасан, хариултын төвшин харьцангуй өндөр байлаа.
5. Тайланд: судалгааг тараах ажил хойшлогдсон боловч төлөвлөгөөний дагуу хийгдсэн. Судалгааны асуултуудыг Тай хэл рүү орчуулж, мэдээллийг хялбархан цуглуулах зорилгоор цахимаар судалгааг хийсэн.

Хариултыг бүрэн, тодорхой байх, асуумжид хариулсан хүмүүсийг танилцуулахгүй байхыг судалгааны оролцогчдоос хүссэн. Харилцах хүмүүсийн жагсаалтад багтсан хүмүүс зарим нь эрх бүхий этгээд биш, бүрэн мэдээлэлтэй биш гэдгийг харгалзан үзэж судалгаа хүлээн авагчид судалгааг хамт олондоо танилцуулахыг зөвшөөрсөн. Судалгаа гурван долоо хоногийн хугацаанд нээлттэй байсан. Судалгаанд оролцохыг сануулж гурван долоо хоногийн хугацаанд харилцах хаягууд руу хоёр удаагийн имэйл захидал явуулсан. Судалгааны 2021 оны зургаадугаар сарын 26-ны өдөр хаагдсан. Бид судалгааны хариултыг нэгтгэн дүгнэх зорилгоор статистикийн R програмыг ашигласан.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ОЛОН ТАЛТ ГЭРЭЭ (MEAS) БОЛОН ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖУУД

МЕА -ийн оролцогч улс орнууд гэрээг хэрхэн хэрэгжүүлж байгааг сайн ойлгохын тулд төлөөлөгч таван улсад WFLI арга хэмжээ, биологийн төрөл зүйл, эко систем, төрөл зүйлийг хамгаалахтай холбоотой үндэсний хууль тогтоомж, бодлого зохицуулалтын талаар нэмэлт судалгаа хийсэн. ECOLEX мэдээллийн санг ашиглан бид WFLI, төрөл зүйл, эко систем, биологийн төрөл зүйлтэй холбоотой үндэсний хууль тогтоомжийн механизм, сүүлийн үед батлагдсан баримт бичгүүдийг олж тодорхойлсон. Судалгааны өндөр нарийвчлалыг хангах зорилгоор үнэлгээнд зориулан цуглуулсан мэдээллийг хянан шалгах зорилгоор төлөөлөгч улс орон бүрийн хууль эрх зүйн эксперт рүү гарсан үр дүнгийн мэдээлэл, жагсаалтыг явуулсан (ХАВСРАЛТ А: ТӨРӨЛ ЗҮЙЛ, ЭКОСИСТЕМ, БИОЛОГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛ, WFLI-ИЙН ХАМГААЛЛЫН ҮНДЭСНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖУУДЫГ ХАЙХ, ТОДОРХОЙЛОХ ECOLEX МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ТАНИЛЦУУЛГА).

АЗИЙН ТҮВШНИЙ ҮР ДҮН БА ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

ЗАСГИЙН ГАЗАР БА АГЕНТЛАГ

ОЛОН УЛСЫН ГЭРЭЭНҮҮД

Зэрлэг ан амьтныг хамгаалах олон талт, өргөн хүрээтэй асуудалтай холбоотой олон улсын MEA-ийг төслийн зорилгоор хянан шалгасан. Тэдгээрт дараах гэрээ хэлэлцээрүүд багтана, үүнд: Биологийн янз байдлын тухай конвенц (CBD), Дэлхийн Өвийн Конвенц (WHC), Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES), Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлийг хамгаалах тухай томоохон конвенц (CMS), Олон Улсын Ургамал Хамгаалах Конвенц (IPPC), ХХААУГН-ийн тухай олон улсын гэрээ хэлэлцээр (ITPGRFA), Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц (Рамсар). Эдгээр MEA гэрээ хэлэлцээрт гишүүнээр элсэнэ гэдэг нь зэрлэг ан амьтныг хамгаалах тухай олон улсын хамтын ажиллагаанд өөрийн улс орны үйл ажиллагаа, зорилго, амлалтыг илэрхийлэх, улс орондоо нэмэлт шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх, олон улсын үүрэг, амлалтыг үндэсний хууль тогтоомж, зохицуулалт, бодлого, шийдвэр, үндэсний стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөрт тусгах, үндэсний төвшинд хэрэгжилт, хяналтыг хангахыг шаардана (Mitchell, 2003). Энэхүү судалгааны зорилгоор тодорхойлогдсон Азийн бүх 28 улс орнууд CBD ба WHC -ийн оролцогч талууд юм (Хүснэгт5). 12 улс орны гишүүнчлэл бүхий CMS-ээс гадна бусад дөрвөн MEA-нь Азийн хэмжээнд өндөр гишүүнчлэлтэй байлаа.

Долоон улс орон (Бангладеш, Энэтхэг, Киргизстан, Монгол, Пакистан, Филиппин, Шри Ланка) нь CMS болон түүний нэмэлт гэрээнүүд зэрэг бүх долоон MEA-д гишүүнээр элссэн. Зөвхөн хоёр улс (Бруней ба Зүүн Тимор) гурав хүртэлх гэрээнд элссэн.

Хүснэгт5: Долоон үндсэн MEA-д элсэн орсон орнууд

ХҮСНЭГТ 5: ДОЛООН ҮНДСЭН MEA-Д ЭЛСЭН ОРСОН ОРНУУД							
ОЛОН УЛСЫН MEA	CBD	WHC	CITES	CMS	IPPC	ITPGRFA	Рамсар
Афганистан	Х	Х	Х	Х	Х	Х	
Бангладеш	Х	Х	Х	Х	Х	Х	Х
Бутан	Х	Х	Х		Х	Х	Х
Бруней	Х	Х	Х				
Камбож	Х	Х	Х		Х	Х	Х
Хятад	Х	Х	Х		Х		Х
Энэтхэг	Х	Х	Х	Х	Х	Х	Х
Индонез	Х	Х	Х		Х	Х	Х
Япон	Х	Х	Х		Х	Х	Х
Казахстан	Х	Х	Х	Х	Х		Х
Киргизстан	Х	Х	Х	Х	Х	Х	Х
Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс	Х	Х	Х		Х	Х	Х
Малайз	Х	Х	Х		Х	Х	Х
Монгол	Х	Х	Х	Х	Х	Х	Х
Мьянмар	Х	Х	Х		Х	Х	Х
Непал	Х	Х	Х		Х	Х	Х

ХҮСНЭГТ 5: ДОЛООН ҮНДСЭН МЕА-Д ЭЛСЭН ОРСОН ОРНУУД

ОЛОН УЛСЫН МЕА	CBD	WHC	CITES	CMS	IPPC	ITPGRFA	Рамсар
Хойд Солонгос	X	X			X	X	X
Пакистан	X	X	X	X	X	X	X
Филлипин	X	X	X	X	X	X	X
Өмнөд Солонгос	X	X	X		X	X	X
Сингапур	X	X	X		X		
Шри Ланка	X	X	X	X	X	X	X
Тажикстан	X	X	X	X	X		X
Тайланд	X	X	X		X	X	X
Зүүн Тимор	X	X					
Туркменистан	X	X		X			X
Узбекистан	X	X	X	X	X		X
Вьетнам	X	X	X		X		X

“X”-тэй нүднүүд нь олон улсын МЕА-д элссэн болохыг илтгэнэ

Одоогийн тодорхойлогдсон 12 улс оронтой харьцуулахад илүү олон улс орон CMS-д хамрагдаж чадвал зарим улс орон, бүсийн төвшинд WFLI арга хэмжээнүүдийг илүү нарийн зохион байгуулах, амжилтад хүрэх боломж, бололцоо бүрдэнэ. CMS гэдэг нь нүүдлийн төрөл зүйл, тэдний амьдрах нутаг дэвсгэр, нүүдлийн маршрутыг хамгаалах тухай дэлхийн конвенц юм. CMS-д элсэн орсон улс орнууд биологийн олон төрөл зүйл, тэдгээр төрөл зүйлийн амьдралын циклийн явцад нүүдэллэх, түр зогсох нутаг дэвсгэрийг хамгаалах, тэдний нүүдэлд тулгарч шугаман дэд бүтэц зэрэг саад бэрхшээл, сөрөг нөлөөллийг шийдвэрлэхэд үндэсний хууль эрх зүйн механизмыг сайжруулахад чухал ач холбогдолтой.

ҮНДЭСНИЙ АГЕНТЛАГУУД

Гурван төрлийн шугаман дэд бүтцийн (төмөр зам, авто зам, цахилгаан дамжуулах шугам) нөлөөллөөс зэрлэг ан амьтныг хамгаалах, мөн байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх, зэрлэг ан амьтныг хамгаалалтыг бий болгох хууль тогтоомж, удирдамж, зөвлөмжтэй эсэх, мөн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох шугаман дэд бүтцийн төлөвлөгөө, төслийн үйл ажиллагаа эсэхийг тодорхойлох зорилгоор Азийн 28 улс орон тус бүрд тус бүрчлэн үнэлгээ хийсэн. Авто зам, төмөр зам, БОНБУ-ний хувьд зэрлэг ан амьтныг хамгаалах талаар заалт бүхий хууль тогтоомжтой орнуудын тоо нь зөвлөмж удирдамж бүхий орнуудын тооноос бага зэрэг илүү байна, мөн тэнцүү тооны улс орнууд цахилгаан дамжуулах шугамын чиглэлээр холбогдох хууль, удирдамж, зөвлөмжийг хэрэгжүүлдэг (

Хүснэгт6).

Хүснэгт6: Шугаман дэд бүтцийн төрөл, БОНБУ-тэй холбоотой үндэсний хууль тогтоомж болон удирдамжийн зонхилох хувьд суурилсан улс орны түвшний үнэлгээ

ХҮСНЭГТ 6: ШУГАМАН ДЭД БҮТЦИЙН ТӨРӨЛ, БОНБУ-ТЭЙ ХОЛБООТОЙ ҮНДЭСНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖ БОЛОН УДИРДАМЖИЙН ЗОНХИЛОХ ХУВЬД СУУРИЛСАН УЛС ОРНЫ ТҮВШНИЙ ҮНЭЛГЭЭ

	+1	Оруулсан	+0,5	Оруулсан байх магадлалтай	0	Оруулаагүй болно	0	Боломжгүй мэдээлэл	
	БОНБУ		ЗАМ		ТӨМӨР ЗАМ		ЦАХИЛГААН ШУГАМ		Оноо
Улс орон↓	Хууль	Удирдамж	Хууль	Удирдамж	Хууль	Удирдамж	Хууль	Удирдамж	
Энэтхэг									8
Япон									8
Монгол									8
Өмнөд Солонгос									8
Тажикстан									8
Бангладеш									8
Малайз									8
Зүүн Тимор									8
Туркменистан									7
Непал									7
Хятад									6
Узбекистан									6
Бутан									5
Афганистан									5
Казахстан									5
Бруней									4
Шри Ланка									4
Пакистан									4
Тайланд									4
Камбож									2
Индонез									2
Вьетнам									1
Сингапур									1
Мьянмар									0
Лаос									0
Киргизстан									0
Хойд Солонгос									0
Филлипин									0
Нийт	19	18	18	17	15	14	12	12	

Эдгээр 28 улс орноос найман улс (Бангладеш, Энэтхэг, Япон, Малайз, Монгол, Өмнөд Солонгос, Тажикистан, Зүүн Тимор) авто зам, төмөр зам, цахилгаан дамжуулах шугам дагуу биологийн төрөл зүйлийг хамгаалах болон БОНБУ-тэй холбоотой хууль тогтоомж, удирдамж, зөвлөмжтэй байна. Манай үр дүнгээс харахад олон улс орнууд нь шугаман дэд бүтцийн

нөлөөллөөс зэрлэг ан амьтныг хамгаалах тухай цаашдын ирээдүйн заалтад хамгийн чухал эхлэл цэг болж чадах БОНБУ-ний дор хаяж нэг хууль тогтоомжтой байна.

Шугаман дэд бүтцийн бүх төрлүүдийн дотор авто замын салбар Азидаа хамгаалалтын арга хэмжээ хамгийн өрдөн төвшинд байгаа, (тухайлбал 18 улсад) хууль тогтоомжтой, (17 улсад) зөвлөмж, удирдамжтай байна, харин цахилгаан дамжуулах шугамын салбарт энэ үзүүлэлт бага хувтай байна (тухайлбал хууль тогтоомж, зөвлөмж удирдамжтай улс 12 байна). БОНБУ үйл ажиллагааны хүрээнд биологийн төрөл зүйлийг хамгаалах хууль, зөвлөмж удирдамж хамгийн өндөр хувийг буюу 19 орон энэ чиглэлийн хуультай, 18 зөвлөмж удирдамжтай. Гэхдээ зарим мэдээллийг онлайнаар харах, танилцах боломжгүй учраас WFLI-ийг дэмжих хууль эрх зүйн тогтолцоотой холбоотой нэмэлт судалгаа хийх шаардлагатай. Мэдээлэл олох боломжгүй тохиолдолд тухайн улс орнуудад хууль эрх зүйн ямар төвшинд байгааг тайлбарлах, дүгнэх боломжгүй.

ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУД (ОУСБ), ШУГАМАН ДЭД БҮТЦИЙН БУСАД САНХҮҮЖҮҮЛЭГЧИД

Хяналт шалгалтдаа бид Азид шугаман дэд бүтцийг санхүүжүүлдэг бүсийн эдийн засгийн байгууллагууд, ОУСБ-ууд байгууллагуудыг хянан шалгасан (Хүснэгт2). Эдгээр байгууллага тус бүрийн байгаль орчны болон нийгмийн хамгааллын систем нь Дэлхийн Банкны (WB) бүлэг, Олон Улсын Санхүүгийн Корпорацын (IFC) Үйл Ажиллагааны Стандарт (PS) болон бусад холбогдох байгууллагуудын байгаль хамгааллын үйл ажиллагаатай ерөнхийдөө нийцдэг.

Үйл ажиллагааны стандартын удирдах, зохион байгуулах үйл ажиллагааг Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа Хөгжлийн Байгууллага (OECD) болон түүний бүрэлдэхүүн дахь Хөгжлийн Түслэмж Дэмжлэгийн Хороо үндсэндээ хэрэгжүүлдэг. Бараг бүх ОУСБ-ын байгаль хамгаалал ба нийгэм хамгааллын системд ОУСБ-ын PS 6 (Box 1)-д суурилсан биологийн төрөл зүйл, байгалийн нөөцийн тогтвортой менежементэд (

Хайрцаг 1: IFC PS 6 - Байгалийн Амьд Нөөцийн Тогтвортой Менежмент, Биологийн Төрөл Зүйлийг Хамгаалах
Гүйцэтгэлийн стандарт (PS) 6 нь тогтвортой хөгжилд биологийн олон янз байдал, экосистемийн үйлчилгээ, амьд байгалийн нөөцийн хамаарлыг хүлээн зөвшөөрдөг. Энэ нь байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийг тодорхойлох үйл ажиллагаанд ач холбогдолтой. Шаардлага нь өөрчлөгдсөн, байгалийн болон нэн чухал амьдрах орчны төслүүдэд хамаарна; эсвэл үйлчлүүлэгчийн удирдлага, нөлөөн дор экосистемийн үйлчилгээнд үзүүлэх нөлөөлөл бүхий амьдрах орчинд хамаардаг, эсвэл амьд байгалийн

Хүснэгт7) чиглэсэн стандартуудтай байна. Гэхдээ Азийн Хөгжлийн Банк болон Азийн Дэд Бүтцийн Хөрөнгө Оруулалтын Банк (AIIB) найман IFC PS-ийг өөрийн үйл ажиллагааны гурав ба дөрвөн стандартад багтаан нэгтгэсэн, тэдгээр нь байгаль орчинтой холбоотой бүх стандартуудыг олон дэд хэсэг бүхий нэг иж бүрэн стандартад нэгтгэсэн. PS баримт бичгүүд нь маш өргөн хүрээтэй, их хэмжээтэй учраас манай дүн шинжилгээ нь ОУСБ-уудыг байгаль хамгааллын нэр томьёон дахь зөрүүтэй зүйлсийг тодорхойлох зорилт тавиагүй. Харин үүний оронд бид ОУСБ болон санхүүжүүлэгч байгууллагуудад зориулж хамгаалалтын янз бүрийн төрлүүдэд хамаарах заалтуудыг судалсан. Бидний үзэж байгаагаар эдгээр заалтууд нь дэлхийн банк, агентлагийн зорилттой холбоотой биш, "холбогдох заалт" гэж нэрлэгдсэн заалтуудыг багтаагаагүй гэдгийг дурдах нь зүйтэй (Хүснэгт 7-ийг үзнэ үү).

Энэ үнэлгээнээс харахад ОУСБ байгууллагууд дэд бүтцийн чиглэлээр сайн дурын зөвлөмж баримт бичгүүдийг хөгжүүлсэн боловч тэд авто зам, төмөр зам, цахилгаан дамжуулах шугам зэрэг шугаман дэд бүтцийн гурван төрөлтэй холбоотой зэрлэг ан амьтныг хамгаалах албан

ёсны стандартыг хөгжүүлсэн гэх баталгаа, нотолгоо байхгүй байлаа. Зэрлэг ан амьтныг хамгаалах стандартын оронд ОУСБ нь авто зам, төмөр зам, цахилгаан дамжуулах шугамын чиглэлээр сайн дурын, салбарын өвөрмөц, дэд бүтцийн тусгай удирдамжийн томоохон баримт бичиг болох Дэлхийн Банкны Байгаль Орчин, Эрүүл Мэнд, Аюулгүй Байдлын (EHS) удирдамжийг байнга ашигладаг. Азийн хөгжлийн банк нь зэрлэг ан амьтан болон тээврийн дэд бүтцийн чиглэлээр удирдамж гарын авлагыг(Asian Development Bank, 2019) мөн хөгжүүлсэн, өмнө нь дурдсаны дагуу Дэлхийн Банк зэрлэг ан амьтан, дэд бүтцийн удирдамж гарын авлагыг хөгжүүлэх зорилгоор Энэтхэгийн Зэрлэг Ан Амьтныг Хамгаалах Хүрээлэнд дэмжлэг түслалцаа үзүүлсэн(Wildlife Institute of India, 2016). EHS удирдамж зөвлөмж нь бүх төрөл, ангилалд дэд бүтцийн бүтээн байгуулалтын бараг бүх үйл ажиллагаанд түгээмэл хамаарах бохирдлын эх үүсвэр, түүний хяналт зэрэг байгаль орчны асуудлуудад анхаарлаа хандуулдаг. Гэхдээ EHS удирдамж, зөвлөмж нь зэрлэг ан амьтанд нөлөөлөл бүхий сайт, талбай, түүний ойр орчин дахь нутгийн экологийн хүчин зүйлсийг авч үздэггүй.

Хүснэгт7: Зэрлэг ан амьтныг хамгаалах чиглэлээр Азийн түвшний ОУСБайгууллагуудын заалтууд

ХҮСНЭГТ 7: ЗЭРЛЭГ АН АМЬТНЫГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР АЗИЙН ТҮВШНИЙ ОУСБ БАЙГУУЛЛАГУУДЫН ЗААЛТУУД ХЯНАН ШАЛГАСАН БАРИМТ МАТЕРИАЛУУД																		
Азийн түвшний ОУСБ-ууд ↓	ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНҮҮД																	
	Байгаль Хамгаалал							Байгалийн ба Нийгмийн Нөлөөллийн Үнэлгээ	Бүс нутгийн төлөвлөглт	Чадавхыг бий болгох	Улс Орны Байгаль Хамгаалалттай Уялдуулах Хөтөлбөр	Стратегийн Төлөвлөгөө	Салбарын Төлөвлөгөө ба Хөтөлбөр		Кэйс Судалгаа ба Туршилтын Төслийн Танилцуулгач	Дэд Бүтцийн Хөрөнгө Оруулалт		
													Эрчим хүч	Тээвэр				
	Зэрлэг Ан Амьтан ба Биологийн	Шугаман дэд бүтэц																
		Ерөнхий	Авто зам	Төмөр зам	Цахилгаан Дамжуулах													
Цаг уурын өөрчлөлт	Ерөнхий	Дамжуулах	Төмөр зам	Авто зам	Ерөнхий	Зэрлэг Ан Амьтан ба Биологийн	Цаг уурын өөрчлөлт	Ерөнхий	АХБ	АИИБ	ASEAN	CIDCA*	EBRD	EIB	IFC	JICA*	NDB	WB

Тайлбар: Ногоон: хамрагдсан заалт, Шар: бараг хамрагдсан заалт, Саарал: уялдаа холбоогүй болон хамрагдаагүй заалт

*CIDCA ба JICA нь маш олон шугаман дэд бүтцийн төслүүдэд хөрөнгө оруулалт хийдэг, гэхдээ судалгаанаас их мэдээлэл авах боломжгүй

Энэхүү үнэлгээнээс харахад бодит байдалд бүх ОУСБ-ууд нь зээлдэгчдийг өөрийн байгууллагын эсвэл хүлээн авагч улсын байгаль хамгааллын бодлогыг мөрдөхийг шаарддаг. Гэхдээ томоохон ОУСБ байгууллагууд (Дэлхийн Банк, Азийн Хөгжлийн Банк гэх мэт) буцалтгүй тусламж, техникийн тусламж, сургалт, мэдлэгийг удирдах арга хэрэгслийн тусламжтайгаар байгаль хамгааллын хууль зохицуулалтыг мөрдөн ажилладаг. Тэдгээр байгууллагууд хүлээн авагч улсын байгаль хамгааллын бодлогыг мөрдөн ажиллахыг хичээдэг. Зарим шинэ ОУСБ байгууллагууд эдгээр өртөг шингээсэн үйл ажиллагаа, багаж арга хэрэгслээр хангаж эхэлж

байна. Харин өнгөрсөн хугацаанд холбогдох байгаль хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор чадавх олгохын тулд зээлдэгч нарт илүү шаардлага, найдвар тавьж байсан.

Ихэнх олон улсын хөгжлийн банкнууд стратегийн, хөтөлбөрийн, бүсийн, салбарын, ерөнхий нөлөөллийн үнэлгээ зэргийг багтаасан өргөн хүрээний ESIA-ийг санхүүжүүлдэг. Эдгээр араг хэрэгслүүд нь зарим нэг төслүүдэд мэдээллээр хангах зорилгоор зохих төвшинд тогтвортой хөгжил, уян хатан байдал, биологийн төрөл зүйл, бусад экологийн асуудалд чиглэдэг.

Энд бид Азид хятадын санхүүжүүлсэн шугаман дэд бүтцийн удирдлага, байгаль орчны удирдлагын талаар товч танилцуулга хийлээ. Онлайн судалгаа, экспертийн ярилцлагаас мэдээллийг цуглуулав (Хайрцаг 2).

ХАЙРЦАГ 2: ХЯТАД УЛСАД ДЭД БҮТЦИЙН ТОМООХОН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ БОЛОХ ХЯТАД УЛСАД ЗЭРЛЭГ АН АМЬТАНД ЭЭЛТЭЙ ШУГАМАН ДЭД БҮТЦИЙН ЧАДАВХЫГ ХӨГЖҮҮЛЭХ, БАЙГАЛЬ ОРЧНЫ УДИРДЛАГА, ЗАСАГЛАЛ, ХӨГЖЛИЙН ТУСЛАЛЦАА НЬ

ТАНИЛЦУУЛГА

дэлхий дахинд эдийн засгийн нөлөөллөө эрчимжүүлж, улс орнуудад ямар шугаман дэд бүтцийг, хаана, хэрхэн байгуулахад оролцдог. 2013 онд эхэлсэн дэлхийн дэд бүтцийн томоохон санаачилгуудын нэг болох Хятадын Бүс Ба Зам Санаачилга (BRI) нь Ази даяар хуурай газар, усан замыг холбосон тээвэр, аяллын өргөн уудам коридор байгуулах, Африк, Европ, Латин Америктай Ази тивийг холбохыг эрмэлздэг. BRI төслүүд нь төмөр зам, дамжуулах хоолой, авто зам, хилийн боомтууд зэрэг салбаруудыг багтаасан. BRI нь 2013 онд эхэлсэн цагаасаа 2020 оныг хүртэлх хугацаанд Хятад улс зээл, хөгжлийн тусламж хэлбэрээр 755 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийж, төслийн бүтээн байгуулалт нь Азид хэрэгжүүлж байгаа нийт хөрөнгө оруулалтын 50 орчим хувьд BRI-ийн хүлээн авагч орнуудыг хамарсан (C. WANG, 2020). Эдгээр болон цаашид хэрэгжүүлэх BRI төслүүд Азийн олон оронд биологийн төрөл зүйлд хүчтэй сөрөг нөлөө үзүүлнэ. Бид Ази даяар дэд бүтцийн хөгжлийн хөрөнгө оруулалтын зэрэгцээ WFLI-ийн хамгаалалтыг хэрэгжүүлэхэд Хятадын санхүүгийн хэд хэдэн байгууллагуудыг үнэлэн дүгнэсэн. Бид Хятадын гадаадын тусламжийн агентлаг болон Хятадын Олон Улсын Хөгжлийн Хамтын Ажиллагааны Агентлаг (CIDCA), Хятадын тэргүүлдэг олон улсын хөгжлийн банк болох AIIB, Шинэ Хөгжлийн Банк (NDB), мөн түүнчлэн олон улсын хамгийн дэд бүтцийн чухал санаачилга болох BRI, Хятадын Экологи, Байгаль Орчны Яам, BRI-ийн Ногоон Хөгжлийн Эвсэл (BRIGC)-ийн хэрэгжүүлдэг байгаль орчин, эко систем, зэрлэг ан амьтан, биологийн төрөл зүйлийн хамгаалалттай холбоотой байгаль хамгааллын бодлого шийдвэр, үйл ажиллагааг шинжлэн судлав. Хятад улс нь хоёр талт хөгжлийн банкууд (жишээ нь Хятадын Хөгжлийн Банк, Хятадын Экспорт-Импортын Банк гэх мэт [Liu et al., 2020]) тэргүүлэн оролцдог, эдгээр байгууллагууд нь байгаль хамгааллын өөрийн гэсэн бодлоготой учраас тэдгээрийг энэхүү үнэлгээнд хамруулаагүй.

Бид Хятад улсын зэрлэг ан амьтныг хамгаалах чадавхыг үнэлэх судалгаандаа доорх аргуудыг ашигласан: (1) холбогдох санаачилга, байгууллагын веб сайтаас тэдний бодлого шийдвэр, зөвлөмж удирдамж, хэвлэлийн материалыг судалсан (2) зургаан судалгаа, судалгааны материал, тайланг цуглуулж, хянан шалгасан, (3) Хятадын санхүүгийн хүрээлэн, эвсэл, холбоо, гурван зөвлөх байгууллага зэрэг 13 мэргэжилтнүүдтэй утсаар ярилцах, цахим захидал явуулж, ганцаарчилсан уулзалт хийсэн.

ХЯТАДЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО БОЛОН ЗАСАГЛАЛ

Хятадын засгийн газрын дэмжлэг тусалцаа, хөрөнгө оруулалтыг хамруулан байгаль орчны удирдлагыг үнэлэн дүгнэхийн тулд Хятадын гадаадын хөгжлийн хөтөлбөрийн үйл ажиллагаа, байгууллагын тогтолцоог судлах нь чухал юм. BRI-д хамгийн их уялдаа холбоотой ажилладаг Хятадын хоёр талт тусламжийг удирдан зохицуулдаг дөрвөн бодлого шийдвэр, хууль тогтоомж байна. Нэгдүгээр хууль тогтоомж бол "Бүс ба Замын Экологийн Ба Байгаль Орчны Хамтын Ажиллагааны Төлөвлөгөө" нэртэй өндөр төвшний стратегийн баримт бичиг. Энэ баримт бичиг нь тогтвортой, ногоон, байгаль орчин, экологид ээлтэй дэд бүтцийн талаарх бодлого шийдвэр, төлөвлөгөө, хөтөлбөр, төслүүдийг тодорхойлсон. Энэ нь ногоон хөгжлийг онцлох сэдэв болгон авсан боловч байгаль хамгааллын асуудлыг тусгайлан ач үзээгүй (MEE, 2017b).

Хоёрдугаар зохицуулах баримт бичиг бол "Бүс ба Замыг Хөгжүүлэхэд Ногоон Хөрөнгө Оруулалтын Зарчим (GIP)" бөгөөд энэ нь BRI-д ногоон хөрөнгө оруулалтын үндсэн зарчмуудыг тодорхойлсон, 2021 оны 6-р сарын байдлаар 14 улсын 39 оролцогч, 11 дэмжигчидтэй болсон. Тэдгээр нь "ногоон төслийн ерөнхий стандарт, төслийн бүх үе шатанд тогтвортой хөгжлийн үндсэн зарчмуудыг томьёолох, мөн санхүүгийн байгууллагуудыг BRI хөрөнгө оруулалтын хүрээнд байгаль орчны үнэлгээ хийхийг шаардах" зорилготой (Hillman & Sacks, 2021). Тодорхой мэдэгдэж байгаа бүх BRI-ийн болон BRI-тэй холбоотой байгаль орчны дүрэм журмуудыг заавал дагаж мөрдөх шаардлагагүй боловч эдгээр стандартууд, дүрэм журмууд нь тэргүүлэгч улсын үйл ажиллагаанд найдах биш оролцогч бүх байгууллагуудад байгаль хамгааллыг хэрэгжүүлэхэд эхний чухал алхам болно.

Хятадын Экологи, Байгаль Орчны Яам (MEE) нь шугаман дэд бүтэцтэй холбоотой үндсэн заалтуудыг агуулсан "Ногоон Бүс, Замыг Дэмжих Удирдамж Зөвлөмж" нэртэй BRI-ийн гуравдах бодлого зохицуулалтыг хэрэгжүүлдэг. Нэгэн заалтад БОНБУ-ний дараа байгаль орчинд мэдрэг нутаг дэвсгэрүүдийг тодорхойлохыг шаарддаг бол өөр нэгэн заалтад оролцогч байгууллагуудыг байгаль орчны эрсдэлийн сайн дурын менежментийг батлахыг шаарддаг. Цаашлаад тус зөвлөмж удирдамжид зааснаар Хятад улс нь ... "ногоон хөгжил, экологи-байгаль орчныг хамгаалах төслүүдийг хэрэгжүүлэх ... мөн бүх үе шатны дэмжлэг туслалцаа үзүүлэхийн тулд байгаль хамгааллын хамтын ажиллагааны тогтолцоог хөгжүүлэх, бүрдүүлэх" болно гэж заасан (MEE, 2017a). Гэхдээ хүлээн авагч улс орон шаардлагатай удирдлага, зохион байгуулалтыг хэрэгжүүлэх, хууль тогтоомжийг мөрдөх, байгаль хамгааллын араг хэмжээг хөгжүүлэх, хэрэгжүүлэх шаардлагатай.

2021 оны 7-р сард MEE болон Хятадын Худалдааны Яам нь BRI-ийн хөгжил, мөн хилийн чанадын хөрөнгө оруулалттай холбоотой "Гадаадын Хөрөнгө Оруулалт, Хамтын Ажиллагаанд Зориулсан Ногоон Хөгжлийн Удирдамж" нэртэй нэмэлт бодлогыг гаргасан. Дээрх бодлогын хамтаар эдгээр удирдамжууд нь сайн дурын бөгөөд "зөвхөн гадаадын хөрөнгө оруулалт, хамтын ажиллагаанд Хятадын бизнесийн салбарыг хөгжүүлэх, байгальд ээлтэйгээр хөгжүүлэх тухай үйл ажиллагаанд хамаарна" (Wang & Tang, 2021). Тус зөвлөмж, удирдамж нь зээл авагч улсын байгаль орчны хууль тогтоомж, зохицуулалтыг мөрдөн ажиллахыг уриалдаг боловч зээл авагч улс орны дүрэм журам, стандарттай харьцуулахад илүү өндөр шаардлага тавьж байгаа тохиолдолд "олон улсын байгаль хамгааллын дүрэм, стандартуудыг" дагаж мөрдөхөд гол анхаарлаа хандуулсан. Энэ нь CBD болон Тогтвортой Хөгжлийн Зорилт зэрэг олон улсын гэрээнүүдийг илүү түгээмэл ашиглах, мөрдөх болсон гэсэн үг юм.

Өөр нэгэн чухал байгууллага бол CIDCA бөгөөд Хятадын гадаадын зээл тусламжийг гүйцэтгэх, стратеги, бодлого шийдвэр, төслийн зөвшөөрөлд хяналт тавих зорилгоор 2018 онд байгуулагдсан (Lynch, 2020). Үүнтэй холбоотойгоор энэ нь CDCA-ийг байгаль хамгааллын бодлого, шийдвэр, үйл ажиллагаанд Хятадын баримтлах чиг хандлагыг тодорхойлох гол чухал байгууллага болгож, төслийн үзэл санаа, техник-эдийн засгийн судалгааг хянах, батлах эрхийг олгосон. Баримт бичигт CIDCA нь биологийн төрөл зүйлийг (PRC State Council Information Office, 2021) хамгаалахтай холбоотой тусгай заалттай боловч одоогоор эдгээр нь Хятадын болон олон улсын стандартыг эс тооцвол байгаль хамгааллын холбогдолтой дээд төвшний зөвлөмж удирдамж болдог (CIDCA, 2020). Орон нутгийн төслийн дэмжигчид болон зохицуулагчдад байгаль хамгааллын ямар стандартад хамаарах талаар уян хатан зохицуулалтыг олгосноороо онцлог юм. Үүнээс гадна Хятадын бусад олон агентлагууд нь төслийг бодитоор хэрэгжүүлэхэд оролцдог боловч CIDCA нь эдгээр байгууллагуудын байгаль орчны бодлого зохицуулалтад хэрхэн нөлөө үзүүлдэг нь тодорхой бус байна (Tjønneland, 2020).

ХЯТАДЫН ОЛОН ТАЛТ ХӨГЖЛИЙН БАНК

Бид Ази даяар шугаман дэд бүтцийн хөгжилд зээл тусламж олгодог AIIB, NDB-ийн үүрэг оролцоонд үнэлгээ хийсэн. Эдгээр хамтарсан хөгжлийн банкууд (MDB) нь дан ганц хятадын эзэмшлийн биш боловч Хятад улсад төв оффистой, Хятадын зүгээс тодорхой хөрөнгө оруулалт хүлээн авдаг, Хятадын хууль тогтоомжид захирагддаг, AIIB банк нь Бээжинд төвтэй бол NDB банк нь Шанхайд төвтэй. MDB нь ESIA-ийн бодлого зохицуулалттай, тус хоёр банк Байгаль Орчин, Нийгмийн Зохицуулалтын баримт бичгээрээ биологийн төрөл зүйлийн асуудалд ханддаг (AIIB, 2016b; NDB, 2016).

Хоёр банкны тодорхойлсноор тус хоёр банк нь хүлээн авагч улсууд өөрийн байгаль орчны үнэлгээг хэрэгжүүлэх, нөөц чадвар хангалтгүй бол түүнийг хөгжүүлэх, сайжруулахад тусламж үзүүлдэг. Эдгээр хоёр банк нь төслийн бүрэлдэхүүнд байгаль орчны нөлөөлөл, биологийн төрөл зүйл, түүний нутаг дэвсгэрт үзүүлэх нөлөөллийг үнэлэх зардал, чадавхыг бий болгох бүрэлдэхүүн хэсгийг төсөвт багтаан

оруулах, мөн шугаман дэд бүтцийн хүрээнд зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээг төслийн хүлээн авагч улсын зүгээс санхүүжүүлэх боломжийг олгосон.

Өөрийн төслийн 60-70 хувьд AIB нь өөр нэгэн томоохон MDB-тай хамтран төслийг санхүүжүүлэх тохиолдолд тэд бусад банкны байгаль хамгаалах бодлого зохицуулалтыг дагаж мөрдөнө (биечлэн харилцах бол Стефен Линтнэр). АБХ болон ДБ зэрэг томоохон MDB-ийн зарим нь зээлдэгч байгууллагуудыг байгаль орчны бие даасан судалгаа хийхэд дэмжлэг үзүүлэх бодлого зохицуулалттай бөгөөд эдгээр банкууд нь зээл авагч нарт зориулж нөөц, чадавхыг бий болгох, техникийн тусламж дэмжлэг үзүүлэх замаар байгаль хамгааллын бодлого шийдвэрийг мөрдөх нөхцөлийг хангаж тодорхой хэмжээний төсөв төсөвлөдөг. AIB-ийн Төслийн Бэлтгэлийн Тусгай Сан ESIA гэх мэт төслийг хөгжүүлэх, чадавхыг бий болгоход зориулж тодорхой дэмжлэг үзүүлдэг(AIB, 2016a). Тус сан байгуулагдсан цагаасаа хойш 10 гаруй төслийн бэлтгэл ажилд дэмжлэг туслалцаа үзүүлсэн. AIB нь биологийн төрөл зүйлд сөрөг нөлөө бүхий төслүүдийг хянан шалгахад Биологийн Төрөл Зүйлийн Үнэлгээний Иж Бүрэн Аргыг (IBAT) ашиглах боломжийг бүрдүүлсэн.

ХЯТАДЫН БҮС БА ЗАМ САНААЧИЛГА

BRI нь 2013 онд эхэлсэн бөгөөд хятадын хэд хэдэн төрийн байгууллагууд, банк, AIB-аас дэмжин тусалдаг. Хятадын хилийн чанадад хийгдэж байгаа Хятадын ихэнх хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт нь BRI -ийн хүрээнд хийгдэж байна(Coenen et al., 2021). BRI-ийн санхүүгийн тусламж дэмжлэгийг хүлээн авдаг ихэнх хүлэн авагчид нь өндөр хөгжилтэй орнуудад байрладаг, мөн BRI нь хөгжлийн тусламжтай харьцуулахад худалдаа, хөрөнгө оруулалтад илүүтэй чиглэгдсэн (Линк, 2020). BRI-ийн эдийн засгийн үүрэг хариуцлага бол Хятад улсын экспорт, худалдаа, олон улсын харилцаа, бусад улстай эв найрамдалтай харилцах, тэр тусмаа Азийн хөгжиж байгаа улс орнуудтай харилцахад дэмжлэг туслалцаа үзүүлэг зорилгоор тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх явдал юм. Хятад дотоодын байгаль хамгаалалд зохих ахиц дэвшил гаргаж байгаа боловч BRI-аас нөлөө үзүүлэх Хятадын бодлогыг гадаад орнууд дараах байдлаар шүүмжилдэг. үүнд: (1) хуучин, бохирдол ихтэй технологийг экспортолдог, жишээ цементийн зуух, боловсруулах болон химийн үйлдвэр, нүүрсээр ажилладаг цахилгаан станц (эрчим хүчний салбарт хөрөнгө оруулалтын ихэнх хэсэгт хатуу түлш ашиглаж цахилгаан үйлдвэрлэдэг гэдгийг дурдах хэрэгтэй), (2) BRI-ийн хүлээн авагч улс орнуудад байгаль хамгааллын асуудал, хөндлөнгөөс оролцохгүй байх Хятадын бодлогын улмаас зэрлэг ан амьтныг хамгааллын асуудлыг хэрэгжүүлэх талд учир дутагдалтай(Coenen et al., 2021). Гэхдээ сүүлийн үед бий болсон BRIGC зэргийн үр дүнд BRI-ийн ногоон хөгжлийн бодлого, санаачилгуудыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд тодорхой ахиц дэвшлүүд гарч байгаа учраас эдгээр шүүмжлэлийг бодитоор үнэлэн дүгнэх хэрэгтэй.

БҮС БА ЗАМ САНААЧИЛГЫН НОГООН ХӨГЖЛИЙН ЭВСЭЛ

BRIGC бол Хятадын МЕЕ-ийн хяналтан дахь Хятадын болон олон улсын төрийн бүс байгууллага, шийдвэр гаргагчдын сүлжээ юм. Тус эвсэл нь шийдвэр гаргах, байгаль орчны мэдлэг, ногоон технологийн суурь тогтолцоо болох, BRI-д тогтвортой хөгжлийн зорилтыг нэгтгэх явдал юм. Хэдийгээр Ковид цар тахлын улмаас ажил удааширч байгаа боловч энэхүү харьцангуй шинэ байгууллага зохион байгуулагдаж байна. BRIGC нь BRI-ийн 26 улсын байгаль орчны яам, төрийн бүс байгууллагуудыг оролцуулаад 120 байгууллагын идэвхтэй оролцоог багтаасан.

BRIGC нь тус эвсэлд олон улсын зөвлөх багаар тусламж дэмжлэг үзүүлэх, BRI-ийн ногоон хөгжлийг дэмжихэд олон улсын хамтын ажиллагааг бий болгох арга технологиор туслах зорилгоор Бүс Ба Зам Санаачилгын Ногоон Хөгжлийн Олон Улсын Судалгааны Институтыг байгуулсан. 2020 онд ногоон хөгжлийн талаарх тус институтын зорилгыг тодорхойлсон BRI-ийн Төслийн Суурь Судалгааны Тайланд Зориулсан Ногоон Хөгжлийн Зөвлөмж, Удирдамж(BRIGC, 2020b), BRI-ийн Ногоон Хөгжлийн Кэйс Судалгааны Тайлан(BRIGC, 2020a) Зэрэг Хэд хэдэн Судалгааны Тайлангуудыг гаргасан. Мөн 2020 онд Хятадын хилийн чанадын төслүүдэд зориулж Хятад улсын зөвшөөрлийн үйл ажиллагаа болох BRI-ийн Төслийн Байгаль Орчны Ангиллыг нэвтрүүлсэн. Одоогоор BRI-д байгаль орчны эрсдэлийг хянан дүрэм, протокол дутагдалтай байна(You, 2020). Энэхүү тайланд BRIGC нь байгаль орчны томоохон нөлөөллийн үндсэн дээр ногоон, шар, улаан гэсэн үнэлгээний хөрөнгө оруулалтыг санал болгож, Хятадын эрх бүхий байгууллагуудыг "ногоон" төслүүдийг дэмжих, санхүүгийн дэмжлэг туслалцаа түлхүү үзүүлэх, "улаан" төслүүдийн хяналтыг бэхжүүлэхийг шаардсан.

Хятадын болон олон улсын түншүүд BRIGC-ийн үйл ажиллагааг 10 тусгай ажлын хэсэгт хуваадаг. Ажлын хэсэг бүр BRI-ийн бүх төсөлд зориулж анхан шатны удирдамж, удирдамжийн төсөл, ажлын

төлөвлөгөө, түршилтын төслийг эхлүүлэх төлөвлөгөөг боловсруулж байна. Бид байгаль хамгаалал, BRIGC-ийн үйл ажиллагаанд мэдээлэл хүсэх зорилгоор BRIGC-ийн янз бүрийн ажлын хэсэгт багтсан олон улсын төрийн бус байгууллагуудын таван төлөөлөлтэй холбоо барьсан бөгөөд тэдгээрээс нь хоёр нь тодорхой хариулт өгсөн. Бидний ярилцлагын үр дүнд янз бүрийн ажлын хэсгүүдийн хооронд харилцан адилгүй ахиц дэвшил гарч байгааг тогтоосон. Нэг төрийн бус байгууллагын төлөөлөгч дараах үйл ажиллагаанд оролцсон. Үүнд: 1) орон нутгийн түншүүдтэй хамтран хамтарсан судалгаа хийх 2) тусгай үйл ажиллагааг хамтран зохион байгуулах 3) ногоон хөгжлийн удирдамжийн тайланд оролцох. Хамгийн багаар Биологийн Төрөл Зүйл, Эко Системийн Удирдлагын нэг ажлын хэсэг мэдээлэл солилцоход түншээр оролцож, зөвлөх ажил гүйцэтгэсэн. Тусгай ажлын хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөө хийгдэж байгаа боловч олон нийтэд танилцуулах хараахан боломжгүй.

Нэг төлөөлөгчийн тодорхойлсноор BRIGC-ийн үйл ажиллагаа нь КОВИД-19 цар тахлын улмаас тодорхой хэмжээгээр саатсан, BRIGC-ийн хөгжлийн төлөв байдал, үүрэг, WFLI-тай холбоотой хөнгөвчлөх арга хэмжээ, хамгаалах арга хэмжээний хэрэгжилт түншүүдэд бүрэн тодорхой бүс байна. Хэдийгээр тус эвслийг зохион байгуулахад эдгээр хүндрэл бэрхшээл байгаа боловч бие даасан байгууллага болох BRIGC BRI-тай холбоотой WFLI-ийн чадавхыг бэхжүүлэх зорилгыг дэвшүүлж болох юм.

Дүгнэлтүүд

Хятад улс нь додоодын дэд бүтцийн төслүүдэд хамаарах дотоодын биологийн төрөл зүйлийг хамгаалах бодлоготой. гэхдээ Хятадын хилийн чанадад хөгжлийн хөрөнгө оруулалтад шугаман дэд бүтцэд зориулсан зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх зардал нь хүлээн авагч улс орнуудад тодорхой үүрэг хариуцлага бий болгосон. Энэ бол BRI-ийн хэрэгжилтэд тодорхой харагдаж байна, дагаж мөрдөх талаасаа BRI-ийн шугаман дэд бүтцийн төслийн санхүүжилт нь сайн дурын ногоон хөгжлийг дэмждэг, байгаль хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэхэд хязгаарлагдмал нөөц, удирдамжийг олгодог боловч нөгөө талаас эдийн засгийн дарамт, сургалт, хяналт зэрэг нь хэрэгжүүлэгч улс орноос ихээхэн хамаардаг.

BRI бол төрийн өмчит байгууллагуудын ерөнхий болон мужийн төвшинд зохион байгуулалттай хөрөнгө оруулалт, санаачилгуудыг багтаасан томоохон санаачилга юм. Байгаль хамгаалал, хяналт, нөлөөллийн мэдээлэл олон нийтэд тодорхой бүс, мөн шугаман дэд бүтцийн нөлөөллөөс зэрлэг ан амьтныг хамгаалах одоогийн нөөц, чадавхыг үнэлэхэд амаргүй байна. Одоогоор Хятадын MEE-ийн тогтолцоо нь өндөр төвшний амлалт, бодлого шийдвэрүүдийг танилцуулдаг, цаашлаад BRIGC-ээс хяналт тавих шаардлагатай шалгуур, үйл ажиллагаа, дэлгэрэнгүй үйл ажиллагаа дутагдалтай байна.

Ерөнхий удирдамж нь BRI төсөлд хамрагдсан байгууллагуудыг дэмжих, тухайлбал BRI-ийн холбогдолтой хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлэх, төлөвлөхөд удирдлага, зохион байгуулалтын систем, байгаль орчны бодлого, арга хэмжээ, байгаль хамгааллын арга хэмжээг хөгжүүлэх, холбогдох бодлого зохицуулалтыг дагаж мөрдөх зорилгоор Хятадын болон хэрэгжүүлэгч улсын төрийн байгууллагыг дэмжих үндсэн зорилготой. Эдгээр дүгнэлтүүд нь BRI-ийн байгаль орчны удирдлагын асуудалд оролцдог, анхаарлаа хандуулдаг бусад эрх бүхий этгээдийн дүгнэлттэй үндсэндээ тохирдог(Coenen et al., 2021; Foggin et al., 2021; Hillman & Sacks, 2021).

Зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх нөөц, хүчин чадавхыг ойлгохдоо улс орнууд НҮБ-ийн SDG, Парисын Гэрээг ханган ажиллахыг эрмэлздэг, гэхдээ Хятадын зүгээс зээл олгох, WFLI-ийн чадавхыг бэхжүүлэх сургалт зохион байгуулах зэргээр зээл авагч улс орнуудыг дэмжих нь зүйтэй гэсэн утгаар тайлбарлана. Өөр нэгэн чадавхыг бий болгох боломж нөхцөл бол зөвлөх байгууллагууд, төрийн бус, иргэний нийгмийн байгууллагуудыг BRI-ийн удирдагч орнуудын үйл ажиллагаанд өргөнөөр татан оролцуулах, оролцогч компаниудыг үйл ажиллагаандаа хариуцлагатай байхад дэмжлэг үзүүлэх явдал юм (Coenen et al., 2021). Эцэст нь хэлэхэд Хятадын төрийн байгууллагууд, институтууд, MDBs-ийн талаар дээрх дүгнэлтийг хийж байгаа боловч дэлгэрэнгүй БОНБУ-ний бэлтгэл ажлыг шаардах зэргээр шугаман дэд бүтцийн төслүүдэд BRI-ийн санхүүжилт авч байгаа хөгжиж байгаа улс орнуудад байгаль орчны үр дүнтэй удирдлагын хэлбэрээр чадавхыг бүрдүүлэх нь зүйтэй.


АЖ ҮЙЛДВЭРИЙН ХОЛБОО

Зэрлэг ан амьтныг хамгаалахад аж үйлдвэрийн нөөц, чадавхыг ойлгохын тулд бид авто зам (5), төмөр зам (4), цахилгаан дамжуулах шугамын (14) чиглэлээр ажилладаг 23 аж үйлдвэрийн холбооны үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгсөн. Мөн эдгээр гурван салбарт ажилладаг мэргэжилтнүүдийн талаар мэдээлэл авахын тулд инженерийн холбооны (8) үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгсөн (Хүснэгт8).

Хүснэгт8: Салбар салбараар нь аж үйлдвэрийн холбоодыг авч үзсэн байдал

ХҮСНЭГТ 8: САЛБАР САЛБАРААР НЬ АЖ ҮЙЛДВЭРИЙН ХОЛБООДЫГ АВЧ ҮЗСЭН БАЙДАЛ			
ЗАМ	ТӨМӨР ЗАМ	ЦАХИЛГААН ШУГАМ	ИНЖЕНЕР (ХОЛИМОГ ТӨРӨЛ)
Олон Улсын Авто Замын Сан	Ази, Номхон Далайн Төмөр Зам	ASEAN -ий Энергийн Төв	Азийн Барилгын Инженерийн Зөвлөх Зөвлөл
Олон Улсын Авто Тээврийн Эвлэл	Олон Улсын Төмөр Замын Байгууллага	CASA-1000 Цахилгаан Дамжуулах Шугам Болон Худалдааны Систем	Ази, Номхон Далайн Инженерийн Байгууллагуудын Холбоо
Тээврийн Инженерүүдийн Институт	Олон Улсын Төмөр Замын Эвлэл	SAARC Эрчим Хүчний Төв	Ази, Номхон Далайн Инженерийн Байгууллагуудын Холбоо
Ази, Австралийн Замын Инженерийн Холбоо	Төмөр Замын Байгууллага	SASEC Эрчим Хүч	Барилгын Инженерүүдийн Институт
НҮБ-ийн Ази, Номхон Далайн Тээврийн Хорооны Эдийн Засаг, Нийгмийн Комисс (UNESCAP)	Хоорондын Хамтын Ажиллагааны Байгууллага	Ази, Номхон Далайн Хот Суурингийн Эрчим Хүчний Холбоо	Олон Улсын Гүүр, Дэд Бүтцийн Инженерүүдийн Холбоо
		Зүүн Ази, Номхон Далайн Баруун Орнуудын Цахилгаан Хангамжийн Салбарын Холбоо	Олон Улсын Зөвлөх Инженерүүдийн Холбоо
		Төв Азийн Эрчим Хүчний Түншлэл	Олон Улсын Дэд Бүтцийн Инженер ба Барилгын Нийгэмлэг
		Зүүн Ази, Номхон Далайн Дэд Бүтцийн Зохицуулалтын Форум	Дэлхийн Инженерийн Байгууллагуудын Холбоо
		Эрчим Хүчний Нийлүүлэлтийн Холбоо	
		Эрчим Хүчний Зохицуулах Байгууллагуудын Бүсийн Холбоо	
		Япон-АНУ-ын Мэконг Эрчим Хүчний Түншлэл	
		Өмнөд Азийн Дэд Бүтцийн Удирдах Байгууллагуудын Форум	
		TUTAP Эрчим Хүчний Хамтын Ажиллагааны Төсөл	
		UNESCAP -ийн Эрчим Хүчний Хороо	

Эдгээр мэргэжлийн холбоодын үйл ажиллагааны цар хүрээ нь Ази, төдийгүй дэлхий дахинд өргөн хүрээтэй явагддаг (Зураг 1 **Error! Reference source not found.**). Цахилгаан дамжуулах шугам нь бидний үнэлгээ хийсэн эрчим хүчний холбоодын гол анхаарлын асуудал юм. эрчим хүчний холбоодын тал хагас орчим нь Азид эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулалтыг сайжруулах зорилгоор эдийн засгийн хамтын хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд бүс нутгийн олон улсын засгийн газар хоорондын түншлэл үүсгэдэг гэдгийг дурдах нь зүйтэй.




Зураг 1: Аж Үйлдвэрийн Холбоодын Газар Зүйн Байрлал

Эдгээр холбоодын веб сайтад үндэслэн бид тэдний зэрлэг ан амьтныг хамгаалах чиглэлээр зохион байгуулдаг мэргэжлийн сургалт (виртуал болон танхимын сургалт), вебинар, хэвлэл, бусад техник арга зүйн нөөцүүд зэрэг чадавх бий болгох үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгсөн. Бид аль болох тэдний бодлого шийдвэр, мэдэгдэл, бага хурал зэргийг судлахыг хичээсэн. Бага хурал зохион байгуулах нь байгаль хамгааллын чиглэлээр мэдлэг, туршлагаа хуваалцах гол арга юм. Зарим холбоод мэдээллийн веб сайттай байдаг бол зарим холбоод зохион байгуулалтын хувьд хөгжил сайнгүй. Гэсэн хэдий ч бид зэрлэг ан амьтныг хамгаалахтай холбоотой ерөнхий чиг хандлагуудыг ойлгох боломжтой байлаа:

- *Зэрлэг ан амьтныг хамгаалах асуудал:* Шугаман дэд бүтцийн төрөл хэлбэрүүдийн хувьд бид зэрлэг ан амьтныг хамгаалах чиглэлээр одоогийн баримт материалуудыг тодорхойлох боломжгүй байлаа. Харин Олон Улсын Төмөр Замын Байгууллага (UIC) бидний олж тодорхойлсноор зэрлэг ан амьтантай холбоотой ганцхан төслийг удирдаж байна. 2020-2023 оны хооронд дэвшүүлсэн зорилго болох: *Зэрлэг Ан Амьтанд Төмөр Замын Экологийн Нөлөөлөл* бол "байгалийн өвийн хадгалах, дэмжих зорилгоор төмөр замын байгууллага, дэд бүтцийн удирдагч, шийдвэр гаргагч нарт зориулж биологийн төрөл зүйлийн үйл ажиллагааны төлөвлөгөө, удирдамжийг хөгжүүлэх" явдал юм(UIC, 2021).
- *Хэвлэлийн материал:* Төмөр замын нэг холбоо инженерийн хоёр холбоотой (холимог үйл ажиллагаатай) хамтран үс хамгаалалт, цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох, уян хатан үйл ажиллагаатай холбоотой тусгай хэвлэлийн баримт бичигтэй байна. Бид бусад холбооны веб сайтуудад тавигдсан ижил төстэй баримт материалуудыг бүрэн олж чадаагүй. Гэхдээ инженерийн долоон холбооны (холимог үйл ажиллагаатай) веб сайт, авто замын гурван холбооны веб сайт, төмөр замын нэг холбоотой хамтарсан веб сайт зэргээс техник, арга зүйн ерөнхий баримт бичиг, сэтгүүл, тайлан зэргийг цуглуулсан, эдгээрт хэдийгээр бидний ярилцаж байгаа сэдэв хараахан багтаагүй байсан боловч зэрлэг ан амьтныг хамгаалах чиглэлээр мэдээлэл тараах, танилцуулах бүрэн боломжтой. Бид цахилгаан дамжуулах холбооны веб сайтуудаас техник, арга зүйн баримт бичгийг олж чадсангүй.

- *Хүний нөөцийн сургалт:* төмөр замын нэг холбоо, авто замын дөрвөн холбооны зүгээс курс, семинар, гэрчилгээ олгох, вебинар зэрэг олон хэлбэртэй хүний нөөцийн сургалтууд явагддаг, заримдаа танхимын болон онлайн сургалтууд явагддаг. Мөн түүнчлэн төмөр замын нэг холбоо, авто замын нэг холбоо, инженерийн хоёр холбоо байгаль орчны өргөн хүрээтэй асуудлаар сургалт зохион байгуулдаг. Цахилгаан дамжуулах шугамын дөрвөн холбоо, инженерийн хоёр холбоо хүний нөөцийн сургалтыг мөн зохион байгуулдаг.
- *Бага хурлууд:* Бага хурлууд нь чадавх бий болгох өөр нэгэн боломж юм. Шугаман дэд бүтцийн бүх салбаруудын чиглэлээр бид аж үйлдвэрийн холбоод нь бүсийн хэмжээний олон бага хурлуудыг зохион байгуулдаг болохыг бид олж тодорхойлсон (Зураг 2). Бодит байдалд Азитай хамааралтай 18 бага хурлыг олж тодорхойлсон нь инженерийн 7, авто замын 4, цахилгаан дамжуулах шугамын 4, төмөр замын 3 холбоо байна. Тус холбоод нь 11 нэмэлт бага хурлууд дэлхийн төвшинд үйл ажиллагаа явуулдаг.



Зураг2: Бага хурлуудын зохион байгуулагдаж байгаа байдал,

Эцэст нь хэлэхэд мэргэжлийн холбоо тус бүрийн байгаль хамгааллын зорилт, үйл ажиллагааны зорилгын талаар ойлголт авахын тулд бид тэдгээр холбоодын үйл ажиллагааны төлөвлөгөө, бодлого шийдвэрийг судалсан. Веб сайтаас мэдээлэл авах боломжтой, бодлого шийдвэрээ танилцуулсан 16 холбооноос (төмөр замын 2, авто замын 5, инженерийн 2, эрчим хүчний 7) аль нь ч зэрлэг ан амьтныг хамгаалах чиглэлээр тусгайлан заагаагүй. Гэхдээ төмөр зам, цахилгаан дамжуулах шугамын холбоод нь цаг уурын өөрчлөлт, байгалийн бохирдлын бууруулах зэрэг байгаль орчны асуудалтай холбоотой бодлого шийдвэртэй байлаа.


Аж үйлдвэрийн холбоод нь авто зам, төмөр зам, цахилгаан дамжуулах шугамын чиглэлээр мэргэжилтнүүдэд зориулсан зэрлэг ан амьтныг хамгаалах сургалт, мэдээллийн эх үүсвэртэй байх, мэдээллээр хангах бүрэн хүчин чадавхтай. Азийн хэмжээнд авч үзвэл дэлхийн төвшинд үйл ажиллагаа явуулдаг зарим байгууллагууд Азийн холбоодтой хамтран бүс нутагт аж үйлдвэрийн мэргэжлийн үйл ажиллагааг идэвхтэй явуулдаг. Эдгээр холбоод нь мэргэжилтнүүдэд мэдлэг, мэдээлэл өгөх зорилгоор тусгай форумуудыг санал болгодог. Гэхдээ одоо үед бидний судалсан веб сайтуудаас зөвхөн нэг нь зэрлэг ан амьтныг хамгаалах асуудлыг асуудлын гол сэдэв болгон авч үздэг. Бага хурал, хэвлэлийн материал, сургалтаар дамжуулах аж үйлдвэрийн холбоод WFLI-ийн үйл ажиллагааны талаар өөрийн гишүүддээ мэдээлдэг.

ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУД

ОЛОН УЛСЫН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУД

Ази дахь хамгийн том олон улсын төрийн бус байгууллагуудтай хийсэн ярилцлагын үндсэн дээр тэдгээр байгууллагуудын байгаль хамгааллын хөтөлбөр нь бүхэл бүтэн тивийн хэмжээнд идэвхтэй явагддаг, манай судалгаанд хамрагдсан улсад мөн үйл ажиллагаа явуулдаг (Бруней, зураг 3). 28 улсаас 22 улсад шугаман дэд бүтцийн төслүүд, төлөвлөгөөтэй хамтран ажиллах нь өндөр үзүүлэлттэй дүгнэгдсэн. Бидний хянан шалгасан 11 төрийн бус байгууллагаас ес нь байгаль хамгааллын нэн тэргүүний 10 асуудлын дотор шугаман дэд бүтцийн асуудлыг авч

үздэг, томоохон төрийн бус байгууллагууд бүгдээрээ шугаман дэд бүтцийн асуудалд хандах тодорхой чадавхтай. Гэсэн хэдий ч шугаман дэд бүтцийн төлөвлөгөө ба төслийн асуудалд хандах нь ерөнхийдөө албан бус, бидний хянан шалгасан, ярилцлага хийсэн зөвхөн хоёр төрийн бус байгууллага шугаман дэд бүтцийн хөтөлбөртэй, бусад зургаа нь өөр бусад хөтөлбөрөөр шугаман дэд бүтцийн асуудалд ханддаг.




Зураг3: Төрийн бус байгууллагын судалгаанд хамрагдсан оролцогчдын байгаль хамгаалал, шугаман дэд бүтцийн үйл ажиллагааны хэрэгжилт, газар нутгийн байдлаар

Шугаман дэд бүтцийн асуудалд хандахдаа эдгээр байгууллагууд байгаль хамгааллын арга шийдлийг гаргахдаа өөрийн дотоод болон гадаад нөөц чадавхад тулгуурладаг (Зураг4: Төрийн бус байгууллагуудаас авч хэрэгжүүлдэг шугаман дэд бүтцийн асуудлаар чадавхыг бий болгох арга хэмжээнүүд. а) Дотоод чадавхыг бий болгох б) Гадаад чадавхыг бий болгох.). Дотооддоо эдгээр төрийн бус байгууллагууд Азийн хөтөлбөрийн дотор ба гадна одоогийн мэргэжлийн чадварт тулгуурлах хандлагатай. Тэдгээр байгууллагууд мэргэжлийн үр чадварыг бий болгохын тулд одоогийн ажилтнууд, хүний нөөцийг дэмжин ажилладаг, шинэ экспертүүдийг авч ажиллуулах, шинэ хөтөлбөр хөгжүүлэх зэргээр дэмжин ажилладаг (Зураг4 (a)). Гадна талдаа төрийн бус байгууллагууд нь бусад төрийн бус байгууллагууд гэх мэт хөндлөнгийн байгууллагуудтай хамтран түншлэл байгуулж, шугаман дэд бүтцийн экспертүүдтэй хамтран түр хугацаанд зөвлөх ажилтнуудыг хөлслөн авч ажиллуулдаг (Зураг4 (b)).

(a)

(b)



Зураг4: Төрийн бус байгууллагуудаас авч хэрэгжүүлдэг шугаман дэд бүтцийн асуудлаар чадавхыг бий болгох арга хэмжээнүүд. а) Дотоод чадавхыг бий болгох б) Гадаад чадавхыг бий болгох. (Хөх өнгөтэй хэсгүүд нь 'тийм' гэсэн хариултыг илэрхийлнэ). Саарал тэмдэг нь 'үгүй' гэсэн хариултыг илэрхийлнэ.)

Олон улсын төрийн бус байгууллагууд дотоод чадавхыг бий болгох чиглэлээр гурван үндсэн хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон:

- Шугаман дэд бүтцийн нөлөөллөөс зэрлэг ан амьтныг хамгаалах үйл ажиллагаанд одоогийн байгууллагын үйл ажиллагааны ухамсар харьцангуй нэмэгдсэн;
- Шугаман дэд бүтцийн төслийг хэрэгжүүлэх үед боломжит мэдээллээр дамжуулан богино хугацаанд ялгах, шүүх стратеги
- Нийгэм, улс төр, экологийн нарийн нийлмэл нөхцөл байдал бүхий орон нутгийн асуудалд ерөнхий мэдээллийг хэрхэн хэрэглэх тухай сэдвээс хамааралтай мэдээлэл, удирдамж.

Одоо үед төрийн бус байгууллагуудын оролцож байгаа шугаман дэд бүтцийн төслийн шат бол бүтээн байгуулалтын өмнөх шатанд мэдээлэл цуглуулах бөгөөд энэ нь шинэ шугаман дэд бүтцийг хөгжүүлэхэд үзүүлэх нөлөөллийг үнэлэхэд чухал үүрэгтэй. Энэхүү мэдээлэл нь өндөр эрсдэлд байгаа нутаг дэвсгэр, төрөл зүйл, биологийн төрөл зүйлийн унаган нутаг зэргийг тодорхойлох боломжтой, мөн нөхөн сэргээлт, байгаль хамгааллын хэрэгцээ шаардлагад хамаарч болно. Төрийн бус байгууллагуудын ихэнх нь үр дүнтэй шугаман дэд бүтцийн арга хэмжээнд төслийн явцад агентлаг, санхүүжүүлэгч, олон нийтийн байгууллага, олон нийттэй идэвхтэй хамтран ажиллах шаардлагатай гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Шугаман дэд бүтцийн дэмжигчид, хөгжүүлэгчидтэй урт хугацаанд хамтран ажиллахын тулд төрийн бус байгууллагууд төлөвлөгөөт санхүүжилтийн хэрэгцээ шаардлагын талаар илэрхийлдэг нь мэргэжлийн үр чадвар, туршлага бий болгох боломжийг олгодог.


Нэмэлт чадваруудыг бий болгохын тулд олон улсын төрийн бус байгууллагууд уулзалт зохион байгуулах (73 хувь), мэдээллийн лавлах (64 хувь), гарын авлага, удирдамж зөвлөмжид (64 хувь) илүүтэй анхаарлаа хандуулсан. Уулзалтууд нь янз бүрийн түншлэгчид хамт цугларах боломжийг олгодог бол гарын авлага, удирдамж, зөвлөмж нь хүн бүрд нэгэн ижил мэдээлэл өгөх боломжийг бүрдүүлдэг. Төвлөрсөн мэдээллийн лавлах нь бүх оролцогч, хамтрагчид тодорхой сэдвээр нэг төвөөс богино хугацаанд мэдээлэл хайх, олж авах боломжийг бүрдүүлдэг.

Эдгээр төрийн бус байгууллагууд зэрлэг ан амьтан- машины мөргөлдөөн, зэрлэг ан амьтны нутаг дэвсгэрийг хуваах зэрэг шугаман дэд бүтцийн шүүд нөлөөллийн талаар анхаарлаа хандуулдаг, тэдгээрийн олонх нь шинэ шугаман дэд бүтцээр бий болсон боломжуудад анхаарлаа хандуулдаг. Шугаман дэд бүтцийн шинэ түрэлт нь зэрлэг ан амьтанд нэмэлт аюул

занал учруулах, хууль бус ан агнуур, ой үстгал зэрэг хүндрэлтэй асуудлыг бий болгодог. эдгээр асуудал бол олон төрийн бус байгууллагын анхаарлын гол асуудал юм. Нэг төрийн бус байгууллага танилцуулснаар шугаман дэд бүтцийн аюул, сөрөг нөлөөлөл өндөр төвшинд байгаа боловч авто зам, төмөр замын зүгээс олон нийтэд үзүүлэх ач холбогдол нь энэхүү сөрөг нөлөөллөөс илүү өндөр хувийг эзэлж байна. Төрийн бус байгууллагууд шугаман дэд бүтцийн тэлэлтийн сөрөг тал нь идэвхтэй хамтын ажиллагааны чухал асуудал гэдгийг хүлээн зөвшөөрдөг.

ҮНДЭСНИЙ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУД


Тавин дөрвөн төрийн бус байгууллага цахим судалгаанд судалгааны бүсийн 28 улсын 15-ийг хамруулсан. Энэтхэг, Пакистан, Непал (Зураг5) зэрэг өмнөд Азийн орнуудаас ч ихэнх хариултууд ирсэн, энэ нь IUCN-ийн гишүүн орнуудын жагсаалтаас танилцуулсан газар нутгийг хамардаг. Төрийн бус байгууллагуудын 90 орчим хувь нь шугаман дэд бүтэц бол тэдгээр улсад зэрлэг ан амьтанд аюул занал учруулдаг гэж үздэг, 54 байгууллагын 38 нь зэрлэг ан амьтанд шугаман дэд бүтцийн зүгээс үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ нь тэдгээр байгууллагын анхаарлын гол асуудал гэж үздэг. Гэхдээ зарим улс орнууд шугаман дэд бүтэц,



зэрлэг ан амьтны чиглэлээр голчлон ажилладаг төрийн бус байгууллагууд ихэнх хувийг эзэлдэг.

Зураг5: Төрийн бус байгууллагуудын судалгаанд оролцогчдын газар зайн тархалт

Шугаман дэд бүтцэд гол анхаарлаа хандуулдаг байгууллагуудын гуравны хоёр нь шугаман дэд бүтцийн ажлуудад тодорхой болон бүх цаг хугацааг зориулдаг, шугаман дэд бүтцийн төлөвлөгөө, төсөлд хандах чадавх, асуудлаар гол анхаарлаа хандуулдаг (Зураг 6). Үйл ажиллагааны нөөц, чадавхыг авто замд (25 төрийн бус байгууллага), төмөр замын чиглэлээр 12 төрийн бус байгууллага, цахилгаан дамжуулах шугамын чиглэлээр 11 төрийн бус байгууллагууд шугаман дэд бүтцийн чиглэлээр ажилладаг бусад байгууллагуудтай хамтран ажилладаг.



Зураг6: Шугаман дэд бүтцийн гол асуудлууд, улс орноор авч үзвэл

Үндэсний төрийн бус байгууллагуудын дөрөвний гурав нь санхүүжилт дутмаг байх нь зэрлэг ан амьтанд шугаман дэд бүтцийн нөлөөллийн асуудалд хандахад хүндрэлтэй байдлыг үүсгэдэг, энэ хүндрэл нь олон улсын томоохон төрийн бус байгууллагуудад мөн чухал хүндрэл болдог. Иймээс үндэсний төрийн бус байгууллагууд шугаман дэд бүтцийн санхүүжилтийн эх үүсвэрийн асуудалд анхаарлаа хандуулж тусламж дэмжлэг үзүүлэх, чадавх бий болгох асуудалд анхаарлаа хандуулах хэрэгтэй. Санхүүжилттэй холбоотойгоор эдгээр төрийн бус байгууллагуудын олонх нь хүний нөөцийн дутмаг байдал нь гол бэрхшээл гэж үздэг бол, цөөн тооны төрийн бус байгууллагууд хязгаарлагдмал нөөцтэй, нэмэлт санхүүжилт байхгүй, ажилтнууд нь шугаман дэд бүтцийн асуудалд хандах үр чадвар, чадавхгүй. Олон тооны төрийн бус байгууллагуудын дүгнэснээр тухайн улсын улс төрийн орчин, "төр засгийн дэмжлэг сул байх", "мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа дутмаг, хууль эрх зүйн дутмаг байдал", "шийдвэр гаргагчдад ойлголт өгөх зохих удирдамж, зөвлөмж дутмаг байх" зэрэг гол саад бэрхшээл гэж дүгнэсэн. Эдгээр хариултууд нь төр засгийн ажилтнуудтай хамтран ажиллах, тэдэнд нөлөөлөх талаар сургах, WFLI-ийн чиглэлээр хамтран ажиллах сургалт явуулах нь зүйтэй болохыг харуулдаг. Эцэст нь хэлэхэд олон улсын төрийн бус байгууллагуудын адилаар үндэсний төрийн бус байгууллагууд байгаль хамгааллын үр дүнтэй үйл ажиллагаанд мэдлэг, туршлага дутмаг байгааг онцлон тэмдэглэж, нэмэлт сургалт явуулах шаардлагатай гэж үздэг.

Үндэсний ТББ -ууд зэрлэг ан амьтдыг хамгаалах арга хэмжээний талаар илүү ихийг мэдэхийг хүсэж байгаа бөгөөд 54 -ийн 53 нь шугаман дэд бүтцийн талаар сургалт явуулах сонирхолтой байгаагаа илэрхийлжээ. Бодлого зохицуулалт, төлөвлөлтийн талаарх сургалтууд нь хамгийн их анхаарал, сонирхол татсан, шугаман дэд бүтцийг байгуулахаас өмнө эдгээр төрийн бус байгууллагууд ихэвчлэн оролцдог, шугаман дэд бүтэц, төлөвлөлтийн асуудлаар ерөнхий бодлого зохицуулалтын хөгжүүлэх хэрэгтэй. Зарим ТББ -ууд сонирхож байгаа төлөвлөлт, хор хөнөөл, хяналт шинжилгээгээр хариулсан боловч эдгээр сэдвүүд нь бүх ТББ-уудад хамаарал багатай байж магадгүй юм. Цөөн хэдэн ТББ -ууд шугаман дэд бүтцийн эдийн засгийг тусгайлан сонирхож байсан боловч ихэнх нь ОУ-ын барилгын ажлыг төлөвлөх, хөгжүүлэх явцад ил тод хариуцлагатай байхыг дэмжих сонирхолтой байв. ТББ -ууд шугаман дэд бүтцийн төслүүдийн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд хандивлагчдаас засгийн газарт өгөх инженерчлэл, барилгын компаниудын хариуцлагыг дээшлүүлэхийг уриалав.

ҮНДЭСНИЙ ТӨВШНИЙ ҮР ДҮН, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

LISA СУДАЛГААНЫ ХАРИУЛТУУДЫГ НЭГТГЭН ДҮГНЭХ НЬ

840 зорилтот оролцогчдоос (хамт олны зүгээс судалгааг дамжуулсан тоог нэмээд) цахим судалгаа 321 хариултыг цуглуулсан. Эдгээрээс 89 хариулагч төрийн байгууллагын бүрэлдэхүүнд багтдаг, 27 нь ОУСБ-д хамаардаг, 46 нь аж үйлдвэрийн салбарт, 120 нь төрийн бус байгууллагад (хувийн эрдэм шинжилгээний байгууллагуудыг оруулаад) багтдаг. "Бусад" гэж хариулсан 39 оролцогчид ихэвчлэн тэтгэвэрт гарсан төрийн албан хаагч, иргэний нийгмийн экспертүүд байлаа. Шинжилгээндээ бид эдгээр мэргэжилтнүүдийн туршлага, өмнөх ажил мэргэжилтэй хамгийн их нийцэж байгаа бүрэлдэхүүн хэсгүүдийн хүрээнд эдгээр оролцогчдыг хамруулсан болно. Бидний төлөөллийн таван орны үндэсний хэмжээнд хийсэн чадавхын судалгаа нь КОВИД-19 тахлын хоёр дахь давалгаатай давхцаж, хариултын төвшин буурахад хүргэв. Тиймээс, дараагийн хэсгүүдэд бид байгаа өгөгдөлд үндэслэн үр дүн гаргадаг боловч дутуу эсвэл маш цөөн тооны хариултуудын талаарх дүгнэлтийн ач холбогдлыг хэтрүүлэн үнэлдэггүй.

Ази даяар КОВИД-19 -ийн олон удаагийн дэгдэлт, засгийн газрын үйл ажиллагааны түр сааталтай холбогдуулан бид үндэсний төвшинд харилцан адилгүй хариултуудыг хүлээн авсан: тухайлбал Бангладешаас 56, Энэтхэгээс 46, Монголоос 45, Балбаас 100, Тайландаас 54 хариулт авсан. Судалгаанд хамрагдсан хүмүүс олон оронд ажилласан ($n = 16$) эсвэл сонгосон таван улсын аль нэгэнд нь ажиллаагүй боловч Ази тивд шугаман дэд бүтцийн дээр ажиллаж байсан хүмүүс байсан ($n = 4$). Бидний судалгаанд оролцогчид шугаман дэд бүтцийн янз бүрийн төрлүүдэд ажилласан: зам дээр 146, төмөр замд 76, цахилгаан шугамд 91. Нэмж дурдахад 61 оролцогч зөвхөн тодорхой шугаман дэд бүтцийн -ийн төрөлд ажиллаагүй гэж хариулсан бол 102 оролцогч шугаман дэд бүтцийн тодорхой горим дээр ажиллах нь тэдэнд хамааралгүй гэж хариулжээ. "Хамааралгүй" гэж хариулсан хүмүүс нь үндсэндээ засгийн газар, ТББ -уудаас бүрдэж байсан; Магадгүй тэдний үйл ажиллагааг шугаман дэд бүтцийн -ийг ерөнхий утгаар нь авч үзсэн байж болох юм (жишээлбэл, авто замууд зэрлэг ан амьтдын амьдрах орчныг хэрхэн хуваасан гэх мэт), гэхдээ тэд шугаман дэд бүтцийн төлөвлөгөө, төсөл дээр шууд ажиллаагүй байж болох юм.


Судалгааны үр дүнгийн график дүрслэлд бид тодорхой бүрэлдэхүүн хэсэг эсвэл улс орны хариултын давтамжийг холбох, зөвшилцөл, зөрүүтэй байдлыг хялбархан ялгах шугамыг ашигладаг. Гэсэн хэдий ч хариултууд нь бие даасан хувьсагч юм.

ШУГАМАН ДЭД БҮТЦИЙН НӨЛӨӨЛЛӨӨС ЗЭРЛЭГ АН АМЬТНЫГ ХАМГААЛАХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГАД АНХААРАХ ҮНДСЭН АСУУДЛУУД, ОЙЛГОЛТУУД

Ерөнхийдөө зэрлэг ан амьтдыг хамгаалах нь нэн тэргүүний зорилт байв; Судалгаанд хамрагдагсдын 67 хувь нь шугаман дэд бүтцийн -ийн нөлөөллийг бууруулах нь тэдний байгууллагын хувьд нэн тэргүүний зорилт гэдэгтэй санал нэгджээ (санал нэг байна = 119, ~ 38 хувь; зөвшөөрч байна = 93, ~ 29 хувь; зарим талаар зөвшөөрч байна = 50, ~ 16 хувь). Судалгаанд хамрагдагчид шугаман дэд бүтцийн төслүүдэд зэрлэг ан амьтдын хамгаалалтыг хэрэгжүүлэх нь бэрхшээлтэй гэж дүгнэсэн; "Хамаарахгүй" гэж сонгосон судалгаанд хамрагдагсад буюу оролцогчдын 48 хувь нь шугаман дэд бүтцийн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байсан гэж хариулсан бол 12 хувь нь маш хэцүү байсан гэж хариулсан. Зөвхөн 13 хувь нь үүнийг хялбар (10.6 хувь) эсвэл маш хялбар (2.4 хувь) гэж дүгнэсэн. Судалгаанд хамрагдсан бүх оролцогчдын дунд WFLI-ийн хамгаалалтыг хангах нь нэн тэргүүний зорилт боловч хэрэгжүүлэхэд хэцүү байдаг нь тодорхой харагдаж байна.

Судалгаанд хамрагдагсдын үзэж байгаагаар тэдний байгууллага янз бүрийн шалтгаанаар шугаман дэд бүтцийн -ийн зэрлэг ан амьтдад үзүүлэх нөлөөллийг шийдвэрлэх сонголтыг хийсэн (7). Бүрэлдэхүүн хэсгүүдийн дунд шилдэг туршлагуудтай танилцах, хүмүүсийн аюулгүй байдлыг сайжруулах хүсэл эрмэлзэл ижил төстэй давтамжтайгаар бүртгэгдсэн байна. Гэхдээ ландшафтын тогтвортой байдлыг хангах, зэрлэг ан амьтдыг хамгаалах зорилгоор шугаман дэд бүтцийн -ийн нөлөөллийг шийдвэрлэхэд ТББ -ууд хамгийн их хөрөнгө оруулдаг бөгөөд дараагийн байранд төрийн байгууллагууд орсон. Зэрлэг ан амьтанд шугаман дэд бүтцийн нөлөөллийг бууруулах хууль ёсны үүрэг даалгавар нь засгийн газрын агентлаг, аж үйлдвэрийн оролцогчдын хувьд хамгийн чухал байсан нь гайхмаар зүйл биш юм. ОУСБ-үүд шугаман дэд бүтцийн зүгээс зэрлэг ан амьтдад үзүүлэх нөлөөллийг хэрхэн авч үзэж байгаа шалтгаанаар ОУСБ байгууллагын нэр хүндийг авч үзсэн. Эдгээр урьдчилсан дүгнэлтээс үзэхэд бүрэлдэхүүн хэсгүүдэд WFLI-ийн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд янз бүрийн үндсэн шалтгаанууд байдаг.

Судалгааны нэгэн сонирхолтой дүгнэлт бол судалгаанд оролцогчид шугаман дэд бүтцийн -ийн зэрлэг ан амьтдад үзүүлэх нөлөөллийг шийдвэрлэх шалтгаан болгон "төслийн саатлыг бууруулах" гэж дүгнэхгүй байна (Зураг 7). Бид энэхүү дүгнэлтийг хийхэд олон шалтгаануудыг тогтоосон: тухайлбал судалгаанд оролцогчдын байгууллагад төслийн саатал нөлөө үзүүлэхгүй байж болно (төрийн бус байгууллагууд); төлөөллийн таван улс болон бүсийн ОУСБ сангуудад зэрлэг ан амьтанд үзүүлэх шугаман дэд бүтцийн нөлөөлөл төслийн үйл ажиллагааг хойшлуулдаг гэж үзэхгүй байх нотолгоо бага байна, эцэст нь хэлэхэд зарим тохиолдолд шугаман дэд бүтэцтэй холбоотой байгаль хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэхгүй байх нь төслийн хугацаанд нөлөө үзүүлдэггүй гэх баталгаа бага байна. Бид эдгээр таван улсын шинжилгээнд шугаман дэд бүтцийн чадавх, хэрэгжилтийг үнэлэх дараагийн бүлгүүдэд эдгээр нарийн ширийн зүйлс, хүндрэлтэй асуудлуудад анхаарлаа хандуулсан.



7Зураг: Дөрвөн бүрэлдэхүүн хэсгээс судалгаанд хамрагдагсдын өгсөн шалтгаан нь шугаман дэд бүтцийн зүгээс зэрлэг ан амьтдад үзүүлэх нөлөөллийг шийдвэрлэх шалтгаанууд юм

ОДООГИЙН ЧАДАВХ БОЛОН ТҮҮНИЙ ТУХАЙ ОЙЛГОЛТ

Судалгаанд хамрагдагсдын ойролцоогоор 48 хувь нь тэдний байгууллагад зэрлэг ан амьтдыг шугаман дэд бүтцийн нөлөөллөөс хамгаалах тусгай ажилтнууд байдаггүй гэж хариулсан бол


41 хувь нь тэдний байгууллагууд ийм тусгай ажилтантай гэж хариулсан бөгөөд 11 хувь нь сайн мэдэхгүй байна гэж хариулсан. Бүрдүүлэгч бүлгүүдийн хүрээнд ижил төстэй буюу тавь, тавин хувьтай ойролцоо үр дүн харагдсан. WFLI-д зориулсан боловсон хүчний бүтэц нь бидний судалгаанд хамрагдсанаас илүү нарийн төвшинд илүү тодорхой байж болох бөгөөд тухайн байгууллага, бүрэлдэхүүн хэсгүүд болон хэлтсүүдийн доторх хэлтсүүд хоорондоо ялгаатай байж магадгүй гэж бид дүгнэж байна.

Судалгаанд хамрагдагсдын талаас илүү хувь нь (> 50 гаруй хувь) шугаман дэд бүтэцтэй холбоотой ан амьтдыг хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тэдний байгууллагын чадавх дутагдалтай хэвээр байна гэж үзэж байна. Судалгаанд хамрагдагсдын 31 хувь нь байгууллагууд нь зөвхөн тодорхой хэмжээний чадавхтай, 17 хувь нь чадавх хангалтгүй гэж хариулсан байна. Судалгаанд хамрагдагсдын дөнгөж 38 хувь нь өөрсдийн байгууллагууд чадавхтай гэдэгтэй санал нэгдэж, шугаман дэд бүтцийн зүгээс зэрлэг ан амьтанд үзүүлэх нөлөөллийг шийдвэрлэхэд зарим байгууллагуудын чадавх суурь төвшинд байгаа гэж мөн зэрлэг ан амьтныг хамгаалах үүрэгтэй үндсэн байгууллагуудаас судалгаанд оролцогчид үнэн бодит биш нөхцөл байдалд тодорхой чадавхтай гэж хариулсан.

Шугаман дэд бүтцийн төслийн явцад зэрлэг ан амьтдын хамгаалалтыг авч үзэх явцад бүрэлдэхүүн хэсгүүдийн хоорондын уялдаа холбоо ямар төвшинд байгааг бид бас сонирхсон. Зарим бүрэлдэхүүн хэсгүүд бие биетэйгээ хамтран ажилладаг болохыг бид олж мэдсэн боловч зарим нь бусадтай харьцуулахад илүү их хамтран ажиллаж түншилдэг (8). Хариултуудаас харахад байгаль хамгааллын асуудлаар шугаман дэд бүтцийн төсөлд ажиллах явцад санхүүжүүлэгчдийг (дотоодын болон олон улсын) түншээр хамтран ажиллахыг хүсэн нь хамгийн бага давтамжтай байдаг. Энэ нь төслийн бүхий л үйл явцын туршид санхүүжүүлэгчдийн түншлэлийн үүргийн талаарх ойлголт хязгаарлагдмал байгаатай холбоотой байж болох юм. Бүрдүүлэгч хэсгүүд нь шугаман дэд бүтцийн хөгжил болон зэрлэг ан амьтныг хамгаалахад оролцох үүргийг буруу ойлгосны улмаас эрэл хэрэгцээ багатай үлдэж байгаа түншүүдийг тодорхойлохын тулд чадавхын сургалтад үүргийг илүү ихээр тодорхойлох шаардлагатай. Төр засгийн байгууллагууд төр засгийн газар, төрийн бус байгууллагын хүрээнд хамгийн түгээмэл байдлаар түншлэхийг эрмэлзэх хандлагатай, харин ОУСБ нь үйлдвэр, төрийн бус байгууллагын түншүүдтэй хамгийн их хамтран ажилладаг. Үйлдвэрийн салбар нь үйлдвэр болон төрийн бус байгууллагын хүрээнд түншүүдтэй хамтран ажилладаг. Сонирхолтой нь, манай судалгааны хариултад дөрвөн бүрэлдэхүүн хэсэг нь орон нутгийн иргэдтэй хамтран ажиллаж байгаагаа мэдээлсэн нь төслийн явцад эмзэг бүлгийн иргэдийн асуудлуудыг нэгтгэж байгаа тухайгаа илэрхийлсэн. Эцэст нь, ТББ -ууд бусад ТББ -тай хамгийн их түншилдэг болохыг олж мэдсэн бөгөөд энэ нь дараах шалтгаантай:

- 1) Бусад түншүүдтэй харилцах боломж хязгаарлагдмал,
- 2) ТББ -ын ажлын бусад сэдвүүдтэй харьцуулахад шугаман дэд бүтцийн төсөлд хамрагдах санхүүжилт багатай,
- 3) Уламжлалт тав тухыг эрхэмлэсэн учир гаднаас шилжин нүүхэд хүндрэлтэй.


Гэсэн хэдий ч ТББ-ууд бусад ТББ-тай хамгийн их хамтран ажилладаг гэдгээ илэрхийлсэн бол бусад бүрэлдэхүүн хэсгүүд нь бусад бүрэлдэхүүн хэсгүүдээс илүү өндөр төвшинд ТББ-тай хамтран ажилладаг гэдгээ илэрхийлжээ (ОУСБ болон аж үйлдвэрээс бусад). Энэ нь бүх бүрэлдэхүүн хэсгүүдийн хоорондын уялдаа холбоог хангахад ТББ -ууд чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг харуулж байна.



83ураг: Түншлэгчдийн (баруун) төрлүүд тус бүртэй хамтран ажилладаг гэж мэдээлсэн бүрэлдэхүүн хэсэг бүрийн (зүүн) тус бүрээс асуумжид оролцогчид

ТББ-ууд бусад ТББ-тай хамтран ажиллах өөр нэг шалтгаан нь шугаман дэд бүтцийн төслийн явцад зэрлэг ан амьтдыг хамгаалах бусад бүрэлдэхүүн хэсгүүдийн (өөрсдийгөө оролцуулаад) чадавх сул байгаа гэж тэд үздэгтэй холбоотой. Бусад бүрэлдэхүүн хэсгүүдэд WFLI -ийг хэрэгжүүлэх чадавхын төвшинг нэг бүрэлдэхүүн хэсэг хэрхэн үздэгийг ойлгохыг хүссэн бидний асуулгад бүх бүрэлдэхүүн хэсгүүд БОНБУ-ийн зөвлөхүүд болон ТББ-уудыг бусад бүрэлдэхүүн хэсгүүдээс өндөр чадавхтай гэж үздэг бөгөөд ихэнхдээ өөрсдийгөө хамруулдаг (9). Гэсэн хэдий ч бусад бүх бүлгүүд ТББ-уудыг өөрсдийг нь үнэлэн дүгнэж байгаа ТББ-аас илүү өндөр чадавхтай гэж үздэг. Ерөнхийдөө аж үйлдвэр (БОНБУ-ийн зөвлөхүүдийг эс тооцвол) болон шугаман дэд бүтцийн төлөвлөлтийн мэргэжилтнүүдийг засгийн газар болон ОУСБ-ын үнэлгээгээр үнэлэн дүгнэхэд WFLI -ийн хамгаалах арга хэмжээг үнэлэх, авч хэрэгжүүлэхэд хамгийн бага чадавхтай байна гэж дүгнэсэн.

Гэхдээ төрийн бус байгууллагууд өөрсдийгөө болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний зөвлөхүүдийг оролцуулаад бүх түншүүдийг бага чадавхтай гэж дүгнэсэн, шугаман дэд бүтцээс зэрлэг ан амьтанд үзүүлэх нөлөөллөөс хамгаалах мэргэжлийн ур чадвар, дадлага туршлагатай бүрдүүлэгч бүлгүүд харилцан адилгүй дадлага туршлагатай байна гэж дүгнэсэн.



9Зураг: бүрдүүлэгч дөрвөн бүлгийн үнэлгээгээр зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх түншүүдийн дундаж чадавх. Төр засгийн газар = улаан, ОУСБ= шар, аж үйлдвэр = хөх, төрийн бус байгууллага = ногоон өнгөөр тэмдэглэсэн. Чадавхыг 0-ээс (чадваргүй) 5 хүртэл (өндөр чадвартай) хүртэлх оноогоор дүгнэсэн. Цэг тэмдэгтүүд нь дундаж чадавхыг илэрхийлдэг, харин зурааснууд нь стандарт хэлбийлтийг илэрхийлдэг.

Ихэнх бүрдүүлэгч бүлгүүдийн дотор төрийн бус байгууллагууд WFLI-ийг хэрэгжүүлэхэд тодорхой хэмжээний чадавхтай гэсэн ойлголт байдаг. Гэхдээ төрийн бус байгууллагуудын өөрийн чадвар, чадавхын талаар бага ойлголттой байгаагаас харахад төслийн явцад нэмэлт чадварыг бий болгох шаардлагатай болох нь харагдаж байна. Аж үйлдвэр болон шугаман дэд бүтцийн төлөвлөгчдийн дүгнэгдсэн чадавх бага төвшинд байгаа шалтгаан нь WFLI-ийн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх, үнэлэх чадвар, чадавх бүхий түншүүдтэй хамтран чадварын сургалт зохион байгуулах, хамтран ажиллах тал дээр учир дутагдалтай байгаагаар холбоотой.

ЧАДАВХ БОЛОН ТӨСЛИЙН ХӨГЖЛИЙН ПРОЦЕССЫН ЯВЦ ДАХЬ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ


Одоогийн чадавхыг илүү сайн ойлгохын тулд уг судалгаанд бүрэлдэхүүн хэсгүүдээс төсөл боловсруулах үйл явцад оролцох талаар асуусан болно. Төсөл боловсруулах үйл явц нь төслийн ашиглалтын хугацаанаас эхлээд хамгаалалтын үр нөлөөний эхэн үеэс дуустал болон барилгын дараах хяналтыг хамардаг. Энд төсөл боловсруулах үйл явцыг сонгон шалгаруулалт, санхүүжилт, төлөвлөлт, зураг төсөл, зөвшөөрөл, барилга, барилгын дараах үе шаттайгаар тодорхойлдог. Хариуцлага тооцох ажлыг мөн өргөн хүрээний болон урт хугацааны үе шат гэж үздэг.

Долоон үе шатнаас судалгаанд оролцогчид хамгийн их оролцоо нь төлөвлөлтийн үе шатанд байгааг илэрхийлсэн (Зураг10). Сонирхолтой нь төсөл боловсруулах үйл явцын бүх долоон үе шатанд дөрвөн бүрэлдэхүүн хэсгүүдийн дотор оролцооны хамгийн өндөр давтамжтай байгаа нь ОУСБ байлаа. Үүний эсрэгээр ТББ-ууд долоон үе шатанд дөрвөн бүрэлдэхүүн хэсгийн

оролцооны хамгийн бага давтамжтай байсан бөгөөд ТББ-д оролцогчдын 40 гаруй хувь нь төсөл боловсруулах үйл явцад оролцоогүй гэдгээ шууд илэрхийлсэн байна.

Бидний тооцоолсны дагуу ОУСБ нь санхүүжилтэд маш их оролцдог боловч бусад үе шатуудад тодорхой хэмжээгээр үргэлжлүүлэн оролцдог, харин барилгын ажлын явцад зөвшөөрөл олгох, хяналт тавихад арай бага оролцоотой байв. Эдгээр нь хөнгөвчлөх арга хэмжээ гэх мэт хамгаалах арга хэмжээг хангахад чухал үүрэгтэй бөгөөд түүний үр ашигтай байдлыг дараа үнэлсэн. Судалгаанд хамрагдсан засгийн газрын оролцогчид төсөл боловсруулах үйл явцын дунд үе шатанд төлөвлөлтөөс зөвшөөрөл авах хүртэлх хугацаанд тэдний оролцоо хамгийн өндөр байдаг гэж мэдээлсэн бол салбарын оролцогчид төлөвлөлтөд маш их оролцдог, дараа нь зураг төсөл, зөвшөөрөл, барилга угсралтын ажилд оролцдоггүй гэжээ. Аж үйлдвэрийн салбартай холбоотой энэхүү өвөрмөц байдлыг нарийвчлан судлах шаардлагатай. Аж үйлдвэр нь зураг төсөл, барилгын ажилд аль алинд нь идэвхтэй оролцдог гэж таамаглаж байгаа боловч судалгаа нь тухайн үйлчилгээ үзүүлдэг компаниудад хүрч чадаагүй бөгөөд төслийн төлөвлөлтөд хамгийн их оролцдог БОНБУ-ийн зөвлөхүүдийн оролцоог бүрэн тусгасан байж болох юм.

Өмнө нь мэдээлж байсанчлан судалгаанд оролцсон ТББ-ын оролцогчид төсөл боловсруулах үйл явцын бүх долоон үе шатанд дөрвөн бүрдүүлэгч бүлгийн оролцоонд хамгийн бага давтамжтай байсан. Тэд оролцож байхдаа төлөвлөлтийн үе шатанд хамгийн өндөр давтамжтай байсан. Төрийн бус байгууллагын оролцооны энэхүү өвөрмөц дүр зургийг бид тайлбарлахдаа төрийн бус байгууллагууд шугаман дэд бүтцийн төлөвлөлт болон зөвшөөрөл авах үйл ажиллагаанд оролцдоггүй боловч БОНБУ-ний үед төлөвлөлт, зөвшөөрлийн үйл ажиллагаанд мэргэжлийн тусламж дэмжлэг өгөхөд тэдэнд ханддаг. Бодит төлөвлөлт, зөвшөөрөлтэй холбоотой шийдвэр гаргахад төрийн бус байгууллагуудыг оролцуулах эсвэл оролцуулахгүй байх сонголт хийгддэг. Эцэст нь хэлэхэд бүрдүүлэгч бүлгүүд нь сонгон шалгаруулалтын үе шатыг оролцооны үндсэн үе шат гэж үздэггүй, зэрлэг ан амьтны хэрэгцээ шаардлагатай холбоотойгоор төслийг хэрэгжүүлэх нь зүйтэй эсэх талаар шийдвэр гаргах үүргийг хэн хүлээх вэ гэсэн асуулт гарч ирнэ.




Зураг10: Шугаман дэд бүтцийн төслийн хөгжлийн долоон үе шат тус бүрд судалгаанд оролцогчдын оролцоог бүрдүүлэгч бүлэг тус бүрээр авч үзэв

Судалгааны оролцогчдын ихэнх нь оролцооны давтамжийг хамгийн их гэж тодорхойлоход (Зураг10) төлөвлөлтийн үе шатанд (II) зэрлэг ан амьтныг хамгаалах шийдвэр ихэвчлэн хийгдсэн бүрдүүлэгч дөрвөн бүлгийн оролцогчид, судалгааны оролцогчдын дунд ерөнхий гэрээ хэлцэл хийгддэг. Бүрэлдэхүүний бүх бүлгүүд төлөвлөлтийн үе шатыг байгаль хамгааллыг хэрэгжүүлэх зорилтыг дэвшүүлэх боломж гэж дүгнэсэн (II). Хэдийгээр бүрэлдэхүүний бүлгийн цөөн оролцогчид зэрлэг ан амьтныг хамгаалах нь сонголтын үе шатанд хөгжин бий болдог, шийдвэр гаргахад зарим хүндрэлтэй асуудлууд байдаг, төслийн хөгжлийн явцад байгаль зэрлэг ан амьтныг хамгаалах ажлуудыг хийдэг гэж дүгнэсэн. Төслийн хөгжлийн эхний үе шатанд зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээг авч үзээгүй бол зайлсхийх арга тактикийг зэрлэг ан амьтныг хамгаалах анхны хөнгөвчлөх арга хэмжээ байдлаар авч үзэхэд хүндрэлтэй байж болно. Санхүүжилтийн үе шатанд ОУСБ оролцогчдын 50-иас бага хувь нь байгаль хамгааллын асуудлыг авч үзэхдээ сургалт, мөн ирээдүйн чадвар, чадавхыг бий болгох явцад хэлэлцэх судалгааны асуултыг тайлбарлах, зохицуулалт талаас авч үзсэн. ОУСБ-ийн тодорхойлсноор хэдийгээр бусад бүрдүүлэгч бүлэг үүнийг нөлөөллийн үндсэн асуудал болгон авч үздэг боловч тэд бүтээн байгуулалтын үе шатанд хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлдэг. Сонирхолтой нь ОУСБ-ийн оролцогчид тодорхой хэмжээгээр төслийн явцад ерөнхий хяналт шалгалт хамгааллын араг хэмжээг хэрэгжүүлэхийг шаарддаг, харин төрийн бус байгууллагууд хариуцлагатай байдлыг хангахад хамгийн чухал үүрэгтэй.



13 Зураг: Зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээг шугаман дэд бүтцийн төслийн долоон үе шат тус бүрд хэрэгжүүлдэг, энэ нь төслийн бүх үе шатанд хариуцлагатай байдлаас шалтгаалдаг гэж үзэж байгаа оролцогчдын хувийг бүрдүүлэгч бүлэг тус бүрээр харуулав. "Авч үздэггүй" гэсэн хариулт нь судалгааны оролцогчид өөрийн бүх үйл ажиллагаандаа зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээг авч үздэггүй болохыг харуулна. Харин "Оролцдоггүй" гэсэн хариулт нь төслийн хөгжлийн явцад судалгааны оролцогчид оролцдоггүй болохыг илтгэнэ.

Шугаман дэд бүтцийн төслүүдэд зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд тулгарч байгаа саад бэрхшээл нь ихэвчлэн төлөвлөлт, бүтээн байгуулалт, зураг төслийн үе шатанд тулгардаг болсныг судалгааны оролцогчид хүлээн зөвшөөрсөн, шугаман дэд бүтцийн гурван үндсэн төрөлд цаашдын сургалтын үйл ажиллагааны гол асуудал болгон авч үзэхийг хүссэн (Зураг12). Аж үйлдвэрийн салбарын оролцогчдын үзэж байгаагаар зөвшөөрлийн үе шат нь бусад бүрдүүлэгч бүлгүүдтэй харьцуулахад илүү хүндрэлтэй гэж үзэж байгаа бол бараг бүх ОУСБ-ын оролцогчид зураг төслийн үе шат нь хамгийн чухал хүндрэлтэй асуудал гэж үзсэн. Хүндрэлтэй асуудлын нэг болох зөвшөөрлийн үйл явц нь хамгаалалтын ямар арга хэмжээ урт хугацааны, нарийн төвөгтэй зөвшөөрлийн үйл явцыг бүрдүүлдэг талаар мэдээлэл дутагдалтай байгаатай холбоотой. харин аж үйлдвэрийн салбарт дагаж мөрдөх зөвлөмж, удирдамж, шаардлагууд илүү тодорхой байдаг. Төрийн бус байгууллага болон аж үйлдвэрийн салбарын оролцогчдын дүгнэснээр хариуцлагатай байдал бол хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд тулгарч байгаа гол саад бэрхшээл бөгөөд энэ нь бусад бүрдүүлэгч хоёр бүлэг хариуцлагатай байдал дутмаг байгааг харуулж байна.




Зураг 12: Шугаман дэд бүтцийн төслийн үе шатанд зэрлэг ан амьтныг хамгаалахад саад бэрхшээл тулгардаг гэж үздэг оролцогчдын тоог бүрдүүлэгч бүлэг түс бүрээр авч үзэв

WFLI-Д ТУЛГАРЧ БАЙГАА СААД БЭРХШЭЭЛҮҮД

Төслийн хөгжлийн үе шатанд тулгардаг саад бэрхшээлийг заахаас гадна судалгааны оролцогчид эдгээр үндсэн саад бэрхшээлийн талаар анхаарлаа хандуулсан. Төрийн байгууллагууд, төрийн бус байгууллагуудын зүгээс судалгаанд оролцогчдын үзэж байгаагаар WFLI-ийг хэрэгжүүлэхэд тулгарч байгаа хамгийн их саад бэрхшээлтэй асуудал бол зэрлэг ан амьтныг хамгаалахад санхүүжилт дутмаг байх явдал юм. Үүнд аж үйлдвэрийн салбарын оролцогчид бага хувийг эзэлж байсан (Зураг 13). ОУСБ-ын хувьд энэ асуудалтай санал нэг бөгөөд зэрлэг ан амьтныг хамгаалахад санхүүжилтийг ашиглах асуудалд зээл олгогч болон зээл авагч нарын хооронд уялдаа холбоо муутай гэж дүгнэсэн. Төрийн бус байгууллагуудын үзэж байгаагаар гол үндсэн бэрхшээлийн нэг болох шугаман дэд бүтцийн үйл ажиллагаанд оролцох боломж дутмаг байгаа тухай мөн аль нэгэн бүрдүүлэгч бүлгийн заасан саад бэрхшээлтэй асуудлуудад хамгийн их давтамжтай гэдгийг онцлон тэмдэглэсэн.

Бүрдүүлэгч бүлгээс илэрхийлсэн хамгийн чухал асуудлуудад WFLI-д тулгарч байгаа нэг саад бэрхшээл бол бодлого шийдвэр дутмаг байдал бөгөөд энэ нь бүрдүүлэгч бүлгүүдийн дотор бараг тэнцүү хувь хэмжээтэй байна (зураг 13). Төр засгийн байгууллагууд, аж үйлдвэр, төрийн бус байгууллагуудын тодорхойлсноор зэрлэг ан амьтантай холбоотой мэдлэг чадвар, туршлага дутмаг гэж дүгнэсэн бол WFLI-ийн хөнгөвчлөх араг хэмжээнд бүтээн байгуулалтын дараах хяналт, үнэлгээг үр дүнтэй гэж дүгнэсэн. Төрийн байгууллагууд болон аж үйлдвэрийн байгууллагууд WFLI-ийн хамгаалах араг хэмжээг хэрэгжүүлэхийн тулд улс төрийн хүсэл эрмэлзэл, туршлага, хяналт, үнэлгээ, байгууллагын дэмжлэг дутмаг байгааг онцлон тэмдэглэв. Төрийн бус байгууллагууд болон ОУСБ нь институцийн дэмжлэг дутмаг байдлаас хүндрэл үүсдэггүй. Эцэст нь хэлэхэд ОУСБ-ын үзэж байгаагаар WFLI -д олон дэмжлэг дутмаг байх, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд олон нийтийн дарамт шахалт дутмаг байх зэрэг нь бусад бүрдүүлэгч бүлгээс илүүтэй хувийг эзэлдэг, бусад саад бэрхшээлүүд нь харьцангуй цөөн хувийг эзэлж байна. WFLI-д институцийн дэмжлэг дутмаг байх, эдийн засгийн бус зорилтуудад улс төрийн хүсэл эрмэлзэл дутмаг байх зэрэг нь хөгжиж байгаа орнуудад хамгийн түгээмэл байгаа бол ногоон дэд бүтцийг дэмжих төр засаг, үндэсний бодлого байхгүй

тохиолдолд хөгжлийн болон зэрлэг ан амьтныг хамгаалах норм, хэв хэмжээ нь эргээд WFLI-д олон нийтийн зүгээс дэмжлэг түслалцааг сайжруулж болно.



Зураг 13: Энэхүү цацраг хэлбэрийн графикт саад бэрхшээлийн төрлүүд нь шугаман дэд бүтцийн төслүүдэд зэрлэг ан амьтныг хамгаалах үйл ажиллагаанд саад болдог гэдэгтэй санал нийлж байгаа оролцогчдын тоо, эзлэх хувийн дөрвөн бүрдүүлэгч бүлгээр нь харуулав. Олон нийтийн дэмжлэг түслалцаа дутмаг, санхүүжилт дутмаг, улс төрийн эрмэлзэл дутмаг зэрэг хариултуудын хувьд төрийн албан хаагчдын хариултын хувь хэмжээ нь төрийн бүс ажилчдын хувь хэмжээтэй бараг ойролцоо байна. Иймээс графикийн зарим хэсэгт улбар шар зураас харагдахгүй байна.

Бүрдүүлэгч бүлгүүд зэрлэг ан амьтдыг хамгаалахад тулгарч байгаа хамгийн том бэрхшээлтэй асуудалд санхүүжилт, улс төрийн хүсэл эрмэлзэл, институцийн дэмжлэг, мэргэжлийн үр чадварын дутагдлуудыг нэрлэсэн. Судалгаанаас харахад төрийн бүс байгууллагууд төслийг хөгжүүлэх үйл ажиллагаанд оролцох боломж дутмаг байдаг.


ЧАДВАР, ЧАДАВХЫН ХЭРЭГСЭЛ

Тус судалгаа нь зэрлэг ан амьтныг хамгаалах үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхийн тулд төслийн хөгжлийн үйл ажиллагаанд оролцоход зарим хэмжээгээр шаардлагатай байгаа нэмэлт зүйлс, мэргэжлийн үр чадваруудыг судалсан. Судалгаанд оролцогчдын хамгийн олонх нь өртөг зардал-ашгийн дүн шинжилгээ (СВА) дутмаг, мөн хөнгөвчлөх, бууруулах арга хэмжээний дадлага, туршлага, зэрлэг ан амьтны талаарх мэдээлэл цуглуулах практик туршлага, мөн төлөвлөсөн төслийн дэлгэрэнгүй байдал, дэлгэрэнгүй мэдээлэл, өөр тусгай маршрут дутагдалтай байгааг тодорхойлсон. Бид эдгээр мэдээллүүдийг доор заасны дагуу нэг бүрчлэн судалсан.

ӨРТӨГ ЗАРДАЛ-АШГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

ОУСБ-ын оролцогчдын хариултын төвшин (60 хувиас дээш), аж үйлдвэрийн салбарын оролцогчдын хариултын түвшнээс (50 хувиас дээш) харахад эдгээр хоёр бүрдүүлэгч бүлэг нь шугаман дэд бүтцийн төсөлд зэрлэг ан амьтныг хамгаалах зорилгоор СВА-ийг тогтмол хэрэгжүүлдэг гэж үздэг. Төр засгийн байгууллагууд болон төрийн бус байгууллагуудын хариулт нэлээд бага, 30 орчим хувьтай гарсан (Зураг14). Үүнээс харахад зэрлэг ан амьтныг хамгаалах СВА-ы нь шугаман дэд бүтцийн төслүүдэд стандарт арга хэмжээ биш болох нь харагдана. ОУСБ ба аж үйлдвэрийн салбарын хариултын түвшнээс харахад СВА-ийг хэрэгжүүлэх, санхүүжүүлэхэд тэдний оролцооноос шалтгаална. Харин төрийн ба төрийн бус байгууллагууд тэдний үр дүнг ашиглах эсвэл хянан шалгадаг.

Үүнээс харахад хүний хөгжил болон зэрлэг ан амьтныг хамгаалах ландшафтын төвшний төлөвлөгөө боловсруулахад төрийн ба төрийн бус байгууллагуудын түншлэхэд нэлээд зөрүүтэй байдал үүссэн, гэхдээ шугаман дэд бүтцийн хөгжил болон зэрлэг ан амьтныг хамгаалах асуудлын хоорондох тэнцвэрийг ойлгох аж үйлдвэр ба ОУСБ-ын үйл ажиллагааны хүрээнд явагдаж байна. Төслийн зөвшөөрөл, төлөвлөлтийн үйл ажиллагаанд олон тооны бүрдүүлэгч бүлгүүдтэй хамтран ажиллаж, СВА-ийг гүйцэтгэх албан ёсны механизмыг бий болгосноор эдийн засгийн хувьд илүү үр дүнтэй төслүүдийг хэрэгжүүлэх, зэрлэг ан амьтныг илүү хамгаалахад чухал нөлөө үзүүлнэ.




Зураг14: Төслийн хөгжлийн явцад зэрлэг ан амьтныг хамгаалах зорилгоор ашиг-алдагдлын дүн шинжилгээг авч хэрэгжүүлэх эсэх талаар бүрдүүлэгч дөрвөн бүлгийн хариултын хувь давтамж.

БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ӨМНӨХ ЗЭРЛЭГ АН АМЬТНЫ ТАЛААРХ МЭДЛЭГ, МЭДЭЭЛЛИЙН БААЗ

Ойролцоогоор бүх бүрдүүлэгч бүлгийн оролцогчдын 56 орчим хувийн мэдээлснээр тэдний ажилладаг байгууллагууд шугаман дэд бүтцийн шинэ төслүүдэд зэрлэг ан амьтантай холбоотой бүтээн байгуулалтын өмнөх шатны мэдээллийг ашигладаг. Гэхдээ ойролцоогоор судалгаанд оролцогчдын 13 хувь нь зэрлэг ан амьтны мэдээллийг авах боломжтой байсан гэж хариулсан. Тодруулбал ОУСБ-ын оролцогчдын хэн нь ч бүтээн байгуулалтын өмнөх шатны зэрлэг ан амьтны тухай мэдээлэл боломжтой байсан хариулаагүй. Бүтээн байгуулалтын өмнөх шатанд зэрлэг ан амьтны тухайн мэдээллийн боломжит байдлын талаарх судалгааны эдгээр үр дүнгээс харахад одоогийн мэдээллээс гадна зэрлэг ан амьтан, түүний нутаг дэвсгэрийн талаар илүү дэлгэрэнгүй, өргөн хүрээний төвлөсөн мэдээлэл шаардлагатай, мөн шугаман дэд

бүтцийг хөгжүүлэгчид бүтээн байгуулалтын өмнөх шатны зэрлэг ан амьтны судалгаа, мэдээлэл цуглуулах, биологийн үнэлгээг санхүүжүүлэх шаардлагатай байна.

Зэрлэг ан амьтныг хамгаалах талаар мэдээлэл цуглуулахад ашигласан одоогийн эх үүсвэрийн талаар асуухад бүрдүүлэгч бүлгүүд судалгаанд санал болгосон бүх эх үүсвэрүүдийг янз бүрийн хэмжээгээр ашигласан гэдгээ илэрхийлсэн (Зураг15). Ерөнхийдөө бүрдүүлэгч дөрвөн бүлгийн ашигласан мэдээллийн эх үүсвэрүүдийн хооронд бага хэмжээний зөрүү байсан. Бүрдүүлэгч бүлгийн үйл ажиллагаатай нийцсэн хариултуудаас тодорхой харагдах хэд хэдэн чиг хандлага байна. Үүнд: төрийн байгууллагууд болон ОУСБ нь зэрлэг ан амьтныг хамгаалахтай холбоотой мэдээллийг олж авахдаа ихэвчлэн дотоод сургалт, гадаад уулзалтуудыг ашигладаг ба ОУСБ болон аж үйлдвэрийн салбар нь ихэвчлэн зөвлөхүүдийг ашигладаг. Зэрлэг ан амьтантай холбоотой мэдээллийг олж авахад веб хайлт хийх, гарын авлага, шинжлэх ухааны судалгаа хийх, түншүүдтэй хамтран ажиллах зэрэг нь бүх бүрдүүлэгч бүлгүүдэд түгээмэл харагдаж байсан. Зэрлэг ан амьтны талаарх мэдээллийн төвлөсөн бааз, сан нь шаардлагатай мэдээлэл, байгаль хамгааллын хамгийн сүүлийн үеийн мэдээлэл, шугаман дэд бүтцийн тэргүүн түршлага, стандарт, зөвлөмж, удирдамж зэргээр хангаж, бүх бүрдүүлэгч бүлгүүдийн хувьд мэдээлэл олж авахад чухал ач холбогдолтой.




Зураг15: Зэрлэг ан амьтныг хамгаалах мэдээллийн эх үүсвэр, олон төрлийн мэдээллүүдийг ашиглахтай холбоотой бүрдүүлэгч дөрвөн бүлгийн хариултыг хувиар харуулсан байдал

СУРГАЛТЫН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА БА ТОДОРХОЙЛСОН СЭДВҮҮД

Бүрдүүлэгч бүлгээс хамаарахгүйгээр судалгаанд оролцогчид шугаман дэд бүтцийн нөлөөллөөс зэрлэг ан амьтныг хамгаалахын тулд сургалтын боломж, нөхцөлүүдэд илүү их анхаарлаа хандуулсан (86 хувь). Дээрх үнэлгээнээс харахад зарим сэдвүүд бүрдүүлэгч бүлгүүдийн дотор чадвар, чадавхын хэрэгцээ байдлаар дахин давтагддаг. Бид бүрдүүлэгч бүлгүүд шугаман дэд бүтцийн төслүүдэд зэрлэг ан амьтны хамгаалалтыг хэрэгжүүлэх зорилгоор чадавхыг болгохыг хүсэж байгаа сургалтын төрөл, мэдээллийн талаар тусгайлан асуусан (Зураг16 (а)). ОУСБ ба төрийн бус байгууллагууд сургалтын семинар (богино I-цагийн онлайн сургалт), тусгай арга хэмжээнд (олон өдрийн сургалт) өргөнөөр хамрагдсан. Гэхдээ хээрийн дадлагатай хослуулсан тохиолдолд тусгай арга хэмжээг ихэвчлэн төрийн ба төрийн бус байгууллагууд илүү чухалчлан үздэг. ОУСБ болон төрийн бус байгууллагууд нь зэрлэг ан амьтныг хамгаалах төлөвлөлт, үзүүлэлтийн (жишээ нь зэрлэг ан амьтны гарцын хэмжээ гэх мэт) чиглэлээр зөвлөмж, удирдамж мэдээллийн төвлөрсөн лавлахын (онлайн номын сан, кэйс судалгаанууд,

төлөвлөлтийн зөвлөмж, доорх зурагт "мэдлэгийн сан" гэж нэрлэсэн) ач холбогдлыг өндрөөр үнэлдэг. Бүх бүрдүүлэгч дөрвөн бүлэг чухалчлан үздэг сонголтуудад онлайнаар явуулах их сургуулийн төвшний курс, хичээлүүдийг (боловсролын кредит оноо болон гэрчилгээ олгодог) хамгийн доод төвшинд авч үзсэн.

Сургалтын сэдвийн хувьд бүх бүрдүүлэгч бүлгээс судалгаанд оролцогчид санал болгосон бодлого зохицуулалт, төлөвлөгөө, зураг төсөл, хөнгөвчлөх, хяналт тавих зэрэг бүх шийдлүүдэд ихээхэн анхаарал хандуулсан(Зураг16 (b)). Төрийн бус байгууллагууд болон аж үйлдвэрийн салбар хэрэгцээ шаардлагаараа нэгдмэл бөгөөд WFLI-ийн чиглэлээр төлөвлөлт, зураг төслийн сургалтыг сонирхдог. Төрийн бус байгууллагууд нь хэрэгцээ шаардлагын хувьд төрийн байгууллагуудтай санал нэгдэж, бодлого шийдвэр, хяналт, хөнгөвчлөх арга хэмжээний сургалтын илүүтэй сонирхсон. ОУСБ-ын оролцогчид бүх бүрдүүлэгч бүлгүүдийн өндөр хувь хэмжээтэй хамт сургалтыг илүү сонирхож байгаа нь ОУСБ-ын хүрээнд WFLI-ийг хэрэгжүүлэхэд сургалт нэн тэргүүний чухал асуудал болохыг харуулж байна. Ерөнхийдөө бидний үр дүнгээс харахад чадавхыг бий болгох үр дүнтэй сургалтуудад бүрдүүлэгч бүлгийн хүрээнд ижил төстэй сэдвүүд байж болохыг харуулдаг. Өмнөх үр дүнгээс харахад төслийн хөгжлийн явцад бүрдүүлэгч бүлгүүд өөр хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх шаардлага байгаа боловч сургалтууд нь тухайн хэрэгцээ шаардлагад янз бүрийн оролцогчдыг татан оролцуулах боломжийг бүрдүүлдэг. Цаашлаад стандарт сургалтаар бүх бүрдүүлэгч бүлгүүдэд ерөнхий суурь мэдлэгийг олгосноор ирээдүйн хамтын ажиллагаа нэгэн жигд, тогтвортой төвшинд явагдана.



Зураг 16: (а) зэрлэг ан амьтны талаарх сургалтад баримтлах нэн тэргүүний механизм (b) зааварчилгаа, заавар өгөхөд чухал сэдвүүдийн талаар бүрдүүлэгч дөрвөн бүлгийн өгсөн хариултыг хувиар илэрхийлсэн цацраг хэлбэрийн график.

ӨӨРМӨЦ БҮРДҮҮЛЭГЧ БҮЛГҮҮДЭД ЗОРИУЛСАН ЧАДАВХЫН ДҮГНЭЛТ

Өмнөх бүлэгт судалгааны хариултыг бүхэлд нь мөн бүрдүүлэгч дөрвөн бүлгийг хооронд харьцуулсан байдлаар авч үзсэн. Энэхүү дараагийн бүлэгт чадавхын хэрэгцээ шаардлагыг нарийн төвшинд үнэлэхэд туслах, зэрлэг ан амьтныг хамгаалах үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхэд сургалтын үйл ажиллагааг чиглүүлэх бүрдүүлэгч бүлгээс хамааралтай дүгнэлтүүдийг танилцуулсан.


ЗАСГИЙН ГАЗАР

Төр засгийн газар нь биологийн төрөл зүйлийг хамгаалахын тулд олон улсын зорилго, зорилтуудыг үндэсний зорилго, зорилтуудтай уялдуулах шаардлагатай. Иймээс төр засгийн газрууд олон улсын хөтөлбөр, олон улсын төвшинд хүлээсэн үүрэгт нийцүүлэх үндэсний бодлого, хөтөлбөрийг баталдаг. Энэхүү судалгаанд мэдлэг мэдээллээр авах төрийн албан хаагчдын чадавхыг тодорхойлох, үндэсний байгаль хамгааллын үүрэг хариуцлага, үйл ажиллагааны хүрээнд ажиллах мэргэжилтнүүдийн чадавхыг тодорхойлохыг эрмэлзсэн.

Төр засгийн газраас судалгаанд оролцогчид биологийн төрөл зүйл, амьтдын нүүдэл, байгалийн өв, үржил шимтэй газар зэрэг зэрлэг ан амьтныг хамгаалахтай холбоотой судалгаанд тодорхойлсон долоон MEAs-ийн талаар өргөн мэдээлэлтэй байсан. Эдгээр оролцогчдын олонх нь өөрийн байгууллагад зэрлэг ан амьтныг хамгаалах талаар олон улсын зорилго, зорилтын талаар ажилчдад мэдлэг, мэдээлэл өгөхөд албан ёсны системтэй (нийт 91 хариултын 44-д буюу $n=44$), мөн албан бус системтэй (нийт 91 хариултын 17 нь буюу $n=17$) гэж батлан хариулсан. Зэрлэг ан амьтныг хамгаалахтай холбоотой олон улсын зорилго, зорилтод хяналт тавих, мөн төрийн байгууллагуудад танилцуулах гэрээ хэлэлцээрийг батлах, үндэсний үйл ажиллагааны талаар мэдээлэх үүрэгтэй төрийн албан хаагч байдаг эсэх (байгаа =46, байхгүй= 37, итгэлтэй биш=10).

Хэдийгээр байнгын биш боловч өөрийн байгууллагад нь MEAs-ийг дэмжихэд шаардлагатай үйл ажиллагаатай холбоотой нөөцийг ашиглах эрхийг албан хаагчдад олгосон гэж зарим оролцогчид хариулсан (эрхийг олгосон =48, эрхийг олгоогүй =20, итгэлтэй биш=24). Тус судалгаа нь зэрлэг ан амьтныг хамгаалах чиглэлээр илүү нарийн төвшинд ажилладаг засгийн газрын агентлагуудын ялгааг мэдэхийг хичээгээгүй. Иймээс олон улсын байгаль хамгаалал,

зэрлэг ан амьтныг хамгаалах зорилтын төлөө ажилладаг төрийн байгууллагууд дотоодын шугаман дэд бүтцийн байгууллагууд, төслүүдтэй үйлдээ холбоотой ажилладаг эсэхийг тодруулахын тулд цаашид нэмэлт судалгаа хийх шаардлагатай. Гэхдээ тус судалгаа нь үндэсний төвшинд төрийн байгууллагууд зэрлэг ан амьтныг хамгаалахтай холбоотой олон улсын зорилго, зорилтуудын чиглэлээр ажиллахад ажилтнуудын чадавхыг дээшлүүлэх зорилгоор зохион байгуулалттай үйл ажиллагаа, институцийн дэмжлэг түслалцаа үзүүлдэг эсэхийг тодорхойлсон. Тэдгээр нь үүнийг хийхдээ чадавхыг бий болгох хамгийн түгээмэл ерөнхий арга хэмжээ бол тусгай арга хэмжээ, сургалт зохион байгуулах, хэвлэлийн материал тараах, магадлан итгэмжлэх зэрэг хэлбэрээр хэрэгжүүлдэг (Зураг 17).



Зураг 17: MEA-д хамаарах төр, засгийн газрын зорилго зорилтын талаар сүрч мэдэхийн тулд албан хаагчдын авах боломжтой чадавхыг бий болгох арга хэмжээний олон төрлүүдийг тодорхойлсон төр засгийн бүрдүүлэгч бүлгийн хариулагчдын тоо.


Судалгаанд оролцогчдын олонх нь (93-аас 58-нь) төр, засгийн газрын байгууллагын ажилтнууд шугаман дэд бүтэцтэй холбоотой зэрлэг ан амьтныг хамгаалах тухай сургалтад суусан гэж хариулсан. Сургалтад суусан ажилтнуудын бараг тал орчимд байгууллагын зүгээс заавар зөвлөгөө өгсөн (n=18), үлдсэн тал орчим хувьд өөр байгууллагаас заавар зөвлөгөө өгсөн (n=20). Төр засгийн байгууллагын оролцогчдын тодорхойлсноор сургалтыг зохион байгуулах гол шалтгаан нь донор болон санхүүжүүлэгч байгууллагатай холбоотой (n=35), хуулийн шаардлагаар (n=25), MEA-ийн шаардлагаар (n=28) гэж хариулсан. Зэрлэг ан амьтныг хамгаалах сургалтад манай төслийн үнэлэн дүгнэсэн шугаман дэд бүтцийн гурван хэлбэр, төрөл (авто зам =46, төмөр зам =25, цахилгаан дамжуулах шугам =28), төлөвлөлтийн (n=33) асуудлыг хамруулсан.

Судалгаанд оролцогчид мөн зэрлэг ан амьтанд шугаман дэд бүтцийн үзүүлэх нөлөөлөлд хандахад өөрийн байгууллагад хүчин чадавх дутагдалтай эсэх тухай асуултад 88-аас 50 нь чадваргүй (n=26), зэрлэг ан амьтанд үзүүлэх нөлөөллийн асуудлыг бусад хөтөлбөрөөр шийдвэрлэдэг, гэхдээ шугаман дэд бүтцийн экспертэд ийм үүрэг олгоогүй (n=24) гэж хариулсан(Зураг18 (a)). Гэхдээ 19 оролцогч зэрлэг ан амьтныг хамгаалах чиглэлээр дадлага туршлагатай ажилтантай гэж хариулсан, 9 оролцогч өөрийн байгууллага нь шугаман дэд бүтцийн нөлөөллөөс зэрлэг ан амьтныг хамгаалах тусгай иж бүрэн хөтөлбөрийг хэрэгжүүлдэг гэж хариулсан. Төр засгийн ажилтнуудын зүгээс ийм ялгаатай хариулт өгч байгаа шалтгаан нь

зэрлэг ан амьтан, авто зам, төмөр зам, цахилгаан дамжуулах шугам, төлөвлөлттэй холбоотой төр, засгийн газрын хэлтэс, албадуудын хүрээнд маш олон янзын үүрэгтэй холбоотой.

Төр засгийн зүгээс судалгаанд оролцогчид WFLI-д ажиллах хүний нөөцийн чадавхтай үед бие даасан төслүүдэд шаардлагатай дотоод болон гадаад үүрэгтэй харьцуулахад илүү түгээмэл тохиолддог. Гэхдээ судалгаанд оролцогчдын олонх энэхүү үйл ажиллагааг гүйцэтгэх тусгай ажилтан байхгүй гэж онцлон тэмдэглэсэн (Зураг18 (a)).

(a)




(b)

Зураг18: (a) өөрийн байгууллага нь шугаман дэд бүтцийн зүгээс зэрлэг ан амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг хариуцдаг ажилтны чадавхын талаар (b) шугаман дэд бүтцийн зүгээс зэрлэг ан амьтанд үзүүлэх нөлөөллийг хариуцсан ажилтанд шаардлагатай чадварын талаар тодорхойлсон төр засгийн байгууллагаас оролцсон оролцогчдын тоо.

Тус судалгаа нь зэрлэг ан амьтан, авто зам, төмөр зам, цахилгаан дамжуулах шугам, төлөвлөлтийг хариуцсан төр засгийн байгууллагын оролцогчдод чиглэсэн. Шугаман дэд бүтцийн зүгээс зэрлэг ан амьтанд үзүүлэх нөлөөллөөс хамгаалах арга хэмжээний шаардлага, мэргэжлийн үр чадвар, хүний нөөцийн төвшинтэй холбоотой асуудлуудад төр засгийн янз бүрийн байгууллагуудын чадавх ямар байгаа тодорхойлсон хариултаас харахад судалгаанд хамрагдсан бүх таван улсын төр засгийн байгууллагууд, шугаман дэд бүтцийн төрлүүдэд чадавхыг бэхжүүлэх шаардлагатай. Дараа нь бид зэрлэг ан амьтныг хамгаалах асуудлыг тусгахын тулд шугаман дэд бүтцийг хөгжүүлэх үйл ажиллагаанд чухал үе шатах болох Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд анхаарлаа хандуулсан. Бид Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хөгжилд бүрдүүлэгч янз бүрийн бүрэлдэхүүн хэсгүүдийн үүрэг, хариуцлагын талаар төр засгийн байгууллагын ажилтнуудын ойлголт, ухамсрын талаар үнэлгээ хийхийг эрмэлзсэн.

Төслийн хөгжлийн явцад төр засгийн байгууллагууд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хөгжлийг удирдах үүрэгтэй гол оролцогч хэвээр үлддэг бөгөөд гол шаардлага нь шугаман дэд бүтцийн зүгээс зэрлэг ан амьтанд үзүүлэх нөлөөллийг ойлгох, шаардлагатай хамгаалалтын арга хэмжээг төлөвлөх явдал юм. Төр засгийн байгууллагын зүгээс судалгаанд оролцогчдын тодорхойлсноор төр, засгийн болон хувийн санхүүжилттэй шугаман дэд бүтцийн төслүүдэд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ шаардлагатай, дотоодын санхүүжүүлэгчид, хувийн аж үйлдвэрийн хөгжүүлэгчид зэрэг төр засгийн янз бүрийн бүрдүүлэгч бүлгүүд бүгд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэдэг (19). Хариултааас харахад төр засгийн байгууллагууд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ-ийг шаардах болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг эцсийн байдлаар батлахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний процессын явцад төр засгийн байгууллагууд аж үйлдвэр болон санхүүжүүлэгч байгууллагуудтай хамтран ажилладаг. Төр засгийн байгууллагууд нь аж үйлдвэрийн хөгжүүлэгчид болон санхүүжүүлэгчдийн талаар дүгнэхдээ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд чухал үүрэгтэй бүрдүүлэгч бүлэг гэж дүгнэдэг. Мөн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний бэлтгэлд аж үйлдвэрийн хөгжүүлэгчдийн үүрэг оролцоог онцлон тэмдэглэдэг. Энэхүү үүрэг оролцооны талаарх ойлголтоос харахад чадвар, чадавхад тодорхой саад бэрхшээлүүд тулгардаг. Жишээ нь ил тод байдал, хариуцлагатай байдал, удирдлага, зохион байгуулалт хангалтгүй бол Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ-ийг хөгжүүлэх нь зэрлэг ан амьтанд сөрөг үр дагавар учруулдаг, хангалттай хамгаалах араг хэмжээ учир дутагдалтай, үр дүнгүй болдог. Энэ нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тодорхой бус, ил тод бус байдал, олон нийт, гуравдагч талын үзэл бодлыг хүлээн аваагүйтэй холбоотой.



19Зураг: Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хөгжилд янз бүрийн бүрдүүлэгч бүлгийн гүйцэтгэх үүргийг тодорхойлсон төр засгийн оролцогчдын хувь


ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН ХҮРЭЭЛЭНГҮҮД

ОУСБ-ын бүрдүүлэгч бүлгээс судалгаанд оролцогчдыг авч үзвэл төв оффист ажилладаг ажилтнууд (n=17, байгаль орчны төв нэгж, тасаг 10, бүсийн ба улсын хэлтэс 7), суурин төлөөлөгч (n=12) байна. Үндсэндээ ОУСБ -ийн мэдээлснээр өөрийн байгууллага нь IFC PS6-ийг (n=4) дагаж мөрддөг, эсвэл үүнтэй дүйцэх өөр үйл ажиллагааны стандарттай (n=20) гэж хариулсан. Өөрийн байгууллагын бодлого, шийдвэр нь IFC PS56-аас илүү нарийн, өндөр шаардлагатай гэж зургаан оролцогч үзсэн ч байгууллагын бодлого шийдвэр нь зээл авагч орны бодлого шийдвэрт суурилсан гэж хоёр оролцогч хариулсан.

Өргөн хүрээтэй байгаль орчин, нийгмийн (E&S) стандартуудаас гадна ОУСБ -ийн оролцогчдын мэдээлснээр өөрийн байгууллага нь WFLI-ийн чухал асуудлуудын ихэнхийг өөрийн байгууллагын бодлого шийдвэрт тусгасан гэж хариулсан. Шугаман дэд бүтэцтэй холбоотойгоор зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээг томьёолох боломж нөхцлийг E&S стандартын хүрээнд (n=26), мөн санал гомдлыг шийдвэрлэх механизмаар дамжуулан шийдвэрлэдэг (n=24) гэж тодорхойлсон. CBAs-ийг хэрэгжүүлэх шаардлага (n=15), WFLI-ийн удирдамжийг бэлтгэх шаардлага (n=14) нь бусад ихэнх сэдвүүдээс бага хувийг эзэлж байсан. Зэрлэг ан амьтныг хамгаалахад гол анхаарлаа хандуулдаг оролцогчдын зөвлөх бүлгийн үрт хугацааны үйл ажиллагааны санхүүжилт (n=4), зэрлэг ан амьтны, тэдгээрийн нутаг дэвсгэртэй холбоотой урьдчилан тодорхойлох боломжгүй хэрэгцээ шаардлагын талаар судалгааны оролцогчид хамгийн бага дурдсан.

ОУСБ -ийн оролцогчид хөнгөвчлөх арга хэмжээний шатлал тодорхой (25 хариултаас 22 нь эерэг байдлаар хариулсан), зайлсхийх гэх мэт хөнгөвчлөх боломжит арга хэмжээнүүдийг ОУСБ-ын бодлогын хүрээнд тодорхойлдог гэж онцлон тэмдэглэсэн. Судалгааны оролцогчид төслийн WFLI-ийг дагаж мөрдөх асуудлыг хөгжилтэй холбоотой арга хэмжээтэй нэгтгэдэг, техник, арга зүйн дэмжлэг туслалцаа (n=24), сургалт (n=23), мэдлэгийн удирдлага зохион байгуулалтаар (n=19) дамжуулан шугаман дэд бүтэцтэй холбоотой зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх тухай заасан.



Судалгааны үр дүнгээс харахад ОУСБ-ууд нь хөнгөвчлөх шаталсан арга хэмжээний хүрээнд "хөнгөвчлөх", "бууруулах", улмаар "зайлсхийх" аргуудыг ашигладаг гэж өөрийгөө дүгнэсэн (20). Хөнгөвчлөх арга хэмжээний нэг болгон нөхөн төлбөр гэж маш цөөн оролцогч хариулсан. Төслийн хөгжлийн явцад зэрлэг ан амьтны маршрутыг сонгох замаар зэрлэг ан амьтны нутаг дэвсгэрээс зайлсхийх аргатай харьцуулахад ОУСБ нь шугаман дэд бүтэцтэй холбоотойгоор зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхээр ажилладаг, гэхдээ бүтээн байгуулалтын дараагаар хөнгөвчлөх нөлөөлөлд илүүтэй найддаг. Хөнгөвчлөх шаталсан арга хэмжээнд нөхөн төлбөрийн аргаас илүүтэйгээр зайлсхийх аргыг илүүтэй хэрэглэдэг эсэхийг тодорхойлохын тулд ОУСБ төслийн үндэсний мэдээллийн сангаар дамжуулан 20-р зурагт танилцуулсан үр дүнг баталгаажуулах боломжтой гэдгийг бид зөвлөж байна.



20Зураг: Азийн шугаман дэд бүтцийн төсөлд хөнгөвчлөх шаталсан арга хэмжээнд хамгийн их ашигласан сонголт, аргыг тодорхойлсон ОУСБ бүрдүүлэгч бүлгийн оролцогчдын тоо

ОУСБ оролцогчид стандартчилсан ESIAs-ийг дагаж мөрдөх бодит зээлийн зарцуулалтаас бусад төслийн хөгжлийн үе шатуудад байгаль орчны болон нийгмийн нөлөөллөөс зайлсхийх аргуудыг чухалчлан авч үзсэн. Судалгааны оролцогчид зээлийн зарцуулалтын талаар дүгнэхдээ цэвэр удирдлагын үе шатанд хамаарах асуудал бөгөөд төслийн эхний шатуудад байгаль орчны асуудлуудад хандахад чиглэсэн арга хэмжээ гэж дүгнэсэн. ОУСБ-ын оролцогчид зэрлэг ан амьтныг хамгаалах талаар тусгай ажилтан, албан хаагчтай (28-аас 26) бөгөөд зэрлэг ан амьтныг хамгаалах төсөв, зардлыг ихэнх шугаман дэд бүтцийн төслийн төсөвт багтаан авч үздэг (27-аас 23 оролцогчийн хариулт эерэг байсан). Зэрлэг ан амьтныг хамгаалах төслийг хэрэгжүүлэхэд төсөлд хамрагдсан ОУСБ болон бусад оролцогчдын хооронд дотоод болон гадаад зохицуулалтын механизмууд байдаг.

ОУСБ нь дотоод чадавхыг бий болгохын тулд янз бүрийн арга хэмжээнүүдийг хэрэглэдэг, энэ нь үндсэндээ ажиллах хүчний сургалт, семинар, сургалтын гарын авлага зэрэг зүйлст анхаарлаа хандуулдаг (21 (a)). Зээл авагч, тусламж хүлээн авагч зэрэг түншүүдтэй хамтран шугаман дэд бүтцийн төсөлд зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх гадаад чадавхыг бий болгохын тулд ОУСБ нь зохих үр чадвар бүхий түр хугацааны зөвлөхийг хөлслөн ажиллуулах, чадавхыг бий болгох үйл ажиллагаанд санхүүжилт олгох, үндсэн түншүүдтэй хамтран ажиллах хандлагатай (21 (b)).




21Зураг: (а) дотооддоо чадавхыг бий болгох зорилгоор ОУСБ-үүд-ээс баталсан янз бүрийн арга хэмжээнүүд (P= биечлэн мөн PR= танхимын ба давтан), (b) гадаад түншүүдэд чадавхыг бий болгох зорилгоор ОУСБ-үүд-ээс баталсан арга хэмжээнүүд.


Эцэст нь хэлэхэд ОУСБ судалгаанд бүх таван улсад зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээ бүхий төслүүдэд хамрагдсан болохыг тодорхойлсон, мөн зарим нь эдгээр үлс орнуудтай хамтран зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээг хамруулах уялдуулан зохицуулах системтэй гэсэн тайлбарыг өгсөн.

АЖ ҮЙЛДВЭРИЙН ХОЛБОО

Аж үйлдвэрийн оролцогчид хувийн салбарын байгууллагууд шугаман дэд бүтцийн нөлөөллийг хөнгөвчлөх зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээг багтаах, хэрэгжүүлэхийг ерөнхийдөө хичээдэг гэж хариулсан (46 хариултаас 21 = маш их эрмэлздэг, 21 = тодорхой хэмжээгээр эрмэлздэг). Оролцогчдын тодорхойлсноор аж үйлдвэрийн байгууллагууд шугаман дэд бүтцийн төслүүдэд хөнгөвчлөх арга хэмжээний чиг хандлага, аргуудыг хэрэглэдэг ч оролцогчдын гуравны нэг нь авч хэрэгжүүлсэн хөнгөвчлөх арга хэмжээний талаар ойлголтгүй байсан (22 (a)). Зэрлэг ан амьтанд үзүүлэх нөлөөллийг бууруулах, зайлсхийх зорилгоор шугаман дэд бүтцийн маршрутыг өөрчилсөн бөгөөд энэ нь хөнгөвчлөх шаталсан арга хэмжээнд шугаман дэд бүтцийн төслүүдэд түгээмэл хэрэглэдэггүй арга гэж арван хоёр оролцогч хариулсан. Гэхдээ хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсэн гэж хариулсан аж үйлдвэрийн салбарын оролцогчид зэрлэг ан амьтанд зориулсан гарц, тэмдэг байрлуулах замаар энэ арга хэмжээг хэрэгжүүлдэг гэж хариулсан (22 (b)). Хэдийгээр өртөг зардал өндөр биш боловч тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах нь зэрлэг ан амьтныг хамгаалах, машинтай мөргөлдөхөөс сэргийлэх хамгийн хямд арга хэмжээнүүдийн нэг бөгөөд гарц, зөрлөг байгуулах нь харьцангуй өртөг зардал өндөртэй арга юм (жишээ нь замын дээгүүрх болон нүхэн гарц нь маш өндөр өртөгтэй) (Huijser et al., 2009). Сургалт зохион байгуулах нь хөнгөвчлөх боломжит арга хэмжээнүүдийн талаар оролцогчдын мэдлэг боловсролыг нэмэгдүүлэхэд чухал шаардлагатай. Төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ үе шатанд эдгээр хөнгөвчлөх арга хэмжээнүүдийг эхлэн хамгийн түгээмэл авч үзсэн, эдгээрийн дараагаар техник-эдийн засгийн судалгаанд авч үзсэн бол зураг төслийн үе шатанд харьцангуй ховорхон авч үзсэн. Төслийг хөгжүүлэх эхний үе шатнаас эхлэн хөнгөвчлөх арга хэмжээнүүдийг багтаан оруулдаг.



(b)




22Зураг: (а) Азийн шугаман дэд бүтцийн төслүүдийн сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор сүүлийн таван жилд авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд (b) Азийн шугаман дэд бүтцийн төслүүдийн нөлөөллөөс зэрлэг ан амьтныг хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд.

Аж үйлдвэрийн салбарынхан шугаман дэд бүтцийн төслийн нөлөөллөөс зэрлэг ан амьтныг хамгаалахын тулд хөнгөвчлөх шаталсан арга хэмжээнд чухал сонголт болох зам, чиглэл, маршрутыг өөрчлөх (22 (b)) зэрэг олон арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлдэг. Зэрлэг ан амьтныг хамгаалахад хамгийн түгээмэл хэрэглэсэн арга хэмжээ нь анхааруулах тэмдэг, түүний дараагаар зэрлэг ан амьтанд зориулсан гарц, зөрлөг, хүн ба зэрлэг ан амьтанд хоёуланд нь зориулсан хос зориулалттай байгууламж (жишээ нь гүүр, нүхэн гарц, хоолой гэх мэт), амьтантай мөргөлдөхөөс сэргийлэх бусад зүйлс (жишээ нь хурд сааруулагч, хурд сааруулах арга хэмжээнүүд, цахилгаан дамжуулах шугамд шувуу үргээгч гэх мэт) удаалж байна.

Үүнээс гадна зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээний өртөг зардлыг төслийн анхан шатны төсөвлөлтөд ихэвчлэн оруулдаг боловч бодитоор хэрэгжүүлсэн тохиолдлуудад хөнгөвчлөх арга хэмжээний үр дүнг хянан үздэг гэж оролцогчид тайлбартаа дурдсан.

Эко системийн сургалт, түүний нутаг дэвсгэрт нөлөөлөх, ан амьтны хөдөлгөөнд нөлөөлөх, СВА зэрэг арга хэмжээнүүд нь бүх таван улсаас судалгаанд оролцсон аж үйлдвэрийн салбарын оролцогчдын эхний гурван сонголт байв (23). Энэ бол экологийн болон эко системийн асуудлууд нь аж үйлдвэрийн салбарын мэргэжилтнүүдийн СВА-тэй ижил төвшинд байгаагийн илрэл юм. Аж үйлдвэрийн салбараас судалгаанд оролцогчдын хариултаас харахад зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээний ач холбогдлын талаарх ойлголт өндөр төвшинд байгааг илэрхийлнэ. Ирээдүйн сургалт болон чадавхыг бий болгох үйл ажиллагаанууд нь аж үйлдвэрийн салбар зэрлэг ан амьтан, түүний нутаг дэвсгэр, экологийн үйлдвэр хамгаалахад хамгийн үр дүнтэй арга хэмжээ гэдгийг ойлгуулахад анхаарлаа хандуулах нь зүйтэй.



23Зураг: Шугаман дэд бүтцийн зүгээс зэрлэг ан амьтныг хамгаалах тухай сургалтын үйл ажиллагаанд багтаах үндсэн асуудлуудын талаар төслийн төлөөллийн таван улс тус бүрд аж үйлдвэрийн салбарын бүрдүүлэгч бүлгийн гишүүдийн хариултын хувь хэмжээ (n=45).

Аж үйлдвэрийн салбарын бүлгийн хариултаас харахад оролцогчид, тэдний компаниуд төслийг хөгжүүлэх үйл ажиллагаанд оролцдог хөнгөвчлөх арга хэмжээний талаар бүтээн байгуулалтын дараах шатанд хяналт тавихын ач холбогдол, дэд бүтцийн олон төслүүдээс үзүүлэх ерөнхий нөлөөллийг үнэлэх хэрэгцээ шаардлагын талаарх ойлголтыг илэрхийлсэн. Үүнээс гадна аж үйлдвэрийн салбарын оролцогчдын тал хагас орчим шугаман дэд бүтцийн төслийн хөгжүүлэлт, зураг төсөл, бүтээн байгуулалтын үе шатанд зэрлэг ан амьтныг хамгаалах араг хэмжээг хэрэгжүүлэх аж үйлдвэрийн салбарын үйл ажиллагааг удирдах, зохицуулах хууль тогтоомж, зохицуулалтын талаар мэдээлэлтэй байсан (25 нь тийм, 20 нь үгүй гэж хариулсан, нийт 45 оролцогч оролцсон). Зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээний талаар оролцогчид тодорхойлохдоо тэд өөрийн улс орондоо зэрлэг ан амьтан, биологийн төрөл зүйлийг хамгаалах хууль тогтоомжтой холбоотой зүйлсийн талаар ойлголт, мэдээлэлтэй байсан.

Аж үйлдвэрийн салбарын оролцогчдын илэрхийлснээр шугаман дэд бүтцийн төслүүдэд зэрлэг ан амьтныг хамгаалах зорилгоор сайн дурын стандарт (зайлшгүй мөрдөх бус), зөвлөмж, удирдлага зохион байгуулалтын тэргүүний практикуудыг дагаж мөрддөг. Цөөн тооны оролцогчид орон нутгийн олон нийт, нийгмийн үгээс үзүүлэх дарамт шахалтын улмаас зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд орон нутгийн, үнэ цэнд тулгуурласан, сайн дурын үйл ажиллагаануудыг онцлон тэмдэглэсэн. WFLI-ийн зорилгоор санхүүжилт, зөвшөөрөлтэй холбоотой албан ёсны үүрэг шаардлагаас бусад нэн тэргүүний практик үйл ажиллагааны удирдамж, одоогийн гарын авлага зэрэг нь аж үйлдвэрийн салбарт түгээмэл хэрэглэгддэггүй. Өөр нэгэн тайлбар бол эдгээр хариултуудад сайн дурын үйл ажиллагаанаас илүүтэйгээр хуулиар шаардсан зохицуулалтуудыг дагаж мөрдөх нь илүү хялбар гэдгийг дурдсан. Судалгааны оролцогчид зайлсхийх болон өөр бусад загвар арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн өөрийн улс орондоо мөн Азийн бусад улс оронд зарим загвар төслүүд, мөн үүний эсрэгээр нэн тэргүүний практикуудыг дагаж мөрдөөгүй төслүүдийн талаар сайн мэдэж байв.

Аж үйлдвэрийн салбарын оролцогчид дараах дөрвөн хариултаас бусад зэрлэг амьтныг хамгаалах загвар арга хэмжээнүүд, зэрлэг ан амьтныг хамгаалах нэн тэргүүний удирдлага,


практикийг хэрэгжүүлэхэд хүлээн авсан олон нийтийн сайшаал, дэмжлэг, шагналын (жишээ нь сонины мэдээ гэх мэт) талаар сайн мэдэхгүй байлаа.

1. Тусгай шагнал байхгүй. Гэхдээ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хөнгөвчлөх болон хяналтын арга хэмжээтэй хатуу нийцүүлсэн төсөлд зориулж зарлах Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хяналтын шагнал байдаг. Үүнд багтсан зарим арга хэмжээнүүд зэрлэг ан амьтантай уялдаа холбоотой. (төмөр замын төсөлд ажиллаж байгаа Тайландын аж үйлдвэрийн салбарынхны хариулт).
2. Үндэсний Байгаль Орчны Шийдвэр. (Бангладешийн тэтгэвэрт гарсан төрийн албан хаагчдын хариулт).
3. Хоёр оролцогч шагналын талаар мэдээлэлтэй байсан гэж хариулсан. тэдгээрийн нэг нь Энэтхэгийн, нөгөө нь Непалын оролцогч юм.

Ерөнхийдөө манай судалгаанд аж үйлдвэрийн салбар хүмүүсийн хариултаас харахад шугаман дэд бүтцийн төслүүдэд зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээ нь санхүүжүүлэгчдийн шаардсан албан шаардлагаас мөн төслийн зөвшөөрлийн үе шатанд тодорхойлсон тусгай заалтын үр дүнд бий болдог. Хөнгөвчлөх шаталсан арга хэмжээ, экологийн мэдээллийг ойлгохын ач холбогдол, экосистемийн үйл ажиллагааны талаар аж үйлдвэрийн салбарын оролцогчид тодорхой хэмжээний ойлголтой байсан. Зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээний нэн тэргүүний практик үндсэндээ сайн дүрын боловч одоогоор эдгээр арга хэмжээнүүд нь зэрлэг ан амьтныг хамгаалах компани, байгууллагад олон нийтийн сайшаал, мөнгөн бус шагналыг бий болгоогүй. Төрийн байгууллагууд болон ОУСБ нь шагнал гардуулах ёслол зохион байгуулах, мөн шилдэг төлөвлөгөө, хэрэгжилтийг урамшуулах олон нийтийн арга хэмжээг зохион байгуулах замаар зэрлэг ан амьтныг хамгаалахад чиглэсэн олон улсын стандартуудыг хэрэгжүүлэхэд аж үйлдвэрийн салбарын сонирхлыг ашиглах боломжтой.

ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУД



Төрийн бус байгууллагуудын оролцогчдын олонх нь үндэсний төвшний байгууллага (n=46), үүний дараагаар олон улсын төвшний байгууллага (n=26) гэж хариулсан. Бусад оролцогчид орон нутгийн болон бүсийн төвшинд ажиллаж байсан эсвэл судалгааны хүрээлэн, мэдээллийн лавлахуудтай нягт хамтран ажилласан гэж тодорхойлсон. Байгууллагын хэмжээ харилцан адилгүй, тухайлбал 5-аас 500 хүртэл ажилтантай гэх мэт. Ихэнх төрийн бус байгууллагуудын оролцогчид өөрийн байгууллага нь шугаман дэд бүтэцтэй холбоотой зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээний талаар ойлголтод мэргэжлийн үр чадвар, дадлага түршлагыг бий болгох зорилгоор чадавхыг бий болгох зарим арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн гэдгийг мэдэж байлаа. Чадавхыг бий болгох хамгийн түгээмэл арга зам бол одоогийн ажилтнуудыг сургах, дадлагажуулах, түүний дараагаар байгаль хамгааллын чиглэлээр дадлага түршлагатай бусад төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах явдал юм (Зураг24). Төрийн бус байгууллагуудын оролцогчдын хэлснээр тэдний байгууллага нь шаардлагатай дадлага, түршлагыг олж авахын тулд заримдаа түр зөвлөхийг хөлслөн ажиллуулдаг, төрийн бус байгууллагуудтай хамтран ажилладаг боловч зэрлэг шугаман дэд бүтцийн төсөлд ан амьтныг хамгаалах чиглэлээр ажиллахын тулд шинээр ажилтан ажиллуулдаггүй. Ойролцоогоор төрийн бус байгууллагын оролцогчдын гуравны нэг нь цэвэр хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, тэдний байгууллага нь ямар нэгэн чадавхыг бий болгоогүй гэж хариулсан.



Зураг24: Шугаман дэд бүтцийн төлөвлөгөө, төслийг шийдвэрлэх, зэрлэг ан амьтныг хамгаалах дадлага туршлагыг хөгжүүлэх зорилгоор сүүлийн үед ашигласан үр чадварыг бий болгох арга технологийн тодорхой хэлбэрүүдийг тодорхойлсон төрийн бүс байгууллагуудын зөвлөх бүлгийн оролцогчдын тоо (n=105). Бий болгоогүй=судалгаанд оролцогчийн төрийн бүс байгууллагад чадавхыг бий болгох арга, техникийг ашиглаагүй.

Төрийн бүс байгууллагын оролцогчдын зааснаар тэдний байгууллагууд нь маш олон арга замаар шугаман дэд бүтцийн төслийг хөгжүүлэх үйл ажиллагаанд оролцдог гэж заасан. Оролцооны хамгийн түгээмэл арга бол зэрлэг ан амьтныг хамгаалах чиглэлээр ерөнхий зөвлөх үйлчилгээ үзүүлэх, бүтээн байгуулалтын өмнөх шатанд зэрлэг ан амьтантай холбоотой мэдээлэл цуглуулах байлаа (25 (a)). Эдгээр арга хэмжээнүүдийн хоёр нь өөр бусад зорилгоор төрийн бүс байгууллагуудын түгээмэл хэрэгжүүлсэн үйл ажиллагаатай дүйцдэг. Төрийн бүс байгууллагууд байгууллагын одоогийн зорилт, санхүүгийн механизмын хүрээнд тохирох, зэрлэг ан амьтныг хамгаалах төслүүдэд нөлөөлөх, оролцох аргаг замуудыг эрэлхийлдэг гэж хэлж болно. Төрийн бүс байгууллагын оролцогчид зэрлэг ан амьтныг хамгаалах зорилтыг хэрэгжүүлэх, төслийн хариуцлагатай байдлыг дэмжих, СВА гэх мэт эдийн засгийн судалгаатай холбоотой үйл ажиллагаанд хамрагдсан байдаг. Зэрлэг ан амьтныг хамгаалах эдийн засаг, хуулийн шаардлага, ОУСБ-ын гэрээний стандартыг ойлгоход төрийн бүс байгууллагуудад нэмэлт сургалт шаардлагатай байж болохыг энэ нь харуулж байна.

Төрийн бүс байгууллагуудын олонхын (n=105) тодорхойлсноор төсөлд оролцоо нь заримдаа зэрлэг ан амьтны талаар илүү сайн төсөл боловсруулахад (n=40) хүргэдэг боловч хариултууд холимог (ховорхон гэж хариулсан 29, үргэлж гэж хариулсан нь 45) байна. Энэ нь төрийн бүс байгууллагууд шугаман дэд бүтцийн төсөлд зэрлэг ан амьтныг хамгаалах талаар харилцан адилгүй амжилт гаргадаг болохыг харуулж байна. Төрийн бүс байгууллагын оролцогчдын тодорхойлсноор тэдний үйл ажиллагаа яагаад сайн төсөл боловсруулахад нөлөөлж чаддаггүй тухай олон шалтгаанууд байна (25 (b)). Хамгийн түгээмэл шалтгаан бол төслийн эргэн тойронд төр засгийн байгууллага болон улс төрийн дарам шахалт нөлөөлдөг нь төрийн бүс байгууллагуудын үзэж байгаагаар төр засгийн байгууллагууд шугаман дэд бүтцийг хөгжүүлэхэд хяналт тавьдаг гэж үздэг. Гэхдээ төрийн бүс байгууллагууд хээл хахууль бол гол саад бэрхшээл гэж тусгайлан зааж хариулаагүй. Хүссэний дагуу төрийн бүс байгууллагуудын зааснаар төсвийн саад бэрхшээл бол гол бэрхшээл байсан.



25Зураг: (a) шугаман дэд бүтцийн төсөлд тэдний байгууллагын гүйцэтгэх үүрэг мөн (b) шугаман дэд бүтцийн төслийн явцад зэрлэг ан амьтныг хамгаалах үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд төрийн бус байгууллагуудын үр дүнтэй үйл ажиллагааг хязгаарлаж байгаа хүндрэл бэрхшээлүүдийн төрлийг тодорхойлсон төрийн бус байгууллагуудын бүрдүүлэгч бүлгийн оролцогчдын тоо.

Ирээдүйн чадавхыг бий болгохтой холбоотойгоор төрийн бус байгууллагын оролцогчдын хариулснаар гадаад оролцогчидтой, тухайлбал олон нийт (65 хувь), төр засгийн байгууллагууд (58 хувь), түүний дараагаар санхүүжүүлэгчидтэй (44 хувь) хамтран чадавхыг бий болгох бусад төрлийн үйл ажиллагаанууд, хамтарсан сургалт зохион байгуулах зэрэг нь хамгийн их ач холбогдолтой гэж хариулсан. Судалгааны оролцогчдын хариулснаар тэдний байгууллага нь шугаман дэд бүтцийн хамгаалалтын чиглэлээр мэдлэг чадвар, дадлага түршлагатай зөвлөх, шинэ ажилтан хөлслөн авч ажиллуулахад харьцангуй бага сонирхолтой байгаагаа илэрхийлсэн. харин үүний оронд судалгааны оролцогчид одоогийн ажилчдын мэдлэг чадвар, дадлага түршлагыг сайжруулахад илүү сонирхолтой байгаагаа илэрхийлсэн, үүнээс харахад сургалт болон мэдээллийн бааз нь ирээдүйд төрийн бус байгууллагуудын чадавхыг бий болгоход чухал нөхцөл юм.

Ерөнхийдөө шугаман дэд бүтэцтэй холбоотойгоор зэрлэг ан амьтныг хамгаалах тухай мэдлэг чадвараа дээшлүүлэх сонирхолтой байгаа боловч санхүүжилт, мэдлэг чадвараар энэ нь хязгаарлагддаг, өөр бусад зорилгоор (зэрлэг ан амьтны талаар мэдээлэл цуглуулах гэх мэт)

тэдний байгууллагын өмнө нь авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаагаар дамжуулан хувь нэмрээ оруулах чадвартай байдаг. Төрийн бус байгууллагын оролцогчид төр, засгийн газар гэх мэт бусад бүрдүүлэгч бүлэгтэй түншлэл хөгжүүлэх сонирхолтой байгаа нь харагдсан. Тэд шугаман дэд бүтцийн хөгжлийн үйл ажиллагаанд илүү идэвхтэй оролцох, мөн тэдний үйл ажиллагааны үр дүнг сайжруулах, дээшлүүлэхэд туслах сургалтыг илүүд үзэж байв.


УЛСЫН, ҮНДЭСНИЙ ТӨВШНИЙ ХЯНАЛТ

Төлөөллийн таван улсын чадавхыг үнэлэх тухайд бид WFLI-ийн хамгаалах арга хэмжээтэй холбоотой ямар асуудлууд тэдний улсын дотоодын бодлого, зохицуулалтад өвөрмөц байж болохыг илүү сайн ойлгох зорилгоор улс бүрийн бүрдүүлэгч бүлгийн хариултуудыг цуглуулсан. Мөн төлөөллийн таван улсад зэрлэг ан амьтныг хамгаалах чадавхыг бий болгох ямар боломж нөхцлүүд байгаа эсэхийг тодорхойлох, улмаар Азийн төвшний стратегийн талаар мэдээлэхийг хичээсэн.

Төлөөллийн таван улсуудад ихэнх оролцогчдын хариулснаар аж үйлдвэрийн салбартай харьцуулахад Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон төрийн бус байгууллагуудын хүрээнд мэргэжлийн өндөр үр чадвартай байна гэж хариулсан (26 (a)). Энэ нь Азийн төвшний оролцогчдыг хамруулсан бусад судалгааны дүгнэлттэй тохирч байгаа бөгөөд үүнийг дотооддоо болон бүс нутагт сургалтад нөлөөлөхөд ашиглаж болох юм. Энэтхэг, Непал болон Тайландад судалгааны оролцогчдын мэдээлснээр төр засгийн байгууллагууд нь шугаман дэд бүтцийн төсөлд зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх хангалттай чадвартай байна. Таван улсын ихэнх оролцогчид нь шугаман дэд бүтцийн төлөвлөгөө гаргагчидтай харьцуулахад санхүүжүүлэгчид илүү чадавхтай гэж хариулсан бол Тайланд улсын мэдээлснээр шугаман дэд бүтцийн төлөвлөгөө гаргагчид санхүүжүүлэгчдээс илүү чадвартай байна гэжээ. Энэхүү үр дүнгээс харахад Тайландад зэрлэг ан амьтныг хамгаалах илүү үр дүнтэй хамгаалалтыг хэрэгжүүлэхэд нөлөөлж чадах шугаман дэд бүтцийн төлөвлөгөө гаргагчдын чадавхыг хэрхэн сайжруулах талаар ойлгох боломжтой.

Бүх таван улсын оролцогчдын зааснаар төслийн төлөвлөлт, зураг төсөл, бүтээн байгуулахтай холбоотойгоор ихэвчлэн саад бэрхшээлүүд тохиолддог бөгөөд энэ нь аж үйлдвэрийн салбарын хүчин чадавх багатай давхцаж байна (26 (b)). Энэтхэгт судалгааны оролцогчид бүтээн байгуулалтын үе шатнаас илүүтэйгээр зөвшөөрлийн үе шатанд илүү их саад бэрхшээл тохиолддог, харин Непалд судалгааны оролцогчдын өгүүлснээр санхүүжилтийн үе шатанд илүү их саад бэрхшээл тулгардаг. Эцэст нь Тайландад судалгааны оролцогчдын өгүүлснээр сонголтын үе шатанд илүү их саад бэрхшээл тулгардаг.

Энэтхэг, Непал, Тайландын хувьд судалгааны оролцогчид төр засгийн байгууллага, санхүүжүүлэгчид, төлөвлөгөө гаргагчид WFLI-ийн илүү их чадавхтай гэж дүгнэсэн. Ерөнхийдөө эдгээр улс орнууд төслийн зөвшөөрөл, санхүүжилт, сонголтын үе шатанд тохиолддог саад бэрхшээлүүдийг бүртгэсэн, энэ нь бүрдүүлэгч бүлгүүдэд тэргүүлэх хандлагатай. Үүнээс харахад зэрлэг ан амьтныг хамгаалахад бүх оролцогчдод хангалттай чадвар, чадавх байхгүй мөн өндөр чадвар, чадавхаас гадна хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд тодорхой саад бэрхшээл тулгарч байгааг харуулж байна. Энэхүү хүндрэл бэрхшээл бол оролцогчдын дунд удирдлага сул байдал, бодлого зохицуулалтын хэрэгжилт сул байгаатай холбоотой байж болох юм.




26Зураг: (a) Төслийн явцад зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд ямар бүлэг хангалттай чадвартай байгаа (b) зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд тулгарч байгаа одоогийн саад бэрхшээлд илүү өртөмхий төслийн үе шатыг нэрлэхтэй холбоотой Бангладеш, Энэтхэг, Монгол, Непал, Тайланд зэрэг улс тус бүрд судалгааны үх бүлгийн оролцогчдын гишүүдийн хариулт.

Өөрийн улс оронд нь зэрлэг ан амьтныг хамгаалахад тулгарч байгаа хамгийн том бэрхшээл, асуудлын талаар асуухад улс, орнуудын оролцогчид зарим ижил төстэй зүйлсийг өгүүлсэн. тухайлбал улс төрийн эрмэлзэл дутмаг байх, мэдээлэл авах боломж сул байх зэрэг болно (27 (a)). Мэдээллийн хангалттай байдлын хувьд зэрлэг ан амьтны талаарх мэдээлэл цуглуулах, хөнгөвчлөх арга хэмжээний практик сайн байгаа боловч CBAs дутмаг байна гэж бараг бүх улс орнууд илэрхийлсэн(27 (b)). Тайландын хувьд арай онцгой ялгаатай буюу зэрлэг ан амьтныг хамгаалахтай холбоотой нэн тэргүүний практикийн талаарх мэдээлэл тайландад илүү их боломжтой байна.


Шугаман дэд бүтцийн төслийг хэрэгжүүлэхэд тусгай өөр зам, маршрутыг хөгжүүлэх, төлөвлөсөн төслийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл нь бүх улс орнуудад дутагдалтай, Бангладеш,

Энэтхэг, Непалд төслийн дэлгэрэнгүй мэдээллийг авах илүү их сонирхолтой, харин Бангладеш, Тайланд, Непал улсуудад шугаман дэд бүтцийн өөр маршрут, зам, чиглэлийн талаарх мэдээлэлд илүү их сонирхолтой байна. Монгол улсын оролцогчдын тодорхойлсноор мэдээлэл хангалтгүй, бүх төрлийн мэдээллийн дутагдалтай байдалд хамгийн бага хариултын хувь хэмжээтэй байсан. Бүх таван улсын оролцогчдын зааснаар СВА хөнгөвчлөх арга хэмжээний нэн тэргүүний практик (М), зэрлэг ан амьтны мэдээллийг цуглуулах нэн тэргүүний практик (W) зэрэгт мэдээллийн хангалтгүй байдал хамгийн өндөр төвшинд байна.

(a)




(b)



27Зураг: (a) зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд тулгарч байгаа хамгийн их саад бэрхшээлийг тодорхойлох (b) мэдээллийн хангалтгүй байдлыг тодорхойлох тухай бүх бүрдүүлэгч бүлгийн хариултыг цацраг хэлбэрийн графикт улс орон бүрээр ялган харуулсан.

Эцэст нь судалгааны оролцогчдыг өөрийн улс оронд шугаман дэд бүтцийн чиглэлээр зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээг хэрэгжилтийг сайжруулах хамгийн чухал асуудлыг тодорхойлохыг хүссэн. Тэд зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх илүү тохирох шаардлага, мөн төслийн техник-эдийн засгийн үе шатанд хамгаалах арга хэмжээний СВА-ийг хамруулах илүү дэвшилтэт шаардлага, зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд илүү их санхүүжилт хийх, олон оролцогчдыг илүү сайн удирдах (төр засгийн байгууллага, санхүүжүүлэгчид, инженер гэх мэт) зэрэгт илүү анхаарлаа хандуулсан (28).

Монгол, Тайланд, Энэтхэг улстай харьцуулахдаа Бангладеш болон Непалын оролцогчид сургалтын хэрэгцээ шаардлагыг илүү онцолсон. Энэтхэг болон Монголын оролцогчид бусад улс орнуудаас бага зэрэг илүү байдлаар хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх илүү сайн шаардлагын хэрэгцээ шаардлагын талаар мэдээлсэн. Бусад улс орнуудтай харьцуулахад Монголын оролцогчид зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээг илүү сайн хэрэгжүүлэхэд хариуцлагатай байдлыг сайжруулах шаардлагатай гэж бусад улс орнуудтай харьцуулахад бага хариулсан. Сонирхолтой нь төслийн хөгжлийн үе шатанд төрийн бүс байгууллага болон олон нийтийг илүү өргөн хүрээнд хамруулснаар зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээг сайжруулах боломжтой гэж бараг бүх улс дүгнээгүй. Төрийн бүс байгууллагууд зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд зөвлөх үйлчилгээ үзүүлэх маш чухал оролцогч учраас энэхүү гайхмаар үр дүнгийн шалтгааныг ойлгоход нэмэлт судалгаа хийх хэрэгтэй.



28Зураг: Шугаман дэд бүтцийн төслийн явцад зэрлэг ан амьтны хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хамгийн чухал хүчин зүйлийг тодорхойлохын тулд бүх бүрдүүлэгч дөрвөн бүлгээс өгсөн хариултыг улс орон бүрээр цацраг хэлбэрийн графикт харуулав.

ЗЭРЛЭГ АН АМЬТНЫГ ХАМГААЛАХ ЦААШДЫН АРГА ХЭМЖЭЭНД ЧУХАЛ ҮҮРЭГТЭЙ ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, ХУУЛИУДЫН ТАЛААРХ ДҮГНЭЛТ

БАНГЛАДЕШ

Бангладеш улс зэрлэг ан амьтныг хамгаалахад анхаарлаа хандуулж байгаа нь илүү тодорхой болж байна. Читагонгоос Кокс Базаар хүртэлх 120 км хос царигтай төмөр замыг байгуулах ажлын хүрээнд одоо бүтээн байгуулалтын ажил хийгдэж байгаа зэрлэг ан амьтанд зориулсан гарцыг багтаан оруулсан нь үүний нэг тод жишээ юм. Энэхүү хичээл чармайлт, үйл ажиллагаа бодит үр дүнд хүрснээр тухайн нутаг дэвсгэрээр дайран гардаг нэн ховордсон Азийн зааныг хамгаалахад чухал ач холбогдолтой.

Шугаман дэд бүтцийн эрчимтэй хөгжлийн улмаас Бангладешийн байгалийн өвд хүндрэлтэй байдал үүсээд байна. Зэрлэг ан амьтныг хамгаалах сайжруулсан арга хэмжээ байхгүй учраас зэрлэг ан амьтан, байгалийн нутаг дэвсгэрт үзүүлэх нөлөөлөл илүү их байж болох юм.

Бангладеш нь энэхүү төсөлд авч үзсэн бүх долоон MEAs-д гишүүнээр элссэн. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ мөн авто зам, төмөр зам, цахилгаан дамжуулах шугам зэрэг шугаман дэд бүтцийн гурван төрөлтэй холбоотой зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээг багтаан зорилгоор хууль тогтоомж, удирдамж, зөвлөмжийг багтаасан хамгаалалтын арга хэмжээнүүдийг задлан шинжилсэн. Бангладешт Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон шугаман дэд бүтцийн гурван төрөлтэй холбоотой хууль тогтоомж, зөвлөмж удирдамж аль аль нь бий.

Бангладешт засгийн газрын бүрдүүлэгч бүлгийн судалгааны ихэнх оролцогчид CBD болон CITES (25)-ийн талаар ойлголттой байсан. Рамсар (23), CMS (22), WHC (20) зэрэг нь дараагийн сайн мэдэх конвенцууд юм (**Error! Reference source not found.**).

Хүснэгт10: Олон улсын MEAs-д Бангладешийн оролцоо, мөн MEA тус бүрийн тухай ойлголтын байдал

ХҮСНЭГТ9: ОЛОН УЛСЫН MEAS-Д БАНГЛАДЕШИЙН ОРОЛЦОО, МӨН MEA ТУС БҮРИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТЫН БАЙДАЛ		
КОНВЕНЦ	ТАЛ/ТАЛ БИШ	ОЛОН ТАЛТ БАЙГАЛЬ ОРЧНЫ ГЭРЭЭНИЙ ТАЛААР ОЙЛГОЛТТОЙ ОРОЛЦОГЧДЫН ТОО
CBD	Тал	25
CITES	Тал	25
Рамсар	Тал	23
CMS	Тал	22
WHC	Тал	20
IPCC	Тал	17
ITPGRFA	Тал	13

Эдгээр MEAs-д гишүүнээр элссэн нь Бангладеш улс байгаль хамгаалах үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог, тус улсын удирдагчид шугаман дэд бүтцийн төслөөс зэрлэг ан амьтдыг хамгаалахад нэмэлт удирдамжаар хангах боломжийн илрэл юм. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд MEA-ийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд тус улсын арга замыг үндэсний хууль тогтоомж, бодлого зохицуулалтад тусгах боломжтой. Энэхүү судалгааны цар хүрээг баримт бичиг бүрдүүлэх мөн Бангладешийн үндэсний хууль тогтоомжийн механизмыг тодорхойлох зэргээр

хязгаарласан (Хүснэгт11). Энэ тохиолдолд холбоо барьсан үндэсний хууль эрх зүйн экспертээс хянан шалгасан, танилцуулсан жагсаалтыг авах боломжгүй. Гэхдээ тодорхойлсон үндсэн баримт бичгүүдэд Хөгжлийн Хууль, Байгаль Хамгааллын Хууль, Биологийн Төрөл Зүйлийн Хууль, Цаг Уурын Өөрчлөлтийн Тухайн Хууль зэрэг багтана. Цаашдын судалгаанд зэрлэг ан амьтанд илүү ээлтэй дэд бүтцийг байгуулахад тусламж дэмжлэг үзүүлэх ахиц дэвшлүүдийг санал болгох, хөгжүүлэх, WFLI-ийн хамгаалах арга хэмжээг танилцуулах эрх бүхий байгууллага, одоогийн механизм, заалт, зорилго, зорилт зэргийг тодорхойлохыг түлд эдгээр үндэсний хууль тогтоомжуудыг судлах шаардлагатай. Бангладешийн холбогдох хууль тогтоомж, бодлого зохицуулалтын талаарх зарим мэдээллийг F хавсралтаас авч болно.

Хүснэгт I I: Бангладешийн хууль тогтоомж, бодлого зохицуулалтын тоог хайлтын ангилал тус бүрээр харуулав

ХҮСНЭГТ I O: БАНГЛАДЕШИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ТООГ ХАЙЛТЫН АНГИЛАЛ ТУС БҮРЭЭР ХАРУУЛАВ	
АНГИЛАЛ	№. ТОДОРХОЙЛСОН ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН (22)
"Хөдөө аж ахуй болон хөдөөгийн хөгжил"	I
"Чадавх бий болгох"	I
"Эрчим хүч"	I
"Байгаль орчны ерөнхий"	I
"Ойн"	I
"Газар ба түүний хэвлий"	7
"Ус"	5
"Зэрлэг амьтны төрөл зүйл ба эко систем"	5

ЭНЭТХЭГ

Сүүлийн үед Энэтхэг улс зэрлэг ан амьтныг хамгаалах чиглэлээр хэд хэдэн чухал арга хэмжээг баталсан. Эдгээрт томоохон төслүүдийг хөгжүүлэхийн өмнө байгаль орчны заавал авах зөвшөөрөл авах, ойн газрын зөвшөөрлийг авах ба цуцлах ажлыг Ойн газар, Бар хамгаалах үндэсний газар (NTCA) гэх мэт бусад төрөл бүрийн оролцогч газруудаас зэрэг багтаж байна. Цаашлаад WFLI-ийн хамгаалалтын араг хэмжээнд институтийн тогтолцоо, тусгай бодлого зохицуулалтууд оролцдог. тухайлбал зэрлэг ан амьтныг хамгаалах улсын болон төв байгууллагаас шаардлагатай зөвшөөрөл авах, иргэний нийгмийн идэвхтэй оролцоо, хариуцлагатай байдлыг хангахын түлд байгаль орчны хууль тогтоомжийг хэрэгжүүлдэг байгууллагууд зэргийг нэрлэж болно. Энэтхэгийн хууль эрх зүйн систем нь Үндэсний Ногоон Шүүх болон зарим дээд шүүхийн хууль тогтоомжийн тусламжтайгаар хамгаалалтыг хэрэгжүүлдэг.

Энэтхэг бол энэхүү судалгаанд авч үзсэн бүх долоон MEAs-ийн гишүүн орон юм. БОНБУ, авто зам, төмөр зам, цахилгаан дамжуулах шугам зэрэгтэй холбоотой зэрлэг ан амьтныг хамгаалах асуудлын багтаан оруулах зорилгоор хууль тогтоомж, зөвлөмж удирдамжийн багтаасан хамгаалалтын арга хэмжээг судлах хэрэгтэй. Энэтхэгт Байгаль орчинд нөлөөлөх байдлын

үнэлгээ болон шугаман дэд бүтцийн гурван төрөл зүйлд WFLI-ийн хамгаалалтын арга хэмжээг бий болгох хууль тогтоомж, зөвлөмж удирдамжуудыг хөгжүүлсэн.

Энэтхэгт төрийн байгууллагын оролцогчдын ойлголт, ухамсарын тухайд гурваас дээш хариултыг (нийт 46) нэг ч MEA хүлээн аваагүй(Хүснэгт12). Төрийн ажилтнуудад энэ нь гайхмаар доогуур үр дүнг үзүүлсэн; харамсалтай нь судалгааны төлөвлөгөөнд оролцогчдын ойлголт дутмаг байгаа шалтгааныг үнэлэн дүгнэх тухай асуултууд байгаагүй. Төр засагт WFLI-ийн хамгаалалтын бодлого, практикийг хариуцсан ажилтнуудын бодит ухамсар, ойлголтыг тодруулахын тулд цаашид нэмэлт судалгаанууд шаардлагатай.

Хүснэгт12: MEAs-д Энэтхэгийн оролцоо болон MEAs тус бүрийн тухай ойлголтын талаарх төр, засгийн бүрдүүлэгч бүлгийн хариултын тоо

ХҮСНЭГТ 11: ЭНЭТХЭГИЙН ОРОЛЦОО БОЛОН ОЛОН УЛСЫН MEAS-ИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ		
КОНВЕНЦ	ТАЛ/ТАЛ БИШ	№. MEA-ИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТТОЙ оролцогчдын (46)
CBD	Тал	3
CITES	Тал	3
CMS	Тал	3
Рамсар	Тал	3
WHC	Тал	3
ITPGRFA	Тал	2
IPCC	Тал	1
Байхгүй	Хамаарахгүй	1

Эдгээр MEAs дахь Энэтхэгийн оролцоо нь тухайн улсын байгаль хамгааллын үйл ажиллагааны оролцоог харуулж байгаа төдийгүй шугаман дэд бүтцийн нөлөөллөөс зэрлэг ан амьтныг хамгаалах боломжийг бүрдүүлж байна. Эдгээр олон улсын үүрэг даалгавруудыг хэрэгжүүлэхийн тулд Энэтхэг улс өөрийн улсын одоогийн хууль тогтоомж, бодлого зохицуулалт, зохицуулалтын үр дүн, зохистой байдалд анхаарлаа үргэлжлүүлэн хандуулах хэрэгтэй. Энэхүү судалгааны цар хүрээ нь тус улсын үндэсний хууль эрх зүйн чухал баримт бичгүүдийг баримтжуулах, жагсаахаар хязгаарлагдана (Хүснэгт12). Тодорхойлсон үндсэн баримт бичгүүд Үндэсний Ногоон Шүүхийн Тухайн Хууль, Байгаль Хамгааллын Тухай Хууль, Биологийн Төрөл Зүйлийн Дүрэм, Зэрлэг Ан Амьтныг Хамгаалах Тухай Хууль зэрэг багтана. Ирээдүйн судалгаануудад WFLI-ийн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх тэдний чадавхтай холбоотой өвөрмөц хууль тогтоомжуудтай холбоотой механизмуудыг задлан шинжлэх, хянан шалгах хэрэгтэй. Энэтхэгийн холбогдох хууль, бодлого, зохицуулалттай холбоотой зарим мэдээллийг G хавсралтад зааж болно.

Хүснэгт13: Хайлтын ангилал тус бүрд тодорхойлсон, хянан шалгасан үндэсний хууль, бодлого, зохицуулалтын нийт тоо

ХҮСНЭГТ 12: ХАЙЛТЫН АНГИЛАЛ ТУС БҮРТ ТОДОРХОЙЛСОН, ХЯНАН ШАЛГАСАН ҮНДЭСНИЙ ХУУЛЬ, БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН НИЙТ ТОО	
АНГИЛАЛ	№. ТОДОРХОЙЛСОН ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН (22)
"Хөдөө аж ахуй болон хөдөөгийн хөгжил"	1
"Эрчим хүч"	2
"Байгаль орчны ерөнхий"	3

"Байгаль Орчны Нөлөөллийн Үнэлгээ"	1
"Ойн"	6
"Газар ба түүний хэвлий"	1
"Ус"	4
"Зэрлэг амьтны төрөл зүйл ба эко систем"	4

МОНГОЛ

Монгол улс нь янз бүрийн арга хэмжээний хүрээнд WFLI -ийн хамгаалалтыг хөгжүүлэхэд ахиц дэвшил гаргаж байна. Монгол улсын үндсэн хуульд үүнтэй холбоотой олон бодлого зохицуулалтууд багтсан. тухайлбал газар, газрын хэвлий, ой, ус, ургамал, амьтан, байгалийн баялаг нь "төрийн хамгаалалтад" байна мөн "байгалийн баялаг, байгаль орчныг хайрлан хамгаалах нь [...] иргэн бүрийн ариун үүрэг" гэж заасан. Тус улсын үндсэн хуульд мөн "Монгол улс нь нэгдэн орсон олон улсын гэрээ хэлэлцээрийн дагуу өөрийн холбогдох үүргээ шударгаар биелүүлнэ" гэж заасан. Монгол улсын нэгдэн орсон олон улсын "гэрээ хэлэлцээрүүд нь үндэсний хууль тогтоомжийг хуульчлан батлагдсаны адилаар хүчин төгөлдөр болно". Монгол улс энэхүү судалгааны бүх долоон MEAs -д нэгдэн орсон (Хүснэгт14).

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон авто зам, төмөр зам, цахилгаан дамжуулах шугамтай холбоотой зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээг хамруулах зорилгоор хууль тогтоомж, бодлого зохицуулалтыг баталсан хамгаалалтын арга хэмжээнүүдийг задлан шинжилсэн. Монгол улсад Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон шугаман дэд бүтцийн гурван төрөлд зэрлэг ан амьтныг хамгаалахад зориулсан хууль тогтоомж, бодлого зохицуулалтууд хэрэгждэг.

Монгол улсад судалгаанд оролцогчдын дунд хамгийн сайн мэдэх MEA бол CBD байсан (12). CBD-ийн дараагаар судалгааны оролцогчид WHC (9), CITES (8), CMS (8), Ramsar (8) гэсэн хариултуудыг өгсөн. (Хүснэгт15)

Хүснэгт 14: Монгол улсын MEAs дахь оролцоо, MEA тус бүрийн талаарх засгийн газрын бүрдүүлэгч бүлгээс өгсөн хариултын тоо

Хүснэгт 13: Монгол улсын MEAs дахь оролцоо болон олон улсын MEAs -ийн талаарх ойлголт		
КОНВЕНЦ	ТАЛ/ТАЛ БИШ	№. MEA-ийн талаарх оролцогчдын ойлголт (45)
CBD	Тал	12
WHC	Тал	9
CITES	Тал	8
CMS	Тал	8
Рамсар	Тал	8
IPCC	Тал	6
ITPGRFA	Тал	4
Байхгүй	Хамаарахгүй	2

Монгол улсын үндэсний хууль тогтоомж, бодлого зохицуулалтын талаар гарч байгаа ахиц дэвшил нь үндэсний арга хэмжээнүүд, бодлого зохицуулалтыг олон улсын үүрэг, амлалттай нийцүүлэх ажлыг сайжруулж байна. Энэхүү судалгааны цар хүрээ нь Монгол улс дахь

тодорхойлогдсон үндэсний хууль, эрх зүйн механизмуудын талаар баримт материал бүрдүүлэх, жагсаалт хийх ажлаар хязгаарлагдсан (Хүснэгт 14). Монгол улсын хувьд хэд хэдэн чухал баримт бичгүүд байна. үүнд: Байгаль Хамгаалах Тухай Хууль, Түүний Нэмэлтүүд, Ус, Цаг Уур, Байгаль Орчны Хяналтын Тухай Хууль, Амьтны Тухай Хууль, Биологийн Төрөл Зүйлийн Үндэсний Хөтөлбөр, Авто Замын Салбарын Хүчин чадавхыг Бэхжүүлэх Дунд Хугацааны Хөтөлбөр, Төмөр Замын Аюул Бүсийн Горим зэрэг болно. Зэрлэг ан амьтныг хамгаалах тухайд Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам (MNET) болон Зам Тээвэр, Хөгжлийн Яамны (MRTD) Хоорондох Хамтарсан Ажлын Хэсэг 2016 оны 11-р сард дахин байгуулагдсан. Төмөр замын хашаа, хашлагыг авах, зайлуулахтай холбоотой бодлого зохицуулалтын орчны үнэлгээг 2017 оны 1-р сард хийсэн. Үүнээс гадна амьтны гарц, шугаман дэд бүтцийн стандартыг 2018 онд "Талын Зам, Төмөр Замын Стандарт" нэртэйгээр хөгжүүлсэн. Нэмэлт үйл ажиллагаа, хичээл чармайлтын хүрээнд Монгол улсын байгалийн баялгийг шугаман дэд бүтцийн эрчимтэй хөгжлөөс хамгаалах арга хэмжээг сайжруулах боломжтой. Монгол улсын холбогдох хууль тогтоомж, бодлого, зохицуулалтын талаарх зарим мэдээллийг Н хавсралтаас (Хавсралт Н) үзэх боломжтой.

Хүснэгт 15: Ангилал тус бүрт тодорхойлогдсон, Монгол улсын үндэсний хууль, бодлого, зохицуулалтын тоо

ХҮСНЭГТ 14: АНГИЛАЛ ТУС БҮРТ ТОДОРХОЙЛОГДСОН, МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ ХУУЛЬ, БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ТОО	
АНГИЛАЛ	№. ТОДОРХОЙЛОГДСОН ХУУЛЬ, БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН (42)
"Хөдөө аж ахуй болон хөдөөгийн хөгжил"	1
"Биологийн төрөл зүйл"	1
"Бизнес, Аж Үйлдвэр, Корпораци"	3
"Чадавх бий болгох"	1
"Эрчим хүч"	6
"Байгаль орчны ерөнхий"	5
"Ойн"	3
"Нэгдсэн удирдлага, зохион байгуулалт"	1
"Газар ба түүний хэвлий"	4
"Газрыг ашиглах төлөвлөгөө"	1
"Ус"	6
"Зэрлэг амьтны төрөл зүйл ба эко систем"	5
"Бүсчлэл"	2
"Төмөр замууд [хяналт шалгалтын явцад тодорхойлсон]"	2
Инноваци [хяналт шалгалтын үед тодорхойлсон]	1

НЕПАЛ

Зэрлэг ан амьтны хамгаалалтыг сайжруулах чиглэлээр Непалд олон тооны санаачилгууд хэрэгжиж байна. Тэдгээрт 2021-2022 оны санхүүгийн жилд 15.34 тэр бум NPR-ийг авто замын дэд бүтцийг сайжруулах, түүний дотор Зүүнээс Баруун чиглэлийн төв замын дагуу зэрлэг ан амьтанд зориулсан гарцын байгууламжийг байгуулах зэрэг ажлууд багтсан. Непал улс 2022 он гэхэд барын тоо толгойг хоёр дахин нэмэгдүүлэх зорилт дэвшүүлсэн бөгөөд үүнд барын гол унаган нутгуудыг нь дайран гарах зам, дэд бүтцийг бууруулах шаардлагатай. Цаашлаад зэрлэг ан амьтныг хөдөлгөөнд тохиолдох саад, сөрөг нөлөөллүүдийг бууруулах, зэрлэг ан амьтан ба машины мөргөлдөөн, бусад холбогдох зөрчлийг бууруулахын тулд томоохон гол замуудад зэрлэг ан амьтанд зориулсан гарцын байгууламжийг төлөвлөх, байгуулах тодорхой хэрэгцээ шаардлагууд байна. Гэхдээ Непалын үндэсний өв нь шугаман дэд бүтцийн хөгжлийн асуудалтай холбоотойгоор нэлээд аюултай, эрсдэлтэй байдалд байсаар байна.

Тус улс нь энэхүү судалгаанд дурдсан долоон MEAs-ийн зургаад нь элсэн орсон. Непал улс бол CMS-ийн гишүүн биш юм (

Хүснэгт16).

БОНБУ, авто зам, төмөр зам, цахилгаан дамжуулах шугам зэрэгтэй холбоотой зэрлэг ан амьтныг хамгаалах асуудлын багтаан оруулах зорилгоор хууль тогтоомж, зөвлөмж удирдамжийн багтаасан хамгаалалтын арга хэмжээг судлах хэрэгтэй. Непалд БОНБУ, авто зам, цахилгаан дамжуулах шугамтай холбоотой хууль, бодлого зохицуулалтууд байсан. Төмөр замтай холбоотой хамгаалах арга хэмжээний зөвлөмж, удирдамж хөгжсөн боловч хуулийн талаар тодорхой мэдээлэл байгаагүй.

Непалд судалгааны ихэнх оролцогчид CBD-ийн (30) талаар мэдлэг ойлголттой байсан, түүний дараагаар CITES (29), Рамсар (28) удаалж байлаа.

Хүснэгт 16: Непал улс олон улсын MEAs дахь оролцоо болон MEA тус бүрийн тухай ойлголтын талаарх төр, засгийн газрын бүрдүүлэгч бүлгийн хариултын тоо.

ХҮСНЭГТ 15: НЕПАЛ УЛС ОЛОН УЛСЫН MEAS ДАХЬ ОРОЛЦОО БОЛОН ОЛОН УЛСЫН MEAS-ИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ		
КОНВЕНЦ	ТАЛ/ТАЛ БИШ	№. MEAS-ИЙН ТАЛААР ОРОЛЦОГЧИД, ХАРИУЛАГЧИДИЙН (100)
CBD	Тал	30
CITES	Тал	29
Рамсар	Тал	28
WHC	Тал	25
CMS	Тал, гишүүн биш	24
IPCC	Тал	15
ITPGRFA	Тал	14

Хэдийгээр CMS-д гишүүн биш боловч Непал улс олон улсын гэрээнүүд дахь оролцоо нь тухайн улсын байгаль хамгааллын хичээл чармайлтыг хэрэгжүүлэх үндэс болдог, мөн шугаман дэд бүтцийн нөлөөллөөс зэрлэг ан амьтныг илүү сайн хамгаалах боломж болдог. CMS-ийг нэгтгэх нь Непалын WFLI-ийн хамгаалах арга хэмжээний чадавхыг цаашид сайжруулах ирээдүйн боломж юм.

Энэхүү судалгааны хамрах хүрээ нь Непалын үндэсний хууль, эрх зүйн механизмуудыг бүртгэх, жагсаах, мөн мэдээллийн нарийвчлалтай байдлыг хянан шалгах аар хязгаарлагдсан. Үр дүнг 16-р хүснэгтэд нэгтгэн харуулав. Энэхүү төслийн зорилгоор хянан шалгасан Непалын бүх хууль, бодлого, зохицуулалтуудыг Англи хэлээр олох боломжтой бөгөөд эдгээр нь Цахилгааны Тухай Хууль, Байгаль Орчныг Хамгаалах Тухай Хууль, Ойн Тухай Хууль, Газрын Тухай Хууль, Усны Нөөцийн Тухай Хууль, Үндэсний Цогцолборт Газар, Зэрлэг Ан Амьтныг Хамгаалах Тухай Хууль зэрэг багтана. Дараа дараагийн судалгаанд WFLI хамгааллын хүчин чадавхтай холбоотой хууль тогтоомжийн заалтуудыг хянан шалгах, дүн шинжилгээ хийх боломжтой. холбогдох хууль, бодлого, зохицуулалттай холбоотой мэдээллийг Хавсралт I-аас үзэх боломжтой.

Хүснэгт 17: Непалын үндэсний хууль, бодлого, зохицуулалтын нийт тоог хайлтын ангилал тус бүрээр харуулав

ХҮСНЭГТ 16: НЕПАЛЫН ҮНДЭСНИЙ ХУУЛЬ, БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН НИЙТ ТООГ ХАЙЛТЫН АНГИЛАЛ ТУС БҮРЭЭР ХАРУУЛАВ	
АНГИЛАЛ	№. ТОДОРХОЙЛСОН ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН (22)
"Хөдөө аж ахуй болон хөдөөгийн хөгжил"	4
"Эрчим хүч"	3
"Байгаль орчны ерөнхий"	2
"Байгаль орчны төлөвөлт"	1
"Байгаль Орчны Нөлөөллийн Үнэлгээ"	1
"Ойн"	3
"Газар ба түүний хэвлий"	3
"Ус"	3
"Зэрлэг амьтны төрөл зүйл ба эко систем"	2

ТАЙЛАНД

Тайланд улс сүүлийн жилүүдэд байгаль хамгаалал, зэрлэг ан амьтныг хамгаалах чиглэлээр олон чухал ахиц дэвшил гаргасан. Тухайлбал 2019 онд Зэрлэг Ан Амьтныг Хамгаалах, Хууль (WARPA Хууль) батлагдсан бөгөөд энэ нь өмнөх WARPA Хууль болон түүний дараагийн нэмэлт өөрчлөлтүүд В.Е.2535 (1992), В.Е. 2546 (2003), В.Е.2557 (2014)-ийг бүрэн орлох хууль юм. Холбогдох арга хэмжээнд ховордсон төрөл зүйл болон унаган бус, CITES-д багтсан төрөл зүйлүүдийг хамгаалах, олон тохиолдолд оногдуулах торгуулийг нэмэгдүүлэх зэрэг олон арга хэмжээнүүд багтсан. Тус улс нь зэрлэг ан амьтны хууль бус ан агнуурт маш их торгууль оногдуулдаг бөгөөд энэ нь зэрлэг ан амьтны хууль бус гэмт хэргийг бууруулах зорилготой. Тус улсын хэмжээнд бусад WFLI-ийн хамгааллын олон арга хэмжээ, хичээл чармайлтыг хэрэгжүүлж байна. Тухайлбал НҮБ-ийн Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Байгууллагын (UNESCO) Дэлхийн Өвд бүртгэгдсэн Dong Phrayayen-Khao Yai Ойн Цогцолборыг дайран гардаг 304-р төв замын дээгүүр зэрлэг ан амьтанд зориулсан гүүрэн гарц байгуулах ажил багтсан. Гэхдээ зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээг сайжруулахгүйгээр шугаман дэд бүтцийн одоогийн болон цаашдын өргөтгөл нь зэрлэг ан амьтан, түүний нутаг дэвсгэрт цаашид нөлөө үзүүлж болзошгүй юм.

Тайланд улс бол энэхүү судалгаанд багтсан долоон MEAs-ийн зургаад нь гишүүнээр элссэн. Непалын адилаар тус улс CMS-ээс бусад бүх MEAs-д гишүүнээр элссэн (Хүснэгт18).

БОНБУ мөн авто зам, төмөр зам, цахилгаан дамжуулах шугам зэрэг шугаман дэд бүтцийн гурван төрөлтэй холбогдуулан шугаман дэд бүтцийн хууль, бодлого зохицуулалтыг багтаасан хамгаалалтын арга хэмжээнүүдэд дүн шинжилгээ хийсэн. Тайландад БОНБУ, шугаман дэд бүтцийн гурван төрөлтэй олон хуулиуд батлагдсан. Гэхдээ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ мөн тээврийн гурван төрөл зүйлд зориулсан WFLI-ийн хамгааллын арга хэмжээний удирдамжийн талаар мэдээлэл байгаагүй.

Тайландад судалгааны ихэнх оролцогчид CITES (Хүснэгт 17)-ийн талаар ойлголттой байсан. түүний дараагаар CBD ба WHC (тус бүр 16 оролцогч) удаалсан. 14 оролцогчид Рамсарын талаар ойлголттой байсан. Харин үлдсэн олон улсын гэрээний талаар дөрвөөс цөөн оролцогчид хариулсан.

Хүснэгт18: Тайланд улс олон улсын MEAs дахь оролцоо болон MEA тус бүрийн ойлголтын талаарх төр, засгийн бүрдүүлэгч бүлгийн хариултын тоо

ХҮСНЭГТ 17: ТАЙЛАНД УЛС ОЛОН УЛСЫН MEAS ДАХЬ ОРОЛЦОО БОЛОН ОЛОН УЛСЫН MEAS-ИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТ		
КОНВЕНЦ	ТАЛ, ГИШҮҮН/ ТАЛ, ГИШҮҮН БИШ	№. ХАРИУЛТЫН (53)
CITES	Тал	17
CBD	Тал	16
WHC	Тал	16
Рамсар	Тал	14
CMS	Тал, гишүүн биш	4
IPCC	Тал	3
ITPGRFA	Тал	2
Байхгүй	Хамаарахгүй	1

Энэхүү судалгааны хамрах хүрээ нь WFLI хамгааллыг хэрэгжүүлэхэд чиглэл, удирдамж өгөх боломжтой Тайланд улсад тодорхойлогдсон үндэсний хууль эрх зүйн механизмуудыг бүртгэх, баримтжуулах, жагсаах зэргээр хязгаарлагдсан. Үүнд зэрлэг Ан Амьтныг Хамгаалах Тухай Хууль, Эрчим Хүчний Салбарын Тухай Хууль, Үндэсний Байгалийн Чанарыг Сайжруулах, Хамгаалах Тухай Хууль, Үндэсний Цогцолборт Газруудын Тухай Хууль зэрэг хууль тогтоомжууд багтана. 18-р хүснэгтийн үндсэн дээр WFLI-ийн хамгааллын хүчин чадавхад харьцангуй хязгаарлагдмал боломж харагдаж байна. Гэхдээ цаашдын судалгаанд зэрлэг ан амьтны хамгаалалтыг хэрэгжүүлэх тусгай араг хэмжээнүүдийг судлах, дүн шинжилгээ хийх хэрэгтэй. Тайландын холбогдох хууль тогтоомж, бодлого, зохицуулалтын талаарх зарим мэдээллийг J хавсралтаас үзэх боломжтой.

Хүснэгт19: Тодорхойлогдсон тайландын үндэсний хууль, бодлого, зохицуулалтын нийт тоо, хайлтын ангилал тус бүрээр

ХҮСНЭГТ 18: ТОДОРХОЙЛОГДСОН ТАЙЛАНДЫН ҮНДЭСНИЙ ХУУЛЬ, БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН НИЙТ ТОО, ХАЙЛТЫН АНГИЛАЛ ТУС БҮРЭЭР	
АНГИЛАЛ	№. ТОДОРХОЙЛОГДСОН ХУУЛЬ, БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТУУД (11)
"Хөдөө аж ахуй болон хөдөөгийн хөгжил"	1

"Эрчим хүч"	3
"Байгаль орчны ерөнхий"	1
"Ойн"	2
"Газар ба түүний хэвлий"	1
"Ус"	1
"Зэрлэг амьтны төрөл зүйл ба эко систем"	2

БАГЦ 3: ШУГАМАН ДЭД БҮТЭЦТЭЙ ХОЛБООТОЙГООР ЗЭРЛЭГ АН АМЬТНЫГ ХАМГААЛАХ ХИЛ ДАМНАСАН АРГА ХЭМЖЭЭНҮҮД: ТЭРАЙ НУМАН АРК ДЭВСГЭРТ ТУЛГАРЧ БАЙГАА СААД БЭРХШЭЭЛҮҮД ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ, ТАНИЛЦУУЛГА

Тэрай Байгалийн Нуман Төрх (TAL) бол Ямуна ба Багмати голын хооронд, Энэтхэг ба Непалын хилийг дамнан, Гималай уулын хормойг ороосон 810 километр бүс нутаг юм. Энэ нь Энэтхэгийн мужуудыг (Уттарханд, Уттар Прадеш, Бихар) Непалын 14 мужийг дамнан оршдог. Тэрай Байгалийн Нуман Төрх (TAL) бол дэлхийд алдартай тусгай хамгаалалттай газар нутаг (PAs) бөгөөд Читван Байгалийн цогцолборт газар ба Бардия Зэрлэг Амьтдыг хамгаалах газар зэрэг дөрөв нь Непалд хамаардаг, Корбетт Барын Нөөц болон Ражажи Байгалийн цогцолборт газар зэрэг нь Энэтхэгт харьяалагддаг. Нэгтгэн авч үзвэл уг тусгай хамгаалалттай газар нутаг нь 50,000км² газар нутгийг хамардаг (WWF India, 2021).

Авто зам, цахилгаан дамжуулах шугам, ирээдүйн төлөвлөгөөт төмөр замын шугамууд, бусад шугаман дээд бүтцүүд зэрэг томоохон шугаман дэд бүтцийн системүүд нь Тэрай Байгалийн Нуман Төрх(TAL) - ийг сүлжилдэн дайрч гарах учраас биологийн төрөл зүйлийн чухал нутаг дэвсгэрт нөлөөлөхөөс гадна (KBAs), мөн биологийн төрөл зүйлээр баялаг экологийн сүлжээнүүдэд уг нутаг дэвсгэрийг холбосон зэрлэг ан амьтныг коридорт нөлөөлнө. Тэрай Байгалийн Нуман Төрх(TAL)-д хил дамнасан долоон коридор тодорхойлогдсон. Заан, бар, хирс зэрэг ховор төрөл зүйлүүд бусад төрөл зүйлүүд хоёр улсын хооронд хил давж орж, гарч, байгалийн нөөц газрыг хамтран эзэмшдэг.

Хилийн хоёр талд дэд бүтцийг хөгжүүлэх асуудлуудыг хоёр улсын засгийн газрууд бүс нутгийн хөгжлийн стратеги, үндэсний аюулгүй байдлын зорилтын дагуу удирдан зохион байгуулдаг(Pulipaka et al., 2018; Sinha, 2020). Шугаман дэд бүтэц нь соёлын чухал газруудыг холбож, тэдгээрийг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулна. Янз бүрийн судалгаанаас харахад ирээдүйн авто замын хөгжил, төлөвлөгөөт төмөр замууд нь зэрлэг ан амьтанд мөн TAL дахь байгалийн унаган нутгуудад хүчтэй сөрөг нөлөө үзүүлэх шугаман дэд бүтцийн төслүүд байна.

TAL ДАХЬ WFLI-ИЙН ХАМГААЛАЛД ТУЛГАРЧ БАЙГАА СААД БЭРХШЭЭЛҮҮД

Энэтхэг болон Непал улсууд Азидаа зэрлэг ан амьтныг хамгаалах чухал нутаг дэвсгэрийг хамгаалах үйл ажиллагааг шугаман дэд бүтцийг хөгжүүлэх үйл ажиллагаатай уялдуулах зорилт тулгарч байна (Aggarwal, 2019, хавсралтын үзнэ үү). Үүнд бодлого зохицуулалт, шийдвэр гаргалт, үр дагаврыг сайжруулах зорилгоор төрийн ба төрийн бус байгууллагуудын анхаарлын өргөнөөр хамруулахыг шаарддаг. Харамсалтай нь тус хоёр улсын холбооны ба мужийн удирдлагууд, шийдвэр гаргагчид, төсөл хөгжүүлэгчид, дэмжигчид шугаман дэд бүтцийн хөгжлийн явцад экологийн асуудлуудыг чухалчлан авч үзэхгүй байна. Гэсэн хэдий ч шугаман дэд бүтцийн төслийн зүгээс TAL-ийн экологийн ач холбогдол, үнэ цэнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлыг хариуцсан тусгай яам, агентлагийн ажилтнууд байна.

TAL бол WFLI-ийн хил дамнасан арга хэмжээг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалт, хэрэгцээ шаардлага, үүрэг амлалт чухал шаардлагатай байгааг харуулах гол жишээ юм . Анхаарлаа хандуулах шаардлагатай одоогийн зарим хүндрэл бэрхшээлийн талаарх товч жагсаалтыг харуулав:

- 1) Эхлээд тусгай хамгаалалттай газар нутгуудад шугаман дэд бүтцийн түрэлт, нөлөөллийг зөвтгөсөн ажлуудыг эцэслэн зогсоох, хилийн гадна байгаа шугаман дэд бүтцийн хэсгүүдийг хөгжүүлэх. Энэхүү үйл ажиллагааны улмаас өмнө нь учирсан зардал, шугаман дэд бүтцийн төслийн гадаад хэсгүүдтэй

холбоотой үүрэг амлалтын үндсэн дээр шинэ шугаман дэд бүтцээр тусгай хамгаалалттай газар нутагт орох үндэслэлийг хөгжүүлэхэд нөлөөлсөн.

- 2) Энэтхэг, Непал улсад тусгай хамгаалалттай газар нутагт шугаман дэд бүтцийн түрэлт, нэвтрэлтийн талаар мөн TAL дахь зэрлэг ан амьтны коридоруудын талаар үндэсний бодлого шийдвэрийг хөгжүүлэх. Одоогоор хоёр орон, түүний муж, дүүргүүд тусгай удирдамжтай боловч хөнгөвчлөх үндсэн арга хэмжээ болох зайлсхийх арга хэмжээг шаардсан үндэсний хэмжээний бодлого байхгүй. Ихэнх тохиолдолд зарим шугаман дэд бүтцийн төслүүдийг хөгжүүлэхэд дарамт шахалтын улмаас WFLI-ийн сайн дурын үйл ажиллагааг хэрэгжүүлж чадахгүй байна. Холбогдох хууль тогтоомж, зохицуулалтын үндсэн дээр зайлсхийх арга хэмжээний шаардлагуудыг батлах нь хамгийн зөв алхам юм.
- 3) WFLI-ийн хамгааллын арга хэмжээнд хөрөнгө оруулалт хийхэд урт хугацааны эдийн засгийн ашгийг (алдагдал) үнэлэх зорилгоор CBAs-ийг хөгжүүлэх. Энэ нь зэрлэг ан амьтныг хамгаалах хөнгөвчлөх арга хэмжээг шугаман дэд бүтцийн зардал гэж үзэх одоогийн чиг хандлагыг арилгахад энэ нь тусална. Үүнээс гадна тулгамдсан асуудал, хүндрэлүүдийн нэг болох CBAs-ийн тодорхой нэг элемент бол эко системийн үйл ажиллагааг үнэлэн дүгнэх явдал юм (жишээ нь Ghosh et al., 2016), TAL дахь шугаман дэд бүтцийн төлөвлөгөө, төсөлтэй холбоотой хязгаарлагдмал практик гэх мэт).

TAL нь WFLI-ийн хамгаалах арга хэмжээний хүндрэл бэрхшээлийг чадавхыг бэхжүүлэх давуу тал болгон ашиглах боломжийг олгож байгаа боловч төслийн хөгжүүлэлт, хэрэгжилтийн явцад WFLI-ийн хамгаалалд тодорхой зөрчил дутагдал байсаар байна.

Үүрэг хариуцлагын төлөөллийн улмаас энэхүү зөрчил, дутагдал ихэвчлэн үүсдэг. Тухайлбал шугаман дэд бүтцийн төслийн бүхий л үйл явц нь төслийг санаачлах, техник-эдийн засгийн судалгаа, маршрутын анхны чиглэл, байгаль орчны үнэлгээ, байгаль орчны зөвшөөрөл шийдвэр, гэрээ байгуулах, төлөвлөх, бүтээн байгуулалт, хяналт зэрэг олон үе шатыг хамардаг. Үе шат бүрд янз бүрийг оролцогчид, удирдагчид удирдан зохион байгуулдаг. тухайлбал төр засгийн газрын албан хаагч, мэргэжилтнүүд, санхүүжүүлэгчид, хувийн салбарынхан, инженер, техникийн байгууллага, төлөвлөлтийн зөвлөх гэх мэт. Эдгээр үе шатууд шугаман байдлаар үргэлжлэх бөгөөд шийдвэр гаргалт, зохих хамгаалалтыг хэрэгжүүлэх оролцогчид зэрэгтэй холбоотойгоор төслийн нэг үе шатнаас нөгөө шатанд уялдаа холбоо алдагдах тохиолдол бий. Ихэнх тохиолдолд зэрлэг ан амьтны мэргэжилтнийг төслийг санаачлах, эхний үе шатнаас илүүтэйгээр төслийн төгсгөл үе шатанд илүү хамруулан оролцуулдаг. Төслийн бүхий л үе шатанд хил хамгаалах газар гэх мэт үндэсний салбар хоорондын удирдлага, зохион байгуулалтыг хөгжүүлэх нь маш чухал юм. Төслийн үе шат тус бүрийг хариуцсан үндсэн оролцогчдоос үл хамааран салбар хоорондын уялдаа холбоог хангах хэрэгтэй. Улмаар WFLI-ийн арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлэхэд туслах хэрэгтэй.

Энэтхэгт дэд бүтцийн хувийн хөрөнгө оруулалтууд цэцэглэн хөгжиж, улмаар өнгөрсөн 15 жилийн хугацаанд уналтад орсон. Хамгийн сүүлийн үеийн байдлаар Энэтхэгийн засгийн газар дэд бүтцийн хөгжилд өөрийн оролцоог нэмэгдүүлж эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар дэд бүтцийн төслүүдэд хамгийн том санхүүжүүлэгч болсон. Непалд дэд бүтцийн хөгжилд хувийн салбарын хөрөнгө оруулалт нь усан цахилгаан станцаар хязгаарлагддаг. Непалд авто зам (стратегийн чухал зам, дүүргийн, орон нутгийн), төмөр зам гэх мэт шугаман дэд бүтцийн бүх томоохон төслүүдийг Непалын засгийн газар санхүүжүүлдэг бол дунд хэмжээний гуравдагч болон орон нутгийн замуудыг мужийн, орон нутгийн захиргаа санхүүжүүлдэг (Gurung, 2005). ОУСБ-ууд нь Непалд дэд бүтцийн тусламж дэмжлэгийг эрчимжүүлж байна.

Энэтхэг болон Непалын санхүүжилтийн бүх гурван эх үүсвэр (үндэсний засгийн газар, орон нутгийн захиргаа, ОУСБ-ууд) нь WFLI-ийн хамгаалах арга хэмжээний стандартын дагуу ажилладагийн үр дүнд TAL-д эдгээр стандартуудыг мөрдөн ажилладаг.

Kelkar Хороо төвлөрсөн төвшинд чадавхыг бий болгох зорилготой тусгай байгууллага байгуулахыг зөвлөсөн. Шугаман дэд бүтцийн төлөвлөлт, төслийн зорилгоор олон нийтэд хүртээмжтэй байдлаар мэдээллээр хангах учраас тухайн байгууллага байгалийн нөөц, экологийн асуудлууд, зэрлэг амьтдын унаган нутаг, зэрлэг ан амьтны асуудлаар хүртээмжтэй мэдээллийг хангана. Цаашлаад тус хороо нь WFLI-ийн хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор бусад чухал нөөцүүдээс гадна зэрлэг ан амьтан, эко систем, зураг төсөл, төлөвлөлт, төлөвлөгөөний удирдамжийн талаарх шинжлэх ухааны мэдлэг мэдээллээр хангах мэдээллийн лавлах төв, мэдээллийн баазыг байгуулдаг(Department of Economics Affairs Ministry of

Finance, 2015). TAL нь мэдээлэл сайтай, сайтар төлөвлөсөн WFLI-ийн хамгаалах араг хэмжээг хэрэгжүүлэхэд холбогдох мэдээлэлд зориулж төвлөрсөн мэдээллийн лавлах, мэдээллийн бааз байгуулах хэрэгцээ шаардлагыг онцлон тэмдэглэсэн.

TAL дахь олон улсын хилийн хоёр талд шугаман дэд бүтцийг хөгжүүлэх одоогийн үйл ажиллагаанаас харахад шугаман дэд бүтцийн төслүүдэд байгаль орчин, зэрлэг ан амьтны тухай зөвшөөрлийг сайжруулах шаардлагатай байна. Бие даасан төслөөс илүүтэйгээр ландшафтын төвшинд шугаман дэд бүтцийн төлөвлөлт нь зэрлэг ан амьтны үнэлгээ, тэдгээрийг хамгаалах арга хэмжээг сайжруулна. Шугаман дэд бүтцийн системийг сайжруулахад үндэсний болон орон нутгийн удирдлагын үйл ажиллагааг удирдах, уялдуулах нь маш чухал шаардлагатай байна.

Энэтхэг болон Непал шийдвэр гаргах үйл ажиллагаанд олон шатлалтай, үндэсний төвшинд цөөн байгууллагууд ажилладаг, үлдсэн байгууллагууд нь муж, орон нутгийн төвшинд ажилладаг. Төвлөрсөн болон орон нутгийн төвшинд холбогдох механизм, арга хэмжээний уялдаагүй байдал нь шугаман дэд бүтцийн зүгээс зэрлэг ан амьтанд үзүүлэх нөлөөллийг шийдэхэд хүндрэлтэй байдал үүсгэдэг. Улсын чанартай замууд болон орон нутаг дахь жижиг замуудын өргөн сүлжээний нөлөөлөл нь TAL-ийн шугаман дэд бүтцийн системд ачаалал үүсгэнэ. Иймээс ерөнхий нөлөөллийг шийдвэрлэх, авч үзэхийн тулд ландшафтын төвшинд дэд бүтцийн төлөвлөгөөг гаргах хэрэгтэй.

Мужийн болон орон нутгийн удирдлагын төвшинд дэд бүтэц, байгаль хамгааллын ажилтнуудыг сургах, шугаман дэд бүтцийн төслийг хөгжүүлэх, WFLI-ийн хамгааллыг хэрэгжүүлэх үүрэгтэй ажилтнуудыг сургах, дадлагажуулах нь маш чухал ач холбогдолтой. Цаашлаад мэргэжилтэн, туршлага мэдээлэл солилцоог хөгжүүлэх шаардлагатай. Үүний үр дүнд мэргэжилтнүүд, албан хаагчид нь чадварлаг, туршлагатай техникийн мэргэжилтнүүд, зөвлөхүүдтэй хамтран ажиллаж, туршлага, мэдээллээ солих боломж бүрдэнэ. Шугаман дэд бүтцийн төлөвлөлт болон WFLI-ийн хамгааллын төлөвлөлт, хэрэгжилтэд шугаман дэд бүтэц, байгаль хамгааллын байгууллага, санхүүжүүлэгчид, инженер, тээврийн төлөвлөлтийн чадавхыг бэхжүүлэх, сайжруулах хэрэгтэй. Тус хоёр улсад төр засгийн бүхий л төвшинд хүний нөөцийн сургалт, зохицуулалт, удирдлагаар дамжуулан TAL -д чадавхыг бэхжүүлэх боломжтой.

ҮНДСЭН ОЛОЛТУУД

I. БҮРДҮҮЛЭГЧ ДӨРВӨН БҮЛГИЙН ОДООГИЙН ЧАДАВХ БОЛОН ИРЭЭДҮЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫН ТАЛААРХ ҮНДСЭН ДҮГНЭЛТҮҮД

ЗАСГИЙН ГАЗАР

- Азийн засгийн газрууд олон SDGs болон бусад олон улсын байгаль орчны гэрээ хэлэлцээрт хүлээсэн үүргээ биелүүлэхэд хичээл чармайлтаа нэгтгэхийн тулд өөрийн улсын үндэсний байгууллагууд, албадуудыг дахин зохион байгуулах боломжтой. Эдгээр хичээл чармайлтууд нь төр засгийн янз бүрийн албан хаагчдын дунд ирээдүйн үйл ажиллагаанд WFLI-ийн удирдамжийг хөгжүүлэх боломжийг олгоно.
- Судалгаанд оролцогчид нь шугаман дэд бүтцийн төслийн хөгжлийн эхний үе шатуудад үндсэн оролцогчоор төр, засгийн газрыг нэрлэсэн. Судалгааны оролцогчид төслийн хөгжлийн эхний үе шат, төлөвлөлтийн үе шатанд зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээний судалгаа, үүрэг амлалт, арга хэмжээг тодорхойлоход хүндрэлтэй байгаа тухай онцлон тэмдэглэсэн.

ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН ХҮРЭЭЛЭНГҮҮД

- Олон ОУСБ-ууд нь стандарт, зөвлөмж удирдамж зэргээр дамжуулан зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээнд хандах дотоод нөөц, чадавхтай байгаа нь тогтоогдсон. Тэд төр, засаг, аж үйлдвэрийн оролцсон арга хэмжээ гэх мэт бусад бүрдүүлэгч бүлгийн чадавх бүрдүүлэх зарим үйл ажиллагаанд тусламж дэмжлэг үзүүлсэн ч эдгээр нь төсөл бүрд харилцан адилгүй ялгаатай. ОУСБ-ууд -ууд байгаль орчны үнэлгээг (жишээлбэл, Байгаль орчны стратегийн үнэлгээ) боловсруулах гэх мэт байгаль хамгаалал, олон нийтийн үнэ цэнийг илүү сайн тусгахын тулд шугаман дэд бүтцийн хөгжүүлээ уялдуулж байгаа нь тогтоогджээ.
- Хятадын олон талт банкууд болон түүний BRI нь WFLI -ийг шийдвэрлэх чадавхыг нэмэгдүүлэх ажлыг дөнгөж эхлүүлж байна. Сүүлийн үед тэдгээр байгууллагууд санхүүжилт хүлээн авагч орнуудыг өөрсдөө бие дааж зэрлэг ан амьтныг хамгаалах болон WFLI-ийн чадавхыг бий болгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх, санхүүжүүлэхэд тусалж, тэдэнд тулгуурлан ажиллах нь түгээмэл байна.

АЖ ҮЙЛДВЭР

- Аж үйлдвэрийн бүрдүүлэгч бүлэг нь зэрлэг ан амьтныг хамгаалахын ач холбогдол, хөнгөвчлөх шат дараалалтай арга хэмжээг ашиглахын ач холбогдлыг илүү сайн ойлгодог. Гэхдээ шугаман дэд бүтцийн нөлөөллөөс зэрлэг ан амьтныг хамгаалах хөнгөвчлөх арга хэмжээг сонгох, төлөвлөхөд барилгын компаниуд болон түүний зөвлөхүүдийг бүрэн сургадаггүй.
- Хууль тогтоомж, зохицуулалтаар тухайн арга хэмжээг шаардсан тохиолдолд зэрлэг ан амьтныг хамгаалах арга хэмжээг ихэвчлэн хэрэгжүүлдэг. Сүүлийн үед шинэ санаачилгууд дутагдалтай байгаа учраас аж үйлдвэрийн зүгээс WFLI-ийн удирдамж, бусад хамгаалах арга хэмжээнүүдийг сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлэх нь сул, дутагдалтай байна.
- Азийн төвшинд авто зам, төмөр зам, цахилгаан эрчим хүч, инженерийн мэргэжлийн чиглэлээр 23 аж үйлдвэрийн холбооны веб сайтад хийсэн судалгаанаас харахад хүний

нөөцийн сургалт (танхимын ба виртуал сургалт), вебинар, хэвлэлийн мэдээлэл, бусад техникийн нөөц, бодлого зохицуулалтыг сурталчлах, WFLI-ийн чиглэлээр бага хурал, чуулган зохион байгуулах зэрэг чадавх бий болгох боломжуудын талаар мэдээлэл дутмаг эсвэл огт байхгүй байна.

ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУД

- Төрийн бус байгууллагууд төслийн хөгжлийн бүх долоон үе шатанд бүрдүүлэгч дөрвөн бүлгийн оролцоо хамгийн бага байв. Судалгаанд төрийн бус байгууллагуудын тодорхойлсноор сүүлийн үед тэд ихэнх шугаман дэд бүтцийн төслүүдийн хөгжлийн үе шатанд оролцох боломж дутмаг байдаг.
- Судалгаанд төрийн бус байгууллагуудаас бусад бүх бүрдүүлэгч бүлгүүдийн тодорхойлсноор төрийн бус байгууллагууд нь WFLI хамгааллын чадавх өндөр төвшинтэй байлаа. Энэхүү зөрүү нь ухамсар, ойлголтын ялгаатай байдлаас шалтгаалсан. Хэдийгээр төрийн бус байгууллагууд зэрлэг ан амьтныг хамгаалах экспертүүд байгаа боловч тэд шугаман дэд бүтцийн хамгаалалттай холбоотой сургалтад суух хэрэгцээ шаардлагаа илэрхийлсэн, тухайлбал биологичдод зориулсан шинэ мэдээллийн сургалт гэх мэт.
- Азийн хэмжээнд төрийн бус байгууллагын оролцогчдын 90 орчим хувь нь шугаман дэд бүтцийн хөгжүүлэлтийг зэрлэг ан амьтанд аюултай гэж дүгнэсэн бол 98 хувь (54-өөс 53 оролцогч) шугаман дэд бүтцийн хамгаалалтын талаарх мэдлэг чадвараа сайжруулах сургалтад суухыг хүсдэг гэж хариулсан.

2. БҮРДҮҮЛЭГЧ БҮЛГҮҮДИЙН ӨРГӨН ХҮРЭЭНИЙ ОРОЛЦООГ ШААРДСАН ӨРГӨН ХҮРЭЭТЭЙ ДҮГНЭЛТ

